



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХ
ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦООНЫ
ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ**

Улаанбаатар
2024

ННА 67.408

ДАА 345

Э-807



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХ ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Бодлогын судалгаа

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн: Г.Наранбаатар PhD.
Д.Оросоо

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14240
Утас: 976-76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Энэхүү судалгааны дүгнэлт, санал нь хийж гүйцэтгэсэн судлаачдын
байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр
суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9083-6-2

ӨМНӨХ ҮГ

Өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулах, мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь иргэдийн шударгаар шүүлгэх эрхийг баталгаатай эдлүүлэхэд нэн чухал үр нөлөөтэй.

Нээлттэй Нийгэм Форум Эрх зүйн хөтөлбөрийнхөө хүрээнд өмгөөлөгчдийн чадавхыг сайжруулах, тэдний мэргэжлийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох талуудад сургалт, судалгааны дэмжлэг үзүүлж ирсний нэг болох “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дах өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал” сэдэвт судалгааны ажлыг энэ удаа танилцуулж байна.

Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг, өмгөөллийн “LB Partners” ХХК-ны төлөөлөл оролцсон өргөн бүрэлдэхүүнтэй судалгааны багийг хуульч, Хууль зүйн ухааны доктор Г.Наранбаатар, хуульч, судлаач Д.Орсоо нар ахлан энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Иргэдийн шударгаар шүүлгэх эрхийн тулгамдсан асуудлын нэг болох өмгөөлөгчийн эрх үүргийн талаарх энэхүү судалгааны санал зөвлөмжийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй бодлого боловсруулах, шийдвэр гаргах албан тушаалтнууд анхааралдаа авч цаашдын үйл ажиллагаандаа тусгана гэдэгт найдаж байна.

Эрх зүйн болон засаглалын чиглэлээр бидний эрхлэн нийтэлсэн бусад судалгааны тайлантай www.forum.mn цахим хуудаснаас танилцан, түгээн дэлгэрүүлэхийг хичээнгүйлэн хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх Захирал П.Эрдэнэжаргал

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	3
ГАРЧИГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
УДИРТГАЛ.....	6
НЭГ. ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН БАТАЛГАА.....	10
1.1. Шударгаар шүүлгэх эрхийн Үндсэн хуулийн баталгаа	10
1.2. Шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулсан бусад улсын туршлага ...	15
1.3. Шударгаар шүүлгэх эрхийг олон улсын эрх зүйн баримт бичигт баталгаажуулсан нь	29
ХОЁР. ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ОРОЛЦОЖ БУЙ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	39
2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог тодорхойлсон байдал.....	39
2.2. Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, эрхийн баталгаа	44
2.3. Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд эдлэх эрхийг үндэсний хууль тогтоомжид баталгаажуулсан байдал	55
ГУРАВ. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	60
3.1. Кэйс судалгаа	61
3.2. Өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй нийтлэг асуудалд хийсэн дүн шинжилгээ	67
3.3. Эрүүгийн процесст оролцож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийн асуудал	75
ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦООНЫ АСУУДЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	83
4.1. Герман Улс.....	90
4.2. Франц Улс.....	92
4.3. АНУ	94
4.4. Англи Улс	96
4.5. ОХУ.....	97
4.6. БНСУ.....	101
4.7. Япон Улс.....	129
ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	131
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	142

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗ	Аюулгүйн зөвлөл
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХСВХХХЦЗТК	Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах цогц зарчмуудын тухай конвенц
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ГАТХ	Гүйцэтгэх ажлын тухай хууль
ЕХ	Европын Холбоо
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын пакт
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) хүний эрхийн төрөлжсөн болон олон улсын хүний эрхийн бусад байгууллагууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна. Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг мөрдөн шалгах, түүний гэм бурууг шүүн шийдвэрлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх хууль зүйн баталгаа бүрдүүлэх нь улс орнуудын хувьд хүний эрхийн төлөв байдлын чухал үзүүлэлт юм.

Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг шинээр баталсан боловч эрүүгийн процессын явцад хүний эрхийн зөрчил оршсоор байгаа тул цаашид хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “...Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх...¹ эрхтэй” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн² 1.6 дугаар зүйлийн 1-д “... Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина”, мөн зүйлийн 3-т “... шүүхийн хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын Дээд шүүхэд энэ талаар санал гаргах ба Улсын Дээд шүүх уг саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана” гэж заасан байдаг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль, хэвлэсэн ХЗҮХ, 2015.

² www.legalinfo.mn /хууль тогтоомж-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль/

Монгол Улсын хувьд эрүүгийн процесст оролцож буй өмгөөлөгчийн эрх, оролцоо хязгаарлагдмал, шүүхээс өмнөх шатны нотлох ажиллагаа нь яллах талын үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн байдгаас үүдэн иргэний шударгаар шүүгдэх эрх болон түүнтэй холбогдох өмгөөлөгчийн үйл ажиллагаа нь эрүүгийн хэргийн нотолгоог хангахад тодорхой нөлөө үзүүлж чадахгүй өнөөдрийг хүрчээ.

Манай улсын хууль, шүүхийн практикт олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх явдал хангалтгүй тул үндэсний хууль тогтоомжийг олон улсын хууль тогтоомжтой нийцүүлж уялдуулах, боловсронгуй болгох шаардлагатай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Өмгөөллийн тухай хууль шинэчлэн батлагдсанаас хойш тодорхой хугацаа өнгөрсөн ч хүний эрхийг хамгаалах талаасаа хангалтгүй, засаж сайжруулах шаардлагатай зүйл нэлээдгүй байгаа тул шинэчлэлт өөрчлөлтийг нэн даруй хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал тулгамдаад байна. Энэхүү судалгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрх, оролцоог хангах талаар холбогдох хууль тогтоомжийг шинэчлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоо сэдвээр хийгдсэн судалгаа ховор бөгөөд энэхүү судалгааны удирдагч Г.Наранбаатар нь 2018 онд энэхүү судалгааны сэдвийн хүрээнд Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалж, “Өмгөөлөл хууль зүйн туслалцаа” номыг хэвлүүлсэн нь өнөөдөр гол эх сурвалж болж байгаа бол У.Хүрэлсүх 2019 онд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах шаардлага, арга зам” сэдвээр судалгаа хийж хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан байна.

Профессор Д.Баярсайхан 2015 онд “Өмгөөлөл ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, 2012 онд “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”, Профессор Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан нар 2018 онд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсэн асуудал” сэдвээр сурах бичиг хэвлүүлсэн байдаг.

Бидний судалгаа нь тус сэдвийг шинжлэх ухааны болон онол практикийн түвшинд нарийвчлан судлах, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн анхдагч цогц судалгаа гэж үзэж болно. Түүнчлэн ЭХХША-нд оролцож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх, оролцооны талаар өнөөдрийг хүртэл баримталж ирсэн үзэл баримтлал, хандлагад өөрчлөлт авчрах шинэлэг үзэл баримтлал, онолын зарчим, хандлага, стандарт хайх зорилгоор Европын холбоо, түүний гишүүн зарим улс, мөн Солонгос, Япон зэрэг улсын ЭХХША-г харьцуулан судалж, шударгаар шүүлгэх эрхийг хангах, ЭХХША-г боловсронгуй болгох санал боловсруулахад чиглэж байгаа юм.

Өнөөдөр манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “уламжлалт” чиг хандлага хүчтэй байгаа бөгөөд энэ нь цаг үетэйгээ нийцэхгүй, практикт ихээхэн хүндрэл бэрхшээл үүсгэх шалтгаан нөхцөл болж байгаа болно. Сүүлийн жилүүдэд хүний эрхийг хангах олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн хэм хэмжээ, үзэл баримтлал, зарчмуудыг хууль тогтоомжид тусгах, мөн шүүхийн практикт хэрэглэх, хэвшүүлэх шаардлага өсөн нэмэгдэж байна. Гэвч олон улсын гэрээ, хэлэлцээрийн үзэл баримтлал, зарчмыг хууль тогтоомжид тусгах, бүтээлчээр хэрэглэх явдал дутмаг байгаа тул үүнийг даван туулахад уг судалгаа хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Судалгаанд дараах зорилтыг тавьж ажиллалаа. Үүнд:

- ЭХХША-нд оролцож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч иргэний шударгаар шүүгдэх эрхийн хэрэгжилт, үндсэн эрх, баталгаанд буюу ЭХХША-ны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
- Олон улсын гэрээ, конвенц, пактаар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах өмгөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохтой холбоотой чиг хандлагыг тодорхойлох;

- Иргэний эрхийн баталгааг хангах, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцож буй өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хараат бус байдал, эрхийн баталгаа, оролцооны үр нөлөөнд эрэл хайгуул дүн шинжилгээ хийх;
- ЭХХША-ны хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр дүгнэлт санал, зөвлөмж боловсруулах зэрэг хамаарна.
- Судалгаань тоонболончанарын судалгааныаргадтулгуурласан ба баримт бичиг, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хэлэлцүүлэг ярилцлага, харьцуулалтын болон прогнозчилох аргыг ашигласан. Судалгааны аргын хувьд ярилцлага хийх, статистик, бичиг баримт судлах, харьцуулалтын аргуудыг голлон ашигласан бөгөөд 10 судлаач, 16 өмгөөлөгч, 5 шүүгч, 6 прокурор зэрэг 37 хуульчтай чөлөөт ярилцлага хийсэн болно.

Судалгааны багийн ахлагчаар Хууль зүйн ухааны доктор (Ph.D) дэд профессор Г.Наранбаатар, зөвлөхөөр Недерландын Гааг хот дахь Олон Улсын Эрүүгийн Шүүхийн ахлах өмгөөлөгч Н.Орчлон, өмгөөлөгч Лим Тэ Сү, судлаачаар хуульч, өмгөөлөгч Д.Оросоо, Ч.Эрдэнэбат, Ш.Баасанжав, Ч.Өнөржаргал тэргүүтэй өмгөөлөгчдийн баг, судлаач С.Дэнсмаа, Г.Эрдэнэ, Yun Chanеun, судлаачаар Д.Болорчимэг, Г.Туул, Д.Болортуяа, О.Доржрагчаа, У.Төгсжаргал нар ажиллалаа.

НЭГ. ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН БАТАЛГАА

1.1. ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГАА

Үндсэн хууль бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүний эрхийн гол баталгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол чиглүүлэгч, эх сурвалж юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, түүний практик Үндсэн хуульд нийцсэн байх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, 49.1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, 52 дугаар зүйлийн 1-д “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” хэмээн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн оролцогч шүүх эрх мэдлийн үндсэн зарчим, чиг үүргийг заажээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны яллах тал болох прокурорын чиг үүргийн талаар Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1-д “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж тусгайлан заасан.

Прокурорын хяналт нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцож, төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг удирдлагын бие даасан хэлбэр юм. Энэ ажиллагааг прокуророос өөр ямар нэгэн төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх ёсгүй бөгөөд прокурорын хяналтыг гагцхүү төрийн нэрийн өмнөөс тусгай субъект хэрэгжүүлдэг.

Прокурорын хяналтын бие даасан байдал нь хуулийн биелэлтэд хяналт тавих, хуулийн шаардлагыг биелүүлэх, илэрсэн эрх зүйн зөрчлийг арилгах зэрэг үйл ажиллагааны агуулга, хэлбэрээр тодорхойлогдоно. Прокурорын хяналтын онцлог нь төрийн эрх

мэдэл хуваарилах тогтолцооны нэг салаа болох шүүх эрх мэдлийн хүрээнд хамаардаг. Өөрөөр хэлбэл шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хууль ёсоор оролцож, хуулийн дагуу үүрэг гүйцэтгэдэг Үндсэн хуулийн байгууллага юм. Прокурор бүрэн эрхээ ямар нэгэн төрийн байгууллага, албан тушаалтнаас хамаарахгүйгээр гагцхүү хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.³

Прокурор гэдэг нь “санаа тавих”, “хэрэг мөрдөх”, “хангах”, “бэхжүүлэх”, “арилгах”, “халамжлан сургах”, “хянан сахиулах”, “урьдчилан сэргийлэх” гэсэн утгыг агуулсан “Procurare” хэмээх латин үгнээс гаралтай бөгөөд XIV зууны эхээр Францад (эзэн хааны эрх ашгийг хамгаалагч гэдэг утгаар) үүссэн гэж үздэг.⁴ Прокурорын хяналтын үндэс суурь анх XIV зууны эхээр буюу 1302 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Францын IV Филипп хааны үед тавигджээ. Ихэнх эрдэмтэн, судлаачид эл өдрийг прокурорын байгууллага үүсэж бий болсон өдөр гэж үздэг.⁵ IV Филипп анх прокурорын байгууллагыг төрийн нэрийн өмнөөс буруутай этгээдийг залхаан цээрлүүлэх, яллах чиг үүрэг бүхий хааны зарлигийг биелүүлдэг төрийн механизмын нэг болгон бий болгосон нь тухайн үедээ Францад “эзэн хааны хүмүүс”⁶ хэмээн нэрлэгдэж байжээ.

XIV зуунаас өмнө Европын зарим орон эзэн хааны зарлигаар бусдыг шийтгэхдээ олон нийтийн өмнө ялладаг байсан бол XIV зуунаас хойш залхаан цээрлүүлдэг тусгай үүрэг бүхий хүмүүсийг бий болгосон нь одоогийн прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндэс болсон хэмээдэг. Тухайлбал, Испанид эзэн хааны дэргэд хааны зарлигийг зөрчсөн этгээдийг мөрдөн шалгадаг залхаан цээрлүүлэгч албан тушаалтныг бий болгосон байна.⁷

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, оролцоог үр дүнтэй болгоход хууль зүйн

³ Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, УБ., 2009, 17 дахь тал

⁴ Рохлин В.И., Прокурорский надзор и государственный контроль, СП, 2003, С.102.

⁵ Рохлин В.И., Прокурорский надзор и государственный контроль, СП, 2003, С.101.

⁶ Веретенников В.И., Очерки историй генеральной прокуратуры России доекатеринского времени, Харьков, 1915, С.29.

⁷ Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, УБ., 2009, 17 дахь тал

туслалцаа авч буй иргэний өөрийнх Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх, түүний хууль зүйн баталгаа зайлшгүй чухал юм. Хуулиар эдлэх үндсэн эрх, хууль зүйн баталгаа нь хамгаалагдаагүй этгээдэд өмгөөлөгч бүрэн хууль зүйн туслалцаа боломжгүй. Иймд өмгөөлөгчийн эрх, мэргэжлийн үйл ажиллагааны баталгааны асуудлаас өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн зохицуулалтыг хөндөх шаардлагатай.

Өмгөөлөгч нь прокуророос ялгаатай нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүний үндсэн эрх, шударгаар шүүгдэх эрхийг хамгаалах, түүнд хууль зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үүрэг хүлээдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг гол оролцогч болох өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хууль зүйн баталгаа, эрхийг прокурортой адил Монгол Улсын Үндсэн хуульд тусгайлан заагаагүй байдаг боловч хууль зүйн туслалцаа авах үндсэн эрх, өмгөөлөгчөөс мэргэжлийн туслалцаа үзүүлж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэний эрхийг баталгаажуулж өгчээ. Тухайлбал, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д “Монгол Улсын иргэн нь *“халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан цндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшигх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, хэнд боловч эрцү шүцүлт тулгаж, хүцүлэг бус, хэрцүгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, цндэслэлийг баривчлагдсан хүцү, тцүний гэр бцүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.”*”, 14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж цзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүцүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлцүлэх, өөрийн болон гэр бцүлийн гишүд, эцэг эх, цр хүцүхдийнхээ эсрэг мэдүцүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүцүхээр шүцүлгэх, хэргээ шүцүх ажиллагаанд биеэр оролцох, шүцүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүцүлэг өгөхийг шаардах, мэдүцүлэг гаргуулахаар шахалт цзүцүлэх, хүцү хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүцүхээр

нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”, 55 дугаар зүйлийн 1-д “Шүцүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.”, 2-д “Шүцүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж заасан байна. Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулиар иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой харилцааг зохицуулахаас гадна иргэн өөрийгөө өмгөөлөх эрхийг зохицуулсан байдаг онцлогтой. Өмгөөллийн тухай хуулийн⁸ 5 дугаар зүйлийн 5.1-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хүн өөрийгөө өмгөөлөх эрхтэй байна.”, 5.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол хүн өөрийгөө өмгөөлөхдөө хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх бусад хуульд зааснаас гадна энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, хуулийн 14 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээнэ.” гэж заасан. Иргэн нь хууль зүйн туслалцаа авч мэргэжлийн өмгөөлөгчийн үйлчилгээ авахаас гадна Өмгөөллийн тухай хуульд зааснаар өөрийгөө өмгөөлөх хууль зүйн баталгаатай болж, өөрийгөө өмгөөлөх үйл ажиллагаа явуулах эрхийг хуулиар зохицуулсан байна. Иймд “өмгөөллийн үйл ажиллагаа”-г 1) хүн өөрийгөө өмгөөлөх эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа, 2) өмгөөлөгчийн явуулж буй өмгөөллийн үйл ажиллагаа гэж ангилан авч үзэж болно.

Харин эдгээр эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд болон хуулийн практикт бодитой хэрэгжүүлэх асуудал чухал юм. Гэтэл зарим эрх буюу халдашгүй байх, нотлох баримтыг шалгуулах, шударгаар шүүлгэх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, иргэний хууль зүйн туслалцаа авах эрх зэрэг үндсэн эрхийн хэрэгжилт бодит байдал дээр хангалтгүй байгаа нь өнөөдөр шүүмжлэл дагуулсаар байна. Жишээ дурдвал, практикт гэмт хэрэг үйлдэгдсэний дараа тухайн иргэнийг гэмт хэрэгт холбогдуулан сэжигтэн, эсхүл яллагдагчаар татаж шалгах үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон байхад мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 31.6.4-д заасны

⁸ Өмгөөллийн тухай хууль, 2019.

дагуу сэжигтнээр мэдүүлэг авах ёстой байтал өөрийнх нь эсрэг гэрчээр мэдүүлэг авч, уг мэдүүлгийг нотлох баримтаар тооцож прокурор яллах дүгнэлт үйлдсэн тохиолдол гарч байна.⁹ НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн ахлагч Элина Штайнертегийн мэдээлснээр олон тохиолдолд цагдаа гэрчээр мэдүүлэг өгүүлэхээр дууддаг ч сэжигтэн болж хувирдаг байдал газар авсан. Цагдаагийн байгууллагад байцаалт өгөхөөр дуудагдсан иргэд олон цагаар хүлээж, хүнд сурталд өртдөг, дээр нь, цагдаа иргэнийг сэжигтэн эсхүл гэрчээр дуудаж мэдүүлэг авч байгаа эсэх нь ихэнх тохиолдолд тодорхой бус байдаг¹⁰ гэжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхтэй гэсэн баталгаа нь бодит байдал дээр хэрэгжилт тааруу байгааг харуулж буй нэг жишээ юм.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс гэрчийн мэдүүлэг авдаг, түүнийг өөрийнх нь эсрэг нотлох баримт болгож ашигладаг, худал гэрчийн мэдүүлэг өгсөн гэх зэргээр яллах буруу практик бодитой бий. Иргэн үүнийг Үндсэн хуульд нийцэхгүй гэж үзэн татгалздаг боловч мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹¹ 9.1 дугаар зүйлийн 2-т “Гэрч нь шүүгч, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй” гэсэн хуулийн заалт сануулж, улмаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэдэг. Зарим тохиолдолд гэрчийн мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй гэж тайлбарлаж өгдөг боловч мэдүүлэг өгсөн тохиолдолд энэ мэдүүлгийг нотлох баримтаар ашиглаж, буруутгах, яллах үндэслэл болгож ашиглахгүй, үнэлэхгүй, зөвхөн гэмт хэрэг гарсан эсэхийг тогтооход хэрэгтэй байгаа, мэдүүлэг өгөхгүй явж болно, харин бид хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хэмжээнд таныг яллагдагчаар татсаны дараа мэдүүлэг болоход тэр үед та гэрч биш, яллагдагчаар мэдүүлэг өгөх болохоор илүү хүндрэх юм биш үү, тэр

⁹ УДШ-ийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 322 тоот тогтоол

¹⁰ www.itoim.mn, 2022.10.14

¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.

үед оройтсон байж болно, тэгэхээр одоо мэдүүлэг өгөхөд зүгээр байж мэднэ гэх зэргээр ятгадаг. Энэ мэт хүний эрхийн зөрчлийн талаар тайлангийн дөрөвдүгээр бүлэгт тодорхой авч үзсэн болно.

1.2 ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

Үндсэн хуулийн түвшинд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэний эрхийг гадаадын зарим улс орнууд хэрхэн хамгаалж, баталгаажуулсан байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийн зарим зүйл, заалттай харьцуулан товч авч үзье:

1.2.1 ХБНГУ /Герман Улс/

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д “Хүний нэр төр, алдар хүнд халдашгүй дархан байна, үүнийг хүндэтгэх, хамгаалах нь улсын үүрэг мөн”, 3-д “ ... шүүх эрх мэдлийн байгууллага нь хүний үндсэн эрхийг хуулиар хамгаалах үүрэгтэй”, 2 дугаар зүйлийн 2-д “Хүн бүр амьд явах, халдашгүй байх эрхтэй, хүний эрх чөлөө халдашгүй байна, эдгээр эрхийг зөвхөн хуулиар хязгаарлана”¹² гэж хүний үндсэн эрхийн баталгааг хуульчилжээ.

Харин хүний халдашгүй байх эрхийг хязгаарлах асуудлаар нарийвчилсан зохицуулалтыг Герман Улсын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд зохицуулжээ. Манай Үндсэн хуулийн зохицуулалттай харьцуулж үзвэл илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан зохицуулалт гэж үзэж болохоор юм.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд:

1. Хүний халдашгүй байх эрхийг зөвхөн албан ёсны хууль болон хуульд заасан журмын дагуу хязгаарлаж болно, цагдан хоригдож байгаа хүнийг сэтгэл зүй, эсхүл бие махбодоор нь гутаан доромжилж үл болно.

¹² Хууль зүйн Үндэсний хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, УБ., 2020 он, 16 дахь тал

2. Хүний халдашгүй байх эрхийг хязгаарлах буюу хязгаарлалтыг үргэлжлүүлэх эсэхийг зөвхөн шүүгч шийдвэрлэнэ. Хэрэв ийнхүү хязгаарлах арга хэмжээ нь шүүхийн шийдвэрт үндэслээгүй бол нэн даруй шүүхийн шийдвэр гаргана. Баривчлах хугацаа дууссанаас хойш цагдаагийн байгууллага хэнийг боловч хяналтдаа байлгаж үл болно. Нарийвчилсан зүйлийг хуулиар зохицуулна.
3. Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн албадан саатуулагдаж байгаа этгээдийг баривчилснаас хойш нэг өдрийн дотор шүүгч баривчлах болсон үндэслэлийг тайлбарлаж, асуух ба тайлбар өгөх боломж олгоно. Шүүгч нэн даруй үндэслэлийг зааж баривчлах буюу суллах захирамжийг бичгээр гаргана.
4. Шүүхээс гаргасан цагдан хоригдож буй этгээдийн эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хязгаарлалтыг үргэлжлүүлэх тухай шийдвэрийн талаар түүний гэр бүлийн гишүүн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчид нэн даруй мэдэгдэнэ¹³

Монгол Улсын Үндсэн хууль¹⁴д “... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ” гэж дурдан, процессын нарийвчилсан харилцааг ЭХХШТХ-иар зохицуулсан байдаг бол Герман Улсын Үндсэн хуульд халдашгүй байх эрхийг хязгаарлаж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харилцааг нарийвчлан зохицуулсан нь ялгаатай байх бөгөөд тунхгийн шинжтэй биш, шууд хэрэгжих, процессын шинж чанартай, өндөр үр нөлөөтэй хэм хэмжээ болжээ. Тухайлбал, “Цагдан хоригдож байгаа хүнийг сэтгэл зүй, эсхүл бие махбодоор нь гутаан доромжилж үл болно.”, “Баривчлах хугацаа дууссанаас хойш цагдаагийн байгууллага хэнийг боловч хяналтдаа байлгаж үл болно”, “шүүгч баривчлах болсон үндэслэлийг тайлбарлаж, асуух ба тайлбар өгөх боломж олгоно” гэсэн Үндсэн

¹³ мөн тэнд

¹⁴ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

хуулийн хэм хэмжээ бол хүний эрхийг хамгаалах чухал баталгаа, хамгаалалт болж байна.

Герман Улсын хувьд Үндсэн хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмыг тодорхойлогч чухал эх сурвалж болдог. Ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний хувийн халдашгүй эрхийг хангах баталгааг хуульчилсан нь шууд хэрэгжих зохицуулалт болж үйлчилдэг байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглүүлэгч эх сурвалж болдгоороо онцлогтой. Жишээ нь ХБНГУ-ын Үндсэн хуулийн 101 дүгээр зүйлд: “Шударга шүүхээр шүүлгэх эрх”, 103 дугаар зүйлд “Нэг хэргийн төлөө хоёр дахин шийтгүүлэхгүй байх эрх”, 104 дүгээр зүйлд “Хүний хувийн эрх чөлөө, хувийн нууцад хууль бусаар дур мэдэн халдахгүй байх эрх” болон хувийн эрх, эрх чөлөөг хөндөх хязгаарлах үеийн хамгаалах боломж, нөхцөлийг процессын суурь зарчим болгон баталгаажуулж өгчээ.

Үндсэн хуулийн 103-104 дүгээр зүйлд нотлогдсон баримтгүй буюу шүүхийн шийдвэргүйгээр хэнийг ч эрүүгийн хэрэгт сэжиглэн буруутгаж болохгүй, хүний хувийн мэдээлэл, нууцад хууль бусаар халдах, нэвтрэхийг хориглох ба шүүхээр хамгаалуулах, шүүхэд нотлох баримтаа үнэлүүлэх зэрэг эрхийг процессын шууд зохицуулалт болгон тогтоожээ.¹⁵

1.2.2. Франц Улс

Францын Үндсэн хууль, Европын холбооны хууль тогтоомж, Хүний эрхийн конвенц зэрэгт шүүх эрх мэдлийн суурь зарчмууд, хүний халдашгүй эрхийн баталгаа, процессын хязгаарлалт, хамгаалалтыг тогтоож өгсөн байдаг. Францын Үндсэн хуулийн 66-р зүйлд “Хэний ч эрх чөлөөг дур мэдэн хасаж болохгүй. Хувийн халдашгүй эрхийг хамгаалагч шүүх эрх мэдэл нь хуулиар урьдчилан тогтоосон нөхцөлийг сахиулах цед энэ зарчмыг хүндэтгэн хангуулах ёстой” гэж заажээ.

¹⁵ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 43 дахь тал

Иргэний болон Хүний эрхийн тунхаглалын 7 дугаар зүйлд “Хуульд тусгайлан журам болон зааснаас бусад ямар ч тохиолдолд хүнийг баривчлах буюу цагдан хорих, тэрчлэн яллах ажиллагааг явуулж болохгүй”, 9 дүгээр зүйлд “Хуулиар хатуу тогтоосон нөхцөл, журмын дагуу зайлшгүй хариуцлага хүлээх нь нотлогдсоноос бусад ямар ч тохиолдолд гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэж заасан. Францын нэгдэн орсон Европын хүний эрхийн конвенцын 5 дугаар зүйлд “Хуулиар тогтоосон журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хязгаарлаж болохгүй” гэж заасны дээр хуулиар тогтоосон журам нь эрх зүйн суурь зарчмуудаар нөхцөлдсөн зайлшгүй шаардлага бүхий тодорхой үндэслэлүүдийг тусгасан байдаг.¹⁶

Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, Европын Холбооны хууль тогтоомжид заасан дараах үзэл баримтлал, зарчмуудыг удирдлага болгодог байна.¹⁷ Үүнд:

- Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах процесс нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас зааглагдсан, харьцангуй тусдаа байх;
- Эрүүгийн хэргийг нотлох ажиллагааны арга, хэлбэр нөхцөлүүдийг шүүхийн оролцоо, хяналтын дор тодорхойлж хэрэгжүүлэх;
- Гэмт хэргийн категори, ангилал тус бүрийн онцлогт тохирсон процессын журам тогтоон мөрдүүлэх;
- Шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор мэдэгдэн зарлахаас өмнө ямар ч тохиолдолд хэний ч гэм буруутайд тооцохгүй, гэмт хэрэг үйлдсэн гэж харьцахгүй байх;
- Шүүн таслах ажиллагаа нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс хараат бус, бие даасан бөгөөд хэргийг үнэн бодитойгоор тогтооход чиглэгдсэн байх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг баталгаатай хангах, эрх ашгаа хамгаалах боломж олгох;

¹⁶ мөн тэнд

¹⁷ Л.В.Головка Реформа уголовного процесса во Франций Государство и право 2001 №8. с 90-91

- Хууль болон түүнтэй уялдаж гарсан хуульчилсан актаар тогтоосон хэм хэмжээнээс гадуур ямар ч процесс ажиллагаа явуулахыг хориглох;
- Гэмт хэргийн талаарх мэдээлэл, баримт сэлтүүдийг нотлох баримт мөн эсэхийг зөвхөн шүүхийн оролцоо, хяналтан дор үнэлж тооцох,
- Яллагдсан ба ялласан, хохирсон ба хохироосон аль ч этгээдийн хувьд хууль шууд бөгөөд эрх тэгш үйлчлэх зэрэг хамаарна.

Дээр дурдсан үзэл баримтлал, зарчмаас манай улсад нутагшуулан авах шаардлагатай, тулгамдсан цөөнгүй асуудал бий. Тухайлбал, эрүүгийн хэргийг нотлох ажиллагааны арга, хэлбэр нөхцөлүүдийг шүүхийн оролцоо, хяналтын дор тодорхойлж хэрэгжүүлэх, гэмт хэргийн талаарх мэдээлэл, баримт сэлтүүдийг нотлох баримт мөн эсэхийг зөвхөн шүүхийн оролцоо, хяналтан дор үнэлж тооцох зарчим, арга, механизмыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай байна.

1.2.3. Америкийн Нэгдсэн Улс /АНУ/

АНУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудыг тодорхойлоход Үндсэн хууль, Хүний эрхийн билл, шүүхийн зарим прецедент голлох үүрэгтэйгээс гадна олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд зонхилох нөлөөтэй юм.¹⁸

АНУ-ын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр нэмэлтэд “... *Хүний хувийн орон сууц, өмч, хөрөнгө, хувийн бичиг баримтад ямар нэгэн үндэслэлгүйгээр нэвтрэн орж шалгах, эсхүл баримт, шалтгаангүйгээр шууд баривчилж болохгүй. Хүний хувийн халдашгүй эрхийг хөндөх халдах, өмч хөрөнгийг нь хураах, нэгжлэг хийх эрхийг зөвхөн албан ёсны бөгөөд тангараглаж баталгаажуулсан шүүхийн зөвшөөрлийн бичигт заасан хангалттай үндэслэлгүйгээр олгож, зөвшөөрч болохгүй*” гэж заажээ.

Харин Тавдугаар нэмэлтэд “*Хэн ч ямар нэгэн эрцүгийн хэрэгт өөрийн эсрэг мэдцүлэг өгөх ёсгүй, хэнийг ч эрх зүйн нэг хэрэг,*

¹⁸ B.Jackson. Criminal justice in America .L.A., 1984. p18

зөрчлийн төлөө хоёр удаа яллаж болохгүй. Эрх зүйн зохих ёсны зөвшөөрөгдсөн процесс ажиллагааг явуулахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хасах, өмч хөрөнгийг хураах, амь насыг бусниулахыг хориглоно” гэж дурджээ. Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлтэд “... Муж улс бүхэн эрх зүйн зохих ёсны процесс ажиллагаагүйгээр хүний амь насыг бусниулж, эрх чөлөөг нь хасаж, өмчийг нь хурааж болохгүй. Муж улсын хуульд хамрагдах ямар ч этгээдэд хуулийн эрх тэгш хамгаалалт үзүүлэхээс татгалзаж үл болно” гэж заасан байдаг.

Эдгээр хэм хэмжээ нь хүний амьдрах хувийн халдашгүй эрхээ хамгаалуулах болон хувийн өмчийн эрхэнд төрөөс процессын бус аргаар халдахыг хатуу хориглосон агуулгыг илэрхийлдэг. Ер нь Америкийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэг үйлдсэн болохыг нь процессын арга хэрэгслээр урьдчилан шалгаж, шүүхийн зөвшөөрлөөр заавал дамжуулж байж, тухайн сэжиглэгдэж буй хүний эрхийг хязгаарлах зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хэргийг үйлдэл дээр нь баривчилснаас бусад ямар ч тохиолдолд сэжигтнийг таамаг, сэжгээр хорьж, мөрдөхгүй бөгөөд зөвхөн баттай нотлох баримтад тулгуурлаж, процесс ажиллагаа явуулсны үр дүнд л эрхийг нь хязгаарлах, баривчлах, цагдан хорих арга хэмжээ авдаг.¹⁹

Баривчлах болон цагдан хорьж албадан саатуулах, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөн мөшгөх болон албадлага хэрэглэх үед хүний эрхийг хангахад чиглэгдсэн дараах голлох прецедент үйлчилнэ. Үүнд:

1. Miranda v. Arizona 384 US 436 (1966):

Баривчлагдсан буюу албадан саатуулагдсан этгээд цагдаагийн тавьсан асуултад хариулахгүй байх эрхтэй. Энэ нь өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, цагдаагийн тулган хүлээлгэсэн хэргийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрхээр баталгаажсан байна.

2. Mapp v. Ohio 367US.643 (1961) :

Муж улсын хэмжээнд эрүүдэн шүүж, мөрдөн мөшгиж дарамт

¹⁹ К.Н.Гуценко Основы уголовного процесса США. М., 1993. с.10-17

шахалт үзүүлэх замаар гаргуулж авсан нотлох баримтыг хууль бус гэж үзэх ба цагдаагийн цуглуулсан хууль бус нотлох баримтыг яллагдагч, шүүгдэгчийн эсрэг болон шүүх хуралдаанд нотолгооны эх сурвалж болгон хэрэглэхгүй байхаар тогтоосон.

3. Gideon v. Wainwrigh 372 US 335 (1963)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч нь өмгөөлөгч авах эрхтэй, хүнд гэмт хэрэг үйлдэж баривчлагдсан яллагдагч, шүүгдэгч нь өмгөөлөгч хөлслөх эдийн засгийн боломжгүй бол төрийн зүгээс өмгөөлөгчөөр хангах үүргийг хүлээнэ.

4. Terry v. Ohio 392 US 1 (1968)

Цагдаагийн ажилтан ямар нэгэн нотлох баримтгүй, үндэслэл шалтгаангүйгээр сэжиг таамгаар хүний биед дур мэдэн хүрч, нотлох баримтгүйгээр баривчилж болохгүй. Түүнчлэн шүүхийн зөвшөөрөлгүйгээр хүний өмч, хөрөнгөд дур мэдэн халдаж, хурааж болохгүй.

6. United states v. Salerno, 481 US 739 (1987)

Хүнд ноцтой биш гэмт хэрэгт баривчлагдсан болон саатуулагдсан этгээдийг зохих хэмжээний барьцаагаар суллаж батлан даалтад гаргаж болох боловч онц хүнд гэмт хэрэг үйлдсэн баривчлагдсан цагдан хоригдсон этгээдийг өндөр барьцаа шаардаж, суллах буюу давхар шийтгэж болохгүй г.м²⁰

Эдгээр прецедент нь АНУ дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүний халдашгүй байх эрхийг хангахад чухал нөлөө үзүүлжээ. Өмнө дурдсан Аризона мужийн эсрэг Мирандагийн хэргийн прецедент нь манай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хангахад чухал ач холбогдолтой юм.

Мирандагийн сануулга гэдэг нь хууль сахиулагчаас аль нэгэн иргэнийг сэжиглэн баривчлах, саатуулахдаа иргэн хуулиар ямар эрх эдлэх талаар урьдчилан сануулдаг мэдэгдэл юм. Уг мэдэгдэлд тухайн иргэн нь хуулиар дуугүй байх, өмгөөлөгч авах, асуултад хариулахаас татгалзах зэрэг эрхийг танилцуулсан байдаг. Энэ хэргийг дор дэлгэрүүлэн авч үзье.

²⁰ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 85 дахь тал

1966 онд АНУ-ын Аризона мужийн Финикс хотод Эрнесто Миранда гэгчийг хүчингийн болон дээрмийн хэрэгт холбогдуулан баривчилж улмаар 2 цаг гаруй хугацаанд байцаасны үр дүнд хэргийг нь хүлээлгэн, 18 настай эмэгтэйг хүчиндсэн гэмт хэрэгт буруутган 20 жилийн ял оноосон байна.

Үүний дараагаар түүний өмгөөлөгч нь сэжигтэнд эрхийг нь сануулахгүйгээр мэдүүлэг авсан нь хууль бус гэсэн үндэслэл бүхий өргөдлийг Аризона мужийн Дээд шүүхэд гарган маргалдсан боловч шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Улмаар Миранда болон түүний хуульч нар сэжигтэнд эдлэх эрхийн талаар тайлбарлалгүйгээр мэдүүлэг авсан нь АНУ-ын Үндсэн хуулийн Тавдугаар нэмэлтэд заасан өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, Зургаадугаар нэмэлтэд заасны дагуу сэжигтний өмгөөлөгч авах эрхийг тус тус ноцтой зөрчсөн гэсэн үндэслэлүүдийг гарган тавьжээ.

Улмаар мөрдөн байцаалтын явцад авсан мэдүүлэг нь хууль бус тул тухайн мэдүүлгийг үндэслэн сэжигтнийг яллаж, буруутгаж болохгүй гэсэн үндэслэлүүдийг гарган тавьснаар өдгөө Америкийн иргэн бүр мэдэх Үндсэн хуулийн нэгэн чухал асуудлыг АНУ-ын Дээд шүүх шийдвэрлэсэн байдаг. Энэ кейс АНУ-ын Дээд шүүхийн шүүгчид, хуулийн салбарынхны дунд ихээхэн маргаан дагуулсан бөгөөд АНУ-ын Дээд шүүхийн шүүгчид 5:4 харьцаатайгаар шийдвэрлэж, Мирандагийн өмгөөлөгчийн гаргасан үндэслэлийг үндэслэлтэй буюу сэжигтэнд эрхийг нь сануулахгүйгээр байцаасан нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзсэн байдаг.

Улмаар “Мирандагийн эрх” гэсэн ойлголтыг АНУ-ын хуульд тусгаж, Мирандагийн эрхийг тусгасан Мирандагийн сануулга картыг боловсруулан хэрэглэх болжээ. Дээд шүүх шийдвэртээ гэмт хэрэг үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хэрцгий байдлаас үл хамааран мөрдөгдөж буй байцаан шийтгэх ажиллагааны үр ашгийг иргэн бүр хүртэх эрхтэйг тусгасан байна. Үндсэн хууль судлаачдын зүгээс Мирандагийн хэргээс үүдэлтэйгээр бий болсон Мирандагийн сануулга нь хувь хүн, сэжигтэнд олгож байгаа хуулийн маш том хамгаалалт гэж үздэг. Мөн Мирандагийн сануулга хуульд тусгагдсантай холбоотойгоор цагдаа, хүчний байгууллагынхан олон шатлалт сургалтад хамрагдаж, хэрхэн үр дүнтэй, алдаагүйгээр

энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон цагдаа нар сэжигтэнтэй хэрхэн харилцах талаарх цогц сургалт явуулах зэрэг олон өөрчлөлт хийхэд хүргэжээ. Үүнээс гадна ямар нэгэн баттай баримт байхгүй бол аливаа иргэнийг зогсоох, байцаах, мэдүүлэг авах зэргийг энэхүү Мирандагийн сануулгаар хязгаарласан бөгөөд АНУ-ын нийт иргэд энэхүү шүүхийн шийдвэрийн чухлыг хамгийн ихээр ойлгон мэдэж, практикт хамгийн ихээр хэрэглэгддэг кэйс болжээ.²¹

Цаашид цагдаагийн байгууллага хорих газар болон баривчилгааны үед байцаалт авахдаа хүн бүрт энэ зарчмыг танилцуулдаг болсон байна. Миранда зарчмыг шүүмжлэгчид эдгээр шинэ шаардлага нь хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хор учруулна гэж анхааруулж байсан ч биеллээ олоогүй байна. Мирандагаас хойш хийсэн судалгаанаас харахад яллах ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй аж.²²

Монгол Улсын Дээд шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 322 тоот тогтоолд²³ уг Миранда зарчмыг агуулгын хувьд тусгасан гэж үзэх үндэстэй. Уг тогтоолд мөрдөгч, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж буй прокурор нь гэмт хэргийн талаар нотолбол зохих байдлыг зөвхөн хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр шалгаж тогтоох үүрэгтэй бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн эрхийг хязгаарлах, хуульд заасан журмыг зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн баримтыг зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцох боломжгүй, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг мөрдөгч заавал сануулахаас гадна өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогчоос гэрчийн мэдүүлэг албадан авч болохгүй, гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнээс хууль сануулж өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авахыг сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлсэнд тооцно, өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг албадаж авахыг цаашид гэмт хэрэг илрүүлэх арга болгон ашиглаж болохгүйг анхааруулах нь зүйтэй гэж үзсэн байдаг.

²¹ Д.Ганчимэг, Америкийг өөрчилсөн түүхэн хэргүүд, УБ, 2021, 82 дахь тал

²² Майкл Х.Роффэр, Дэлхийн эрх зүйн түүх, УБ, 2020, 336 дахь тал

²³ <https://shuukh.mn>

УДШ-ээс хүний халдашгүй байх эрх, Миранда зарчмын агуулгыг тусгасан шийдвэрийг 2021 онд гаргаж байсан ч өнөөдрийг хүртэл мөрдөн шалгах ажиллагааны практикт дорвитой өөрчлөлт, ахиц гараагүй байгаад дүгнэлт хийх шаардлагатай, мөн уг зарчим болон УДШ-ийн шийдвэрийг сурталчлах, энэ чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах шаардлагатай байна.

1.2.4. Их Британи /Англи Улс/

Англи нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь аккусацийн системийг бүрдүүлж, хөгжүүлэхэд анхдагч түүхэн үүрэг гүйцэтгэсэн²⁴ ба Америкийн тогтолцооноос зарим талаар ялгаатай юм. Мянга шахам жилийн түүхтэй Английн шүүхийн уламжлал нь бүтэц, харьяалал, процедур болон шүүхийн соёлын олон чухал үнэт зүйлийг бүтээн, дэлхий дахинд хүргэн нөлөөлж чадсанаар бие даасан систем болтлоо төлөвшсөн ба энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нь гүнзгий шингэж тусгагдсан аж.

Шүүхийн чөлөөт мэтгэлцээн, магистратын шүүх, тангарагтан, өмгөөлөгчийн идэвхтэй оролцоо зэрэг олон зохицуулалт нь Аккусацийн системийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй хүний эрх, шударга ёс, шударга шүүхийг төлөвшүүлж хамгаалахад томоохон түлхэц үзүүлснийг үгүйсгэх аргагүй.²⁵

Английн парламентаас 1679 онд Хабеас корпус (Habeas Corpus) актыг батлан гаргасан нь хүний үндсэн эрхийг хангах, халдашгүй байх, гомдол гаргах эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Habeas Corpus (Procedure) төрийн шоронд хоригдож байгаа этгээдийг баривчилсан болон хорьж байгаа шалтгаан нь хууль ёсны эсэхийг тогтоох, хууль бус бол суллах зорилгоор уг этгээдийг

²⁴ Р.Уолкер, Английская судебная система М., 1980, с 123-125

²⁵ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015, 98, 99 дэх тал

шүүхийн өмнө авчрахаар зохицуулсан өргөдлөөр үүсэх эрх зүйн процесс юм.²⁶

Улс төр судлаач Нэйл Дуглас МакФилэй шинэ захирамж нь “шүүх хурлаа хүлээж байгаа хоригдогчийн шүүх хурлыг шуурхай явуулах, эрүүгийн яллагааны улмаас шоронд хорьсон нь хүчин төгөлдөр эсэхийг шүүхийн журмаар хянах боломжийг олгосноороо эрх чөлөөний хамгаалалтын одоогоор мэдэгдэж байгаа хамгийн үр нөлөөтэй зэвсэг болж байна” хэмээн тодорхойлжээ. Сэжигтэнд хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар өнөөг хүртэл байгаагүй хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл нь 3 хоногийн дотор ял сонгох явдал бөгөөд хэрэв хоригдогч хууль ёсны журмын дагуу эрүүгийн шүүхийн журмаар хоригдоогүй бол түүнийг даруй суллах ёстой байв. Habeas corpus акт нь АНУ-ын Үндсэн хууль баталсан Хуралдайн төлөөлөгчдөд үнэхээр чухал байсан бөгөөд бага зэрэг мэтгэлцэсний дараа санал зөрөлдөөнгүйгээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “Хэрэв зөвхөн бослого үймээн буюу гадны халдлагаас үүдэн нийгмийн аюулгүй байдалд заналхийлээгүй бол шүүхийн Habeas corpus захирамжийн давуу байдлын үйлчилгээг зогсоож болохгүй” гэж баталсан түүхтэй. Эрх зүйн түүхч Эдвард Вайт “Үндсэн хуулийг бүтээгчид шоронд байгаа хүмүүс өөрийнхөө хоригдож байгаа нь үндэслэлтэй эсэхийг маргах эрхтэйг баталгаажуулах нь зүйтэй гэдгийг маш сайн ойлгож байсан юм.” гэж тэмдэглэжээ.²⁷

1.2.5. БНСУ

БНСУ нь эрх зүй хөгжлийн хувьд эрх зүйн холимог тогтолцоог нэвтрүүлж, аль аль тогтолцооны сайн талыг авч эрх зүйн системээ хөгжүүлж байгаа болно. Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, шударгаар шүүлгэх эрх, халдашгүй байх эрхийг хангахад нотлох баримтын шалгуур, нотлох баримтад тавигдах шаардлага, баримт сэлтийг нотлох баримтад тооцох асуудал чухал нөлөөтэй байдаг.

²⁶ Х.Виктор Кондэ, Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, УБ., 2002, 63 дахь тал

²⁷ Майкл Х.Роффэр, Дэлхийн эрх зүйн түүх, УБ., 2020, 76 дахь тал

БНСУ-ын Үндсэн хуульд хууль бус нотлох баримтыг хязгаарлах буюу хориглох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрхийг хангах талаар хэд хэдэн чухал заалт орсон байдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн 12.7-д *“Яллагдагч, шүүгдэгчийн мэдцүлгийг эрүү шүүлт тулгах, хүч хэрэглэх, заналхийлэх, удаан хугацаанд хорьж, саатуулах замаар дарамтлах, хууран мэхэлж төөрөгдүүлэх зэрэг аргаар авсан нь тухайн яллагдагч, шүүгдэгчийн санаа зориг, хүсэлт биш болох нь батлагдах эсхүл шүүх хурлын үеэр дээрх байдал илэрч, тийнхүү байдалд гаргуулсан мэдүүлэг нь тухайн этгээдэд сөрөг нотлох баримт болох тохиолдолд түүний хууль ёсны гэж тооцох боломжгүй. Тэрхүү нотлох баримт нь яллах буюу ял оноох үндэслэл болохгүй.”* гэж заажээ. Дээрх заалт нь нэг талаас нотлох ажиллагаанд тавигдах эрх зүйн шалгуур, шаардлагыг тодорхой болгон өндөржүүлж өгснөөс гадна яллагдагч, сэжигтний процессын ажиллагаанд оролцох халдашгүй эрхийг нь баталгаажуулснаараа ач холбогдолтой.²⁸

Монгол Улсын Үндсэн хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэний хувьд “нотлох баримтыг шалгуулах эрх” эдлэхээр заасан байдаг бол БНСУ-ын хувьд яллагдагч, шүүгдэгч иргэний хувьд мэдүүлгийг эрүү шүүлт тулгах, хүч хэрэглэх, заналхийлэх, удаан хугацаанд хорьж, саатуулах замаар дарамтлах, хууран мэхэлж төөрөгдүүлэх зэрэг аргаар авсан нь тухайн яллагдагч, шүүгдэгчийн санаа зориг, хүсэлт биш болох нь батлагдах эсхүл шүүх хурлын үеэр дээрх байдал илэрч, тийнхүү байдалд гаргуулсан мэдүүлэг нь тухайн этгээдэд сөрөг нотлох баримт болох тохиолдолд түүний хууль ёсны гэж тооцох боломжгүй. Тэрхүү нотлох баримт нь яллах буюу ял оноох үндэслэл болохгүй гэж шууд хэрэгжих шинж чанартай байдлаар илүү нарийвчилсан процесс буюу баталгаатай эдлэх хууль зүйн хамгаалалт байдлаар хуульчилсан байгаа давуу талтай.

²⁸ Жон Хён Жү. Солонгосын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь сэжигтэн, яллагдагчийн Үндсэн хуулийн эрх, Солонгос ба Монголын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тогтолцоо: тулгамдсан асуудал ба сорилт, УБ., 2014, 21-22 дахь тал

БНСУ-ын Үндсэн хуулийн 13.3-д “*Ямар ч иргэнийг түүний гэр бүлийн гишүүн, ойр, төрөл садны хүний үйлдлээс болж гэмт хэрэгт холбогдуулан шалгахгүй*” гэж заасан байна. Сэжигтэн, яллагдагч мэдүүлэг өгөхөөс татгалзах, өмгөөлөгч авах, баривчлагдсан, саатуулагдсан үндэслэлээ дахин шалгуулах, шударгаар шүүлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх зэрэг эрхийг БНСУ-ын Үндсэн хуулийн 12-р зүйлийн 2-6-д тодорхойлж, хуульчилсан нь ЭБША-ны явцад хүний эрхийг хангах зохих түлхэц болжээ. Энэхүү эрхийн баталгаа нь шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэргийн нотлох ажиллагааг хэрэгжүүлэхэд өмгөөлөгч зохих үүрэгтэй оролцох явдлыг хангахад чухал хүчин зүйл болсон байна.²⁹

1.2.6. Япон Улс

Япон Улс нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох ажиллагааны шалгуур, зарчим, нотлох процесс, нотлох баримтад тооцох, түүнийг үнэлэх асуудалд илүү ач холбогдол өгч шинэчлэл хийсэн туршлагатай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг талаар нотлох үйл явц бөгөөд нотлох ажиллагааны зарчим, эрэмбэ нь хүний эрхийг хангахад чухал нөлөө үзүүлдэг.

Япон Улс 1946 онд шинэ Үндсэн хуулиа баталсны дараа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжоо түүнд нийцүүлж гаргах замаар гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тогтолцоог өөрчлөн шинэчлэх болсон билээ. 1948 онд Японы Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль шинээр батлагдан гарсан нь Японы Үндсэн хуулийн суурь зарчмуудыг тусгаж, нотлох ажиллагааны шалгуурыг шинэчлэн шүүхийн мэтгэлцүүлэн хэлэлцэх журмыг тогтоосноос гадна процессын оролцогчдын эрхийг зааглан хуульчилж өгснөөрөө түүхэн ач холбогдолтой. Өмнө нь үйлчилж байсан 1922 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль хэрэгжсэн түүхээс эхлээд цагдаагийн эрх мэдэл хэт өргөжиж төвлөрсөн, мөрдөн мөшгих, байцаах болон баривчлах,

²⁹ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 135 дахь тал

саатуулах ажиллагаанд эрүү шүүлтийн хүчин зүйл оршсоор ирсэн зэргийг дурдаж болно. Японы Үндсэн хуулийн 31-40 дүгээр зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүний эрхийн суурь зарчмуудыг тунхаглан баталгаажуулсан байна.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд *“Хуулиар тогтоосон процессын журмаас гадуур хэний ч эрх чөлөө, амьдрах эрхийг хасаж болохгүй.”*, 33 дугаар зүйлд *“...Газар дээрээ гэмт хэрэг үйлдэж байгаад баригдсанаас бусад ямар ч тохиолдолд шүцхийн эрх бүхий албан тушаалтны шийдвэр, тушаалгүйгээр тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр хэнийг ч баривчлах буюу албадан саатуулж болохгүй”*, 35 дугаар зүйлд *“Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан тохиолдолд нэгжлэг хийх, хураан авах цед шүцхийн шийдвэр, тушаалд тухайлан заагаагүй бол хэний ч орон сууцны халдашгүй эрх, хувийн өмчийн болон хувийн нууц бичиг баримтын халдашгүй байдалд халдахыг хориглоно”*, Үндсэн хуулийн 37 дугаар зүйлд *“Бүх төрлийн эрүүгийн хэргээр яллагдан шалгагдаж буй хэн бүхэн өөрийн хэргийг шударга шүцхээр түргэн шуурхай нээлттэйгээр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх эрхтэй”* гэж заажээ. Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд *“Хэн ч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй, үндэслэлгүйгээр удаан хугацаагаар баривчилж, цагдан хоригдсоны дараа айлган сүрдүүлэх, хэргийг албадан тулган хүлээлгэж гаргуулсан мэдүүлгийг нотлох баримт гэж үзэхгүй”*, 40 дүгээр зүйлд *“Баривчлагдаж, цагдан хоригдсон хүн, хэрэв тодорхой хугацааны дараа шүцхийн тогтоолоор хэрэг нь хэрэгсэхгүй болж, гэм буруугүй нь тогтоогдвол төрөөс хохирлоо арилгуулахаар нөхөн төлбөр гаргуулж болно”* гэсэн байна. Дээр дурдсан Үндсэн хуулийн заалтууд нь цагдаа, прокурор болон мөрдөгч нарын мөрдөн шалгах ажиллагаанд ихээхэн хамааралтай. Цагдаагийн ажилтан, мөрдөгч болон прокурор нь гэмт хэргийг илрүүлэх, хэргийн ул мөр, нотолгооны эх сурвалж бүхий баримт сэлт, мэдээллийг шалган цуглуулах, бэхжүүлэхэд хуулийн дагуу тодорхой үүрэг хүлээсэн байдаг.³⁰

³⁰ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 143 дахь тал

Японы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох баримтыг үнэлэх ажиллагааны нэг онцлог бол шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг хангахад чиглэсэн байдаг байна. Тухайлбал, Японы Дээд шүүх 1978 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 40 тоот тогтоолд *“Шүүгчийн бие даасан байр суурь, мэргэжлийн ухамсар, дотоод итгэлд сөргөөр нөлөөлөхүйц хэргийн бүх материалтай урьдчилан уншиж танилцах, гэм буруутай эсэх талаар шүүх хурлаас өмнө шүүгчид ойлголт, үнэмшил төрөх нь шүүхийн мэтгэлцэх зарчмыг хангахад харш бөгөөд түүнтэй шууд зөрчигдсөн явдал болно”* гэж тэмдэглэсэн байдаг.³¹ Шүүхийн мэтгэлцээнд өмгөөлөх, яллах талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хангах үүднээс шүүх хурлаас өмнө шүүгчийн бие даасан, хараат бус байх явдлыг бүх талаар хангах чухал гэж үздэг.

1.3 ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ БАТАЛГААЖУУЛСАН НЬ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийг хамгаалах төдийгүй хүний эрхийг хязгаарлах, халдахад хүргэх үр дагаврыг агуулдагаараа тодорхой хориглолт, зохицуулалт бүхий эрх зүйн зарчмуудыг өөртөө нөхцөлдүүлсэн байна. Эдгээр суурь зарчим нь гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л явцад заавал баримтлах ёстой нийтлэг хэм хэмжээ, үзэл баримтлал, чиг шугам мөн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим гэж нэрлэсэн нь тухайн процессын зорилго, чиг хандлагыг бүхэлд нь тодорхойлж, тэдгээрийн анхдагч, ерөнхий нөхцөл, чиг шугамыг зааж өгдөгтэй холбоотойгоос гадна ЭБША-ны бүх үйл явц, тэр тусмаа эрүүгийн хэргийн нотолгоог хэрэгжүүлэх, баривчлах, цагдан хорих болон албадлага хэрэглэх, нэгжлэг, үзлэг, шинжилгээ зэрэг хойшлуулшгүй ажиллагаа явуулахад заавал баримтлах стандарт, зарчмууд гэсэн утгыг илэрхийлнэ.³²

³¹ мөн тэнд

³² Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 8 дахь тал

НҮБ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны загвар хууль нь эрх зүйн болон танин мэдэхүйн чухал эх сурвалж болж, олон улс орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн шинэтгэлийн үйл явцад томоохон түлхэц үзүүлж байна.³³

Загвар хуульд өмгөөлөгч нь нотлох баримтуудын цагаатгах болон яллагааг үгүйсгэх баримт сэлтийг цуглуулах, нотлох ажиллагааны аль үе шатанд оролцох зэрэг нөхцөл, боломжоор хангагдсан байхаар тусгагджээ. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөлийг хангахад нотолгоог хэрэгжүүлэгч субъектийн эрх хэмжээ, үйл ажиллагаа нь давхардалгүй, хүнд сурталгүй, харилцан уялдсан, шуурхай бөгөөд тэнцвэртэй байх ёстойг тайлбарласан байна. Загвар хуулийн агуулгаас үзэхэд орчин үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоо нь аль нэг системд хамаарагдана гэхээсээ илүү, тухайн салбарт шинэчлэл хийхдээ аль алиных нь үнэт зүйлс, сонгодог өв соёлыг хослуулан зохистойгоор рецепци хийх замаар хүлээн авах нь түгээмэл хандлага болж байна.³⁴

Загвар хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг хүндэтгэх, эрх тэгш байдлыг нь зохистойгоор хангах, нотлох ажиллагаанд нээлттэй бөгөөд харилцан бие биеэ шалгах (cross examination), хэргийг мөрдөн мөшгих, эрэн сурвалжлах, гүйцэтгэх ажиллагааг явуулахад хүний наад захын халдашгүй эрхийг хангах, нотлох баримтын хүлээн зөвшөөрөхүйц байдлыг зөвхөн шүүх үнэлэх, мөрдөн шалгах ажиллагааг прокурорын яллах ажиллагаанаас ялган салгах, сэжиглэгдэн мөрдөгдөж буй ямар ч хүн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруугүйд тооцогдох, дуугүй байх, өөрийн эсрэг нотолгоог үгүйсгэн маргах эрхтэй байх, шүүх хуралдааныг мэтгэлцэх аргаар нээлттэй явуулах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны орчин үеийн суурь зарчмуудыг эрх зүйн хамгаалалтын гол нөхцөл болгон томъёолсон

³³ Model Code of Criminal procedure., Vivienne O'Conner and Colette Raush editors., W., 2008

³⁴ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 16, 24 дэх тал

байдаг. Мөн мөрдөн мөшгих, мөрдөн шалгах болон яллах ажиллагаанд шүүхийн зүгээс нотолгооны ба хуулийн хэрэглээний хяналтыг хэрэгжүүлэх, яллах ажиллагааг прокурор хэрэгжүүлж удирдан чиглүүлэх, нотлох ажиллагааны шалгуурыг нотолгооны процедурт үндэслэн хуулиар нарийвчлан заасан стандарт нөхцөлүүдийн дагуу тодорхойлох, гэмт хэргийг мөрдөн шалгах явцад оролцогчдыг мэдээллээр хангах (хохирогч, гэрч), мэдүүлэг авахад дүрс бичлэг заавал ашиглах, мэдүүлгийн маягт бөглүүлэх, асууж ярилцах, тодруулах байцаалт авах зэрэг олон аргыг хуулиар зөвшөөрөгдсөн нөхцөлөөр хэрэгжүүлэх гэх мэтээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг хандлага болгон тодорхойлсон³⁵ талаар доктор Д.Баярсайхан онцлон авч үзсэн байна.

Шударгаар шүүлгэх эрх нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд оролцох иргэний эрх, халдашгүй байх эрх нь цагдан хоригдох, саатуулагдаж буй этгээдийн мэдээлэл авах эрх, хууль зүйн туслалцаа авах эрх, хэргээ богино хугацаанд шийдвэрлүүлэх эрх, гомдол гаргах, өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа, нөхцөлөөр хангуулах эрх, байцаалтын үеийн эрхийн хамгаалалт, хүнлэг бус харьцаа, эрүү шүүлтээс ангид байх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатанд чөлөөтэй мэтгэлцэх, гэм буруу, үйл баримт дээр маргах, нотлох баримт гаргаж өгөх, шалгуулах зэрэг процессын эрх эдлэх, хэргийг шударгаар мөрдөн шалгуулах, хэлэлцүүлэх, нээлттэй шүүлгэх, гэм буруугүйд тооцогдох зэрэг эрхийг багтаадаг өргөн хүрээтэй ойлголт юм.

Хүн бүр шүүхийн өмнө тэгш эрхтэй гэх зарчим нь гадаадын иргэн ба харьяалалгүй хүнд ч адил үйлчилнэ. Хууль дээдлэх ерөнхий зарчим нь хүн бүр шүүхэд хандах тэгш боломжтой байх, шүүх аливаа хэргийн талуудад алагчлалгүй хандахыг шаардана. Энэ бол «хүний эрхийг хамгаалах гол элемент» бөгөөд хууль дээдлэх ёсыг хамгаалах процесс арга юм. Шүүхийн өмнө эрх тэгш байх эрх нь улс орнуудыг эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны шударга байдлыг гутаан бүрхэгдүүлдэг ялгаварлан гадуурхлын нийтлэг илрэлийг арилгахыг шаарддаг.

³⁵ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 20, 21 дэх тал

Шүүх, прокурор, цагдаагийн байгууллага нь үйлчилж буй олон нийтийнхээ ялгаатай байдлыг төлөөлөх, ялгаварлан гадуурхах явдлыг хэрхэн таньж илрүүлэх болон хуулийн зохицуулалтын талаар сургалтад хамрагдах шаардлагатай.

Ялгаварлан гадуурхсан шинжтэй процессын хуулийн жишээ: Эмэгтэйчүүдийн мэдүүлэгт эрэгтэйчүүдийнхээс бага ач холбогдол өгч, нотлохыг шаардах, хохирогчийн бэлгийн амьдралын түүх, биеэ авч яваа байдлыг нотлох баримт болгон хүчирхийллийн гэмт хэргийн хуулиар хэрэгт шаардлагагүй, холбогдолгүй байхад хэрэглэх, харилцан зөвшилцөөгүй гэдгийг батлахын тулд биеийн хүчирхийлэл үзүүлсэн гэдгийг нотлохыг шаардах зэрэг болно.

Хуулийг ялгавартай хэрэгжүүлж буйн жишээ: Аль нэг үндэстэн ястны бүлэгт чиглэсэн яллах ажиллагаа явуулах, өргөн хүрээтэй тогтоосон албадан саатуулж нэгжих хууль, терроризмын эсрэг хуулийг аль нэг тодорхой бүлэгт чиглэн түлхүү хэрэгжүүлэх; улс төрийн үзэл суртлаас нь болж хүнийг хэд хэдэн удаа баривчлах, хорих, садар самууны гэмт хэргийн эсрэг хуулийг ихэвчлэн эмэгтэйчүүдэд хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг мөрдөн байцаахгүй, шүүхгүй байх, эдгээр гэмт хэргийг эрүүгийн хэрэг гэхээсээ хувийн асуудал гэж үзэх; ялгаварлан гадуурхлын улмаас үйлдсэн байж болзошгүй гэмт хэрэгт энэхүү бүрэлдэхүүнийг мөрдөн шалгахгүй байх зэргийг дурдаж болно. Терроризмын эсрэг хууль нь ялгаварлан гадуурхсан шинжгүй байхыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей улс орнуудад удаа дараалан уриалсан.

Шүүхийн өмнөх шатанд эрх тэгш байх эрх гэдэг нь адил хэрэгт адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хэлнэ. Энэ нь объектив үндэслэл байгаагаас бусад тохиолдолд зарим төрлийн хэрэг эсвэл зарим бүлэг хүнд зориулсан онцгой процедур, тусгай шүүх бий болгохыг хориглодог. Яс үндэс, арьсны өнгө, хүйс хэл соёл, улс төрийн болон бусад үзэл суртал, нийгмийн болон иргэний гарал, болон үндэсний гарал, эд хөрөнгө зэрэг онцлогтой бүлэгт зориулан байгуулсан тусгай шүүх, трибунал, онцгой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хүнийг шүүх объектив болон зүй ёсны үндэслэл

байх ёсгүй. Дээрх ялгааны үндсэн дээр хүний эрхийг зөрчих нь ИУТЭОУП-ын 2(1) ба 26 дугаар зүйл гэх мэт олон улсын хэм хэмжээг зөрчиж буй явдал юм.

Зарчмын хувьд улс төрийн гэмт хэрэгт энгийн гэмт хэргээс цөөн тооны процедурын баталгаа өгөх нь шүүхийн өмнө эрх тэгш байх эрхтэй харшилдаг. Хойд Ирландад терроризмтэй холбоотой хэргийг шүүхдээ тангарагтны шүүхийг алгасах, Тунист энгийн иргэдийг илүү цөөн давж заалдах шаттай цэргийн шүүхээр шүүх зэргээр тусгай процессын журам мөрдөж байгаа нь үүний жишээ юм.

Түүнчлэн тусгай шүүхүүд (Гуантанамо булан дах АНУ цэргийн хороо) нь зөвхөн тухайн улсын харьяат бус хүмүүсийг шүүж байгаа нь ялгаварлан гадуурхлаас ангид байх эрх, хуулийн өмнө адил тэгш байх эрхийн зөрчил бөгөөд Израйлд Палестин болон Израйл хүмүүст өөр өөр эрүүгийн хууль хэрэглэдгийн улмаас адил хэрэгт илүү хүнд ял оноож, эсвэл илүү удаан хугацаагаар цагдан хорьж байгааг НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хорооноос буруутгаж байгаа юм. Зарим заншлын эрх зүйн хэрэглээ, шүүх ажиллагаа нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байдаг нь хүний эрхийн зөрчилд тооцогдоно.

Эрүүгийн хэрэг дээр шүүхээс тэгш хандана гэдэг нь яллагч болон өмгөөлөгч тал өөрийн үндэслэлийг бэлтгэхдээ адил тэгш боломжоор хангагдах буюу хүн бүрт яг ижил хандах бус объектив факт нь адил байгаа үед шүүхийн шийдвэр адил байна гэсэн үг юм. Шүүх, прокурорын шийдвэр ялгаварлан гадуурхал дээр үндэслэсэн бол тэгш байдал зөрчигдөнө.

Шүүхээс тэгш хандлага шаардах эрхийн зөрчлүүдээс дурдвал: төлбөрийн чадваргүй хүмүүст өмгөөлөгч томилохгүй байх, шаардлагатай үед чадварлаг хэлмэрчээр хангахгүй байх, аль нэг ястан, үндэстний төлөөлөл, эсвэл сэтгэл мэдрэлийн өвчтэй хүнийг хэтэрхий олноор нь хорих байр, шоронд байлгах, хүйсэд тулгуурласан хүчирхийлэлд буруутгагдсан хүмүүст хөнгөн ял өгөх, хүний эрх зөрчсөн хууль сахиулагчдад хөнгөн ял өгөх буюу ял завшуулах зэрэг болно.

Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон этгээд, хохирогч хэн бүхэн нь ялгаварлан гадуурхалгүйгээр шүүхэд хандах эрх тэгш байна. Энэхүү эрхийг хүндэтгэх үүргийн дагуу улс орнууд нь шүүхүүдийг байгуулан, зохих нөөцөөр хангаж, тэднийг шударга шүүх ажиллагаа явуулах боломжоор хангах ёстой. Шүүхүүд нь улс орны бүх нутаг дэвсгэрт хүмүүст ойр байрлалтай байх ба хөгжлийн бэрхшээлтэй хүн биечлэн очиж болохоор байна.

Хүн өөрийн эрхээ хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэйгээр оролцох, хэлэлцүүлэх, шүүхийн хамгаалалтын тусламжтайгаар шударга үнэнд хүрэх эсэх нь хууль зүйн туслалцаа хэр хүртээмжтэй байгаагаас шалтгаална. Улс орнууд эрүүгийн хэргийн мөрдөн байцаах ажиллагаа, шүүхийн ажиллагаа, давж заалдах шатанд үр нөлөөтэй хууль зүйн туслалцаагаар хангах ёстой ба энэ нь цаазаар авах ялтай хэргийн үед ч үндсэн хуулийн эрх нь зөрчигдсөн бол гомдол гаргаж, шийдвэрлүүлэх боломжийг агуулах ёстой. Шүүхэд түргэн шуурхай, үр нөлөөтэй хандах эрх нь хүн бүр эрх зүйн этгээд байх эрхийг хүндэтгэхтэй холбоотой бөгөөд хүчээр сураггүй алга болгох гэх мэтээр хүмүүсийг хуулийн хамгаалалтаас гаргах нь энэ эрх зөрчигдөж байгаа хэлбэр юм. Тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс, эсхүл тухайн улсын шүүхийн харьяалалд байгаа хүмүүс нь эрх зүйн байдлаасаа үл шалтгаалан тус улсын иргэдийн адил шүүхэд хандах тэгш эрхтэй байх ёстой.

Эмэгтэй, эрэгтэй хүн шүүхэд хандах адил эрхтэй. Зарим улсад эмэгтэйчүүдийн шүүхэд хандах эрх нь хуулийн зохицуулалт, эсвэл түүний хууль зүйн туслалцаа авах боломж муу, шүүхээр эрхээ хамгаалуулах чадвар сул, хязгаарлагдмал байдаг. Өөрөөр хэлбэл тэдний өгсөн гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт нь эрэгтэйчүүдийнхээс дутуу үнэлэгдэж, хүндлэгддэг, ач холбогдол багатайд тооцогддог аж.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей нь хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болсон бүх эмэгтэйчүүдэд үр нөлөө бүхий хууль зүйн туслалцааг хүртээмжтэй байлгаж, шүүн таслах ажиллагааны талаар мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломж олгодог болохыг

улс орнуудад уриалсан байна. Олон улсын эрх зүйн дагуу шүүхэд хандахад гарах бэрхшээлүүдийн тоонд дайны гэмт хэрэг, төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг зэрэг олон улсын эрх зүйгээр тодорхойлсон бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл, уучлал үзүүлэх, халдашгүй дархан эрх олгох гэх мэтээр түүнийг яллахаас хамгаалж буй явдал юм. Иймэрхүү хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох нь олон улсын хэм хэмжээнд нийцдэггүй.

Хүний шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт дээр тулгарч байгаа гол асуудал бол хэргийн зүйлчлэлийг зөв тогтоосон эсэхтэй холбоотой асуудал байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж шүүхийн шатанд гэм буруугийн хурал дээр хэргийн зүйлчлэлийг буруу тогтоосон тохиолдол гардаг.

Гэтэл хэргийн зүйлчлэлийг оновчтой тогтоох нь гэмт хэрэгтэнд оноох эрүүгийн хариуцлагыг шударга тогтооход чухал ач холбогдолтой. Үйлчлүүлэгчийн гэм бурууг тогтооход маргаантай асуудлууд дээр өмгөөлөгч мэтгэлцэж оролцоход шүүхээс ял хариуцлагыг хөнгөрүүлэхгүй ялаас чөлөөлөхгүй албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх тохиолдлууд практикт элбэг гарч байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах яллах дүгнэлт үйлдэхэд хэргийн зүйлчлэлийг буруу тогтоосон байх тохиолдолд их гардаг. Энэ тохиолдолд өмгөөлөгчид шүүхийн мэтгэлцэх үе шатанд хэргийн зүйлчлэлтэй холбоотой маргахад хэргийн шүүх бүрэлдэхүүн болон даргалагч шүүгч нь гэм буруу дээр маргалдсан мэтээр дүгнэж хэргийг хянан шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй гарч байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон оролцогчтой хэрэг дээрх шүүхийн өмнөх болон шүүхийн шатан дахь хэрэгт шүүхийн захиргааны ажилтнуудын зохион байгуулалт болон хэрэгт тавьж байгаа хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Гэтэл олон оролцогчтой хэрэг дээр зарим оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эх хуваарь нь гаргаж өгсөн нотлох баримт хэрэгт хавсаргаагүй, эсхүл хавтаст хэргийн хаана хавсаргагдсан эсэх нь мэдэгдэхгүй байх зөрчлүүд элбэг байна.

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.3-д заасан шүүгчийг татгалзан гаргах асуудал чухлаар тавигдана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Ерөнхий шүүгчид зарим үед хэрэг хуваарилагдан ганцаарчлан шийдвэрлэхээр даргалагч шүүгчээр томилогддог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 болон 10.2-д заасан үндэслэлүүдээр татгалзахад шүүгч нь өөрөө шүүхийн Ерөнхий шүүгч тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4-ийн 5-д “... татгалзсан бол уг асуудлыг шүүх хуралдаан даргалагч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.”, мөн зүйлийн 7-д “Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх шүүгчдийн зөвлөгөөнд Ерөнхий шүүгч уг асуудлын талаар тайлбар гаргаж болох...” гэж заасны дагуу Ерөнхий шүүгч татгалзах үндэслэлгүй гэсэн тайлбар гаргаж өөрөө дахин шүүх хуралдаанд орж байна.³⁶

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний шударгаар шүүгдэх эрхийг хангасан байх ёстой бөгөөд хүний шударгаар шүүгдэх эрхийг шүүхийн ажиллагааны өмнөх үеийн эрх, шүүх ажиллагааны үеийн эрх³⁷ гэж хуваан авч үздэг. Үүнд:

Шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэний шударгаар шүүгдэх эрхийн хүрээнд:

1. Халдашгүй байх эрх;
2. Аливаа хэлбэрээр саатуулагдаж буй хүний мэдээлэл авах эрх;
3. Хууль зүйн туслалцаа авах эрх;
4. Хоригдож буй хүний гадаад ертөнцтэй холбоотой байх эрх;
5. Аль болох богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх;
6. Цагдан хорих арга хэмжээ хууль ёсны эсэх талаар гомдол гаргах эрх;
7. Боломжит хугацаанд асуудлаа шүүхээр хэлэлцүүлэх эсхүл

³⁶ Хүний эрхийн үндэсний комиссын тайлан илтгэл 2022 он

³⁷ Эмнести интернэшнл, Шударгаар шүүлгэх эрх, гарын авлага, УБ., 2014 он

- суллагдах эрх;
8. Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа, нөхцөлөөр хангагдах эрх;
 9. Дуугай байх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх;
 10. Хүнлэг нөхцөлд хоригдох ба эрүү шүүлт бусад зүй бус харьцаанаас ангид байх эрх зэргээр эрхээр зайлшгүй хангагдсан байх ёстой байдаг.

Харин шүүхийн ажиллагааны үеийн эрхийн хүрээнд:

1. Хууль, шүүхийн өмнө тэгш байх эрх;
2. Хуулиар байгуулагдсан, эрх бүхий, хараат бус, голч шүүхээр шүүлгэх эрх;
3. Хэргийг шударгаар хэлэлцүүлэх эрх;
4. Нээлттэй шүүлгэх эрх;
5. Гэм буруугүйд тооцох;
6. Өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгүүлэхээр шаардахаас ангид байх эрх;
7. Олон улсын хэм хэмжээг зөрчин олж авсан нотлох баримтыг хасуулах;
8. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх ба нэг гэмт хэрэгт хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглох;
9. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хошуулахгүйгээр шүүлгэх эрх;
10. Өөрийгөө биечлэн эсхүл өмгөөлөгчөөр дамжуулан өмгөөлөх эрх;
11. Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох эрх;
12. Гэрч асуулгах, гэрчийг байцаах эрх;
13. Хэлмэрчлүүлэх болон орчуулуулах эрх;
14. Шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах эрх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх;
15. Давж заалдах зэрэг эрхээр хангагдсан тохиолдолд шударгаар шүүгдэх эрх хангагдах юм.

Шударгаар шүүгдэх эрхийг хангах, иргэн Үндсэн хуулиар

баталгаажсан эрхээ эдлэхэд мэргэжлийн туслалцаа зайлшгүй шаардлагатай, мэргэшсэн өмгөөлөгчийн туслалцаа дэмжлэг байхгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэн эрхээ бүрэн хамгаалах боломж хязгаарлагдмал юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүн эрүү шүүлт буюу хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс чөлөөтэй байх, эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх буюу дур мэдэн баривчлах, цагдан хорихоос чөлөөт байх, эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр өөртэй нь хүнлэг, бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэх ёсоор хандах эрх эдлэх, эрүүгийн болон иргэний хэргээ бие даасан, хараат бус шүүхээр шударгаар шийдвэрлүүлэх эрх зэрэг эрхийг эдлэх эрхтэй.³⁸

Цаашид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийн агуулга, хэлбэрийг шалгуур болгож, практикт гарч буй бодит зөрчил, дутагдлыг халах зорилгоор бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үндсэн эрхийг хангах суурьтай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл хийх шаардлагатай байна.

³⁸ Хүний эрхийн Дээд Комиссарын алба, Олон улсын Барын холбоо, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Шүүгч, прокурор, өмгөөлөгчид зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 32 дахь тал

ХОЁР. ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ОРОЛЦОЖ БУЙ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчийн хууль зүйн байр суурь, оролцоо, мэргэжлийн эрхийг бид онол, зарчим, хүний эрхийн үүднээс нэг оролцогч болох прокурортой адилтгаж буюу прокурор яллах чиг үүргийг харин өмгөөлөгч бол өмгөөлөх чиг үүргийг гүйцэтгэж байгаа учир гол чухал оролцогчийн нэг гэж үздэг. Гэвч бодит практик дээр энэ онолын ойлголт, үзэл санаа зөрдөг. Иймд онолын ойлголт, үзэл санаа, хуулийн байгууллагын бодит практик хоёр яагаад зөрөөд байгааг нухацтай авч үзэх, түүнийг тодорхойлж буй үзэл санаа, ойлголтыг бодитой харах шаардлагатай байна.

Ажил хэргийн практик дээр өмгөөлөгчид анх төсөөлж байснаас огт өөр дүр зураг, саад бэрхшээлтэй тулгардаг ч дийлэнх нь хүний эрхийг хамгаалах өөдрөг үзэл санаа тээж, саад бэрхшээлийг тэвчиж ирсэн нь үнэн. Энэ бүхэн нэг талаас Инквизицийн загвар /мөрдөн шалгах тогтолцоо/ болон Аккусацийн загвар /мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо/-аас хамаарч байдаг ч гэсэн бүх бэрхшээл, зөрчлийг гагцхүү тогтолцооны асуудал мэтээр харах нь учир дутагдалтай.

2.1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦООГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Өмгөөлөгчид бид өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагааны ач холбогдол, онолоо хэрхэн үнэлж, дүгнэх нь нэг хэрэг юм, харин бусад оролцогчийн талаас, хууль тогтоогчоос ЭХХША-ны онол, арга зүйн хувьд өмгөөлөгчийн ЭХХША дахь байр суурь, оролцоог хэрхэн үзэж, хуульчлан тодорхойлсон байгааг тодруулах асуудлыг авч үзье.

Дотоод хэргийн их сургуулиас 2020 онд эрхлэн гаргасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” бүтээлд Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны мөн чанар нь хэрэг шалгаж шийдвэрлэх эрх бүхий субъект болох мөрдөгч, прокурор, шүүгчийн

үйл ажиллагаагаар тодорхойлогдоно³⁹ гэсэн байна. Мөн “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа гэдэгт эрүүгийн хэрэг мөрдөх, шалгах, хянан хэлэлцэх, шийдвэрлэх чиг үүрэгтэй шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны цогц тогтолцоо, мөн уг ажиллагааг хэрэгжүүлэх явцад эдгээр байгууллага болон эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын хооронд үүсэх эрх зүйн нэгдмэл харилцааг ойлгоно”⁴⁰ гэжээ. Түүнчлэн эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, прокурор, шүүгч, яллагдагчаас гадна хохирогч, гэрч, өмгөөлөгч, шинжээч, мэргэжилтэн зэрэг өвөрмөц чиг үүрэгтэй, төрөл бүрийн салбарын субъектийг хамруулж болох тухай дурдсан⁴¹ байдаг.

Дээр дурдсан хамтын бүтээлд илэрхийлсэн үзэл онолыг үндэс болговол, ЭХХША-ны үндсэн оролцогч нь шүүх, прокурор, мөрдөгч бөгөөд өмгөөлөгчийг “гэрч, шинжээч, мэргэжилтэн” зэрэгтэй адил өвөрмөц чиг үүрэгтэй субъект гэж үзэж болно. Энэ тодорхойлолт, ойлголт өмгөөлөгч ЭХХША-нд оролцож буй өнөөгийн оролцоог тайлбарлахад илүү тохирч байна. ЭХХША гэдэгт эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, хянан хэлэлцэх, шийдвэрлэх чиг үүргийг хамруулж авч үзсэн байх бөгөөд ЭХХША-нд өмгөөлөх чиг үүргийг тусгайлан авч үзээгүй байдаг. Өмгөөлөх чиг үүргийг “*хянан хэлэлцэх*” чиг үүрэгт багтааж өмгөөлөгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд хэргийн үйл баримт, үнэн зөвийг тогтоох, бодиттой шийдвэр гаргахад туслалцаа үзүүлж, нөлөөлж байдаг субъект гэж ерөнхий байдлаар тодорхойлон авч үздэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Тавдугаар бүлэгт өмгөөлөгчийн эрх зүйн байдал, эрх, үүргийг тодорхойлсон, өмнөхөөс дэвшилттэй зүйл байдаг боловч энэ нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна.

³⁹ Х.Нямбаатар, Л.Батжав, Ч.Нямсүрэн нар, Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2020 он, 11 дэх тал

⁴⁰ Х.Нямбаатар, Л.Батжав, Ч.Нямсүрэн нар, Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2020 он, 14 дэх тал

⁴¹ Мөн тэнд 39 дэх тал

Манай улсын өмнөх нийгмийн тогтолцоонд эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагаас эрүүгийн хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүн хэлэлцэж таслан шийдвэрлэх, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлалыг биелүүлэх явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний систем⁴² гэж үздэг байв. Мөн ЭБША-нд оролцож байгаа хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор болон шүүхийн үйл ажиллагаа нь харилцан уялдаа холбоотой нарийн дэс дарааллаар хийгдэх байцаан шийтгэх үйлдлүүдийн систем⁴³ гэж тодорхойлж байв.

БНМАУ-ын ЭБШХ-ийн III бүлэгт сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, орчуулагчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид гэж заасан байна. Урьдчилсан мөрдөн байцаалтыг дуусгаж, хэргийн бүх материалтай танилцахыг яллагдагчид мэдэгдсэн үеэс эхлэн хэрэгт өмгөөлөгчийг оролцуулна. Урьдчилсан мөрдөн байцаалт явуулаагүй хэрэгт яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн үеэс эхлэн өмгөөлөгчийг оролцуулна. Өмгөөлөгч бол яллагдагчийн төлөөлөгч биш бөгөөд яллагдагчийн өмнөөс биш яллагдагчтай зэрэгцэн үйл ажиллагаа явуулдаг⁴⁴ гэж үзсэн байдаг.

Академич, доктор (Sc.D) профессор Ж.Амарсанаа “Монгол Улсын хувьд 1990-ээд он хүртэл өмгөөлөгч зөвхөн шүүх хуралдааны шинэчилсэн байцаалтын үед оролцох бөгөөд урьдчилсан мөрдөн байцаалтын үед түүнийг оролцуулдаггүй”⁴⁵ талаар бичсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь төрийн оролцоотой явагддаг бөгөөд ЭХХША-нд оролцож өмгөөлөгчийн эрх, оролцоо нь хүний эрхийг баталгаатай, тууштай хамгаалах хэмжээнд биш байгаад иргэдийн зүгээс байнга илэрхийлсээр ирсэн зүйл юм.

⁴² БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, УБ., 1987 он, 8 дахь тал

⁴³ БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, УБ., 1987 он, 6 дахь тал

⁴⁴ БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, УБ., 1987 он, 41, 43 дахь тал

⁴⁵ Ж.Амарсанаа, “Хүний эрх. Олон Улсын ба Үндэсний эрх зүйн асуудал” УБ., 2000 он, 96 дахь тал

ЭХХША-нд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн иргэний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий өмгөөлөгчийн эрх, оролцоо, яллах чиг үүрэгтэй оролцож буй прокурорын эрх, оролцоо нь ялгаатай, яллах тал илт давуу байдалтай байгаа нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг бодит байдал дээр дордуулах, яллах хандлага практикт давамгайлахад нөлөөлж байна. Иймд ЭХХША-нд оролцож буй иргэн өөрийн үндсэн эрх болох шударгаар шүүлгэх эрхийг өөрийн сонгосон өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж буй тул өмгөөлөгчийн эрх, оролцоог бодитой, үр нөлөөтэй болгон өөрчлөх, шинэчлэх шаардлагатайг олон судлаач эрдэмтэд илэрхийлсэн байдаг.

Тухайлбал, ХБНГУ-ын эрдэмтэн Томас Уэйгенд өмгөөллийн үйл ажиллагаа нь шүүхээс өмнөх шатанд хязгаарлагдмал мэтгэлцээний хэлбэрээр хуульчлагдсан байх боловч бүхэлдээ яллах тогтолцоог үгүйсгэх буюу няцаахад чиглэгдсэн нотлох ажиллагааг явуулдаг тул энэ нь цагдаа болон прокурорын ажиллагаанаас өөр зарчим шалгуураар зохицуулагдсан байх ёстой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харилцаанд оролцож буй өмгөөлөгч нь яллах чиг үүрэг хэрэгжүүлж буй прокурор, мөрдөгчтэй тэнцүү статусыг өөртөө олж авах ёстой юм⁴⁶ гэсэн байна.

ХБНГУ-ын эрдэмтэн Херберт Боуминг өмгөөлөгч нь мэтгэлцэх ажиллагааны үндсэн оролцогч бөгөөд энэхүү статусыг эдэлснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект байх боломж нь нээгдэх бөгөөд мэтгэлцээний үр дүн нь прокурорын үйл ажиллагаанаас төдийгүй өмгөөллөөс шууд шалтгаална гэсэн байдаг.⁴⁷ Гэтэл манай ЭХХША-д өмгөөлөгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэрэгжүүлэгч субъект гэсэн байр сууринаас бус, “гэрч, шинжээч” нарын адил “өвөрмөц субъект”, гэж үздэг нь учир дутагдалтай юм.

⁴⁶ МУИС, ХЗС, У.Хүрэлсүх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах шаардлага, арга зам, Хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, УБ., 2019 он, 9 дэх тал

⁴⁷ Шүүн таслах ажиллагааны мэтгэлцээн, гарын авлага, УБ., 2004 он

Сэжигтэн, яллагдагч иргэн, түүний өмгөөлөгчийн «процессын эрх», яллах нэг тал болсон прокурортой эн тэнцүү байж чадахгүй байгаагийн нэг жишээ нь шүүх хурлын мэтгэлцээний явцад шүүгдэгч иргэн нь өөрийг нь яллаж буй прокуророос асуулт асуух эрх байхгүй, зөвхөн прокурор нь шүүгдэгчээс асуулт асуух давуу эрхтэй, тэр бүү хэл өмгөөлөгч нь прокуророос асуулт асуух эрхгүй байдаг. Цаашилбал, өмгөөлөгч нь шинжээчийн дүгнэлтийг хувилж авах эрхгүй, гараараа бичиж авахад цаг зарцуулдаг, ЭХХША-ны явцад гарсан шинжээч томилсон, хэрэг хэрэгсэхгүй болгох, яллагдагчаар татах, тогтоолыг хүчингүй болгох зэрэг мөрдөгч, прокуророос гаргаж буй тогтоол, шийдвэрийг хувилж авах эрхгүй, зөвхөн унших эрхтэй, зарим тохиолдолд танилцуулдаггүй, өмгөөлөгч өөрийнхөө үйлчлүүлэгчийн мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэг, тайлбартай танилцах эрхгүй байдаг. Энэ мэт хүний эрхийг үл хүндэтгэж, хохироосон зохицуулалт, практик тогтсон байдгийг арилгах, ЭХХША-г сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдан шаллагдаж байгаа хүнийг хэлмэгдүүлэх, хохироохоос сэргийлсэн хүний эрхийн баталгаатай болгох шаардлагатай.

Онолын хувьд хүний эрхийг хамгаалагч болох хуульч мэргэжилтэн Өмгөөлөгч болон төрийг төлөөлөн яллаж буй хуульч мэргэжилтэн Прокурор хоёр эрх тэгш мэтгэлцэх эрхтэй гэж үздэг, гэтэл бодит байдал дээр прокурор, өмгөөлөгч хоёрын процессын эрх нь илт ялгаатай, прокурор нь давуу эрхтэй, ийм тохиолдолд бодит байдал дээр яллагдаж буй иргэний эрхийг өмгөөлөгч хууль зүйн хувьд хамгаалах боломжгүй байгаа нь бодит үнэн юм. Мэтгэлцэх эрх бол мөрдөн байцаалтын шатанд байх ёстой, үүнийг хангах нь чухал байна, хангах арга зам нь процессын шударга байдал юм.

Процессын шударга байдал нь шударгаар шүүгдэх эрхийн суурь юм. Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг хууль эрх зүйн мэдлэг, ойлголт бага байгааг ашиглан гэрчээр мэдүүлэг авч өөрийгөө өмгөөлөх боломжийг хаадаг, дараа нь тухайн иргэнийг сэжигтэн, яллагдагчаар татсаны дараа мэдүүлэг зөрвөл гэрчийн мэдүүлэг худал өгсөн гэж яллаж буруутгадаг явдал оршсоор байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчийн эрх, оролцоо хязгаарлагдмал

байдгаас өмгөөлөгч шүүхийн өмнөх шатанд нотлох ажиллагаа явуулах боломж бага, яллах тал болох прокурорын яллах нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажил давамгайлсан байдаг.

Манай ЭХХША-нд мэтгэлцэх эрх бодитой байхгүйгээс хүний эрх зөрчигдөх болсон, мэтгэлцэх эрхийг “гэм буруугаа хүлээгээгүй, гэмшээгүй зан төлөв” гэж үзэж илүү хүчтэй яллах хандлага, практик тогтсон. Өөрөөр хэлбэл, “үгүйсгэх эрх”-ийг хүлээн зөвшөөрдөггүй.

2.2. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХИЙН БАТАЛГАА

Хүний эрхийг хангахад өмгөөлөгчийн ажил, мэргэжил гол үүрэгтэй. Өмгөөлөгчийн ажил мэргэжлийн хараат бус, бие даасан байдлыг хангахгүйгээр хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах боломжгүй юм.

Хараат бус, бие даасан шүүгч, яллагч нарын зэрэгцээ хүний эрхийг үр ашигтай хамгаалах баталгааг хангах, ардчилсан нийгэмд хууль дээдлэх ёсыг хангахад өмгөөлөгч нар гуравдагч тулгуур багана болдог. Мэргэжлийн үүргээ үр ашигтай биелүүлэхийн тулд өмгөөлөгчид олон улсын болон дотоодын хууль тогтоомжоор үйл ажиллагааны баталгааг хангасан байхаас гадна шүүх, прокурорын нэгэн адил аливаа төрлийн дарамт шахалтаас чөлөөтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, шүүн таслах ажиллагааг шударга, үр ашигтайгаар хэрэгжүүлэхэд өмгөөлөгч дайралт, халдлага, авлига ба бусад төрлийн сүрдүүлгээс ангид ажиллах бололцоог нээх шаардлагатай.⁴⁸

НҮБ-аас баталсан Хуульчдын гүйцэтгэх үүргийн суурь зарчмууд баримт бичигт⁴⁹ Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хуулийн өмнө эрх тэгш байх, гэм буруугүйд тооцогдох зарчим, аливаа хэргийг хараат бус, алагчлалгүй шүүх, ил тодоор, шударга ёсны бүх шаардлагыг сахиж хянан шийдвэрлүүлэх эрх, гэмт хэрэгт яллагдаж байгаа аливаа

⁴⁸ Хүний эрхийн Дээд Комиссарын алба, Олон улсын Барын холбоо, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Шүүгч, прокурор, өмгөөлөгчид зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 147 дахь тал

⁴⁹ мөн тэнд

хүнийг хамгаалах шаардлагатай бүх баталгааг хангах, аль болох богино хугацаанд шүүгдэх эрх, олон нийтийг оролцуулан, нээлттэй шүүгдэх эрхийг хангах, гэмт хэргийн хохирогчид шударга шүүхэд хандах, хохирлоо арилгуулах, бүх хүн хараат бус, мэргэжлийн хуульчдаас хууль зүйн үйлчилгээ авах бодит бололцоотой байх нь чухал болохыг онцолсон байдаг.

Уг баримт бичигт “Хүн бүр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд өөрийгөө хамгаалуулахаар өөрийн сонгосон аль ч хуульчид хандах эрхтэй.” (*Зарчим 1*), “Хуульчид шударга ёсны үүднээс, өөрийн үйлчлүүлэгчийн хууль ёсны эрхийг хамгаалахдаа үндэсний болон олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг дээдлэн, хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хуульчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан чөлөөтэй, нарийн чамбай ажиллах ёстой.”(*Зарчим 14*), “Хуульчдыг өөрийн чиг үүргийг биелүүлсний төлөө үйлүүлэгчидтэй нь адилтгах эсхүл үйлчлүүлэгчдийнх нь үйл хэргийн нэг хэсэг гэж үзэж болохгүй.” (*Зарчим 18*), “Хуульчид нь шүүхэд буюу шүүх, тусгай шүүх бусад хуулийн болон захиргааны байгууллагад сайн санааны үүднээс мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд гаргасан аливаа бичгэн болон аман мэдэгдлийн төлөө иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээхээс ангид байна.”(*Зарчим 20*), “Эрх бүхий байгууллага нь өөрийн мэдэлд буюу хяналтад байгаа зохих мэдээлэл, нууц мэдээ, баримт бичигтэй танилцах боломжийг олгох үүрэгтэй бөгөөд энэ боломж нь хуульч өөрийн үйлчлүүлэгчид үр дүнтэй хууль зүйн туслалцаа үзүүлэхэд хангалттай хугацаанд үргэлжлэх шаардлагатай. Мөн энэ боломжийг хуульчдад аль болох богино хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.” (*Зарчим 21*), “Төр засаг хуульч мэргэжлийн үйл ажиллагаагаа ямарваа нэг заналхийлэл, саад бэрхшээл, айлган сүрдүүлэлт буюу зохисгүй нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах үүрэгтэй” (*Зарчим 16a*), “Төр хуульчийг ажил мэргэжлийн тогтсон стандарт, ёс зүйн хэмжээний хүрээнд ажлаа хийж гүйцэтгэснийхээ төлөө эрүүгийн, захиргааны хариуцлага хүлээлгэх, эдийн засгийн болон бусад хариуцлагад татагдахгүй байх, тийм заналхийлэлд өртөхгүй байх

баталгааг гаргаж өгнө” (*Зарчим 16с*)⁵⁰ зэрэг өмгөөлөгчөөс мэргэжлийн чиг үүргийг гүйцэтгэх баталгаа, зарчмыг баталгаажуулсан байдаг.

Мөн 12 дугаар зарчимд “Шударга ёсыг тогтоогч үндсэн оролцогч болохын хувьд хуульчид мэргэжлийнхээ нэр төр, алдар хүндийг ямагт хадгалж авах ёстой” бөгөөд 13 дугаар зарчимд хуульчдын үйлчлүүлэгчийн өмнө дараах үүрэг хүлээнэ гэж заажээ. Үүнд:

- “(a) Үйлчлүүлэгчдэдээ эрх, үүргийг нь, мөн хамаарах хууль шүүхийн тогтолцоо, механизм хэрхэн ажилладаг талаар зөвлөн таниулах
- (b) Үйлчлүүлэгчдэдээ зохих туслалцаа үзүүлэх ба тэдний ашиг сонирхлыг хамгаалах хууль ёсны үйл ажиллагаа явуулах,
- (c) Үйлчлүүлэгчдэдээ шаардлагатай үед шүүх, шүүн таслах бусад байгууллага, захиргааны байгууллагатай харьцахад нь туслалцаа үзүүлэх”⁵¹ хамаарна.

Хуульчдын ажил, үүргийн талаарх НҮБ-ын суурь зарчмуудын 13-д хуульч нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах тодорхой үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч шударгаар үйлчлэх, үндэсний төдийгүй олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөвшөөрөгдсөн хуулийн хүрээнд өөрийн итгэл, ёс зүйн дагуу хараат бусаар ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа чөлөөтэй явуулах баталгаатай байхаар заасан⁵² байдаг. Мөн Олон улсын барын холбооны хууль зүйн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандартад хуульч нь үйл ажиллагаа, статусын хувьд бие даасан байх нь хүний эрхийг хангах баталгаа бөгөөд тэднийг үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэхэд шууд ба шууд бус байдлаар элдэв саад учруулах,

⁵⁰ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл (Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй), УБ., 2012 он, 93 дахь тал

⁵¹ Хүний эрхийн Дээд Комиссарын алба, Олон улсын Барын холбоо, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Шүүгч, прокурор, өмгөөлөгчид зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 147 дахь тал

⁵² Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл (Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй), УБ., 2012 он

хууль ёсны шаардлага, хүсэлт тавихад нь үл тоомсорлон харьцах, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүндэтгэх шалтгаангүйгээр хориг, хязгаарлалт тавих зэргээс ангид байх баталгааг бүрдүүлэх талаар улс орнууд хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэх талаар заасан⁵³ байдаг.

2.2.1. Өмгөөлөгч хүний эрхийн хамгаалагч болох нь

ЭХХША-нд оролцож буй иргэний эрхийг хамгаалах асуудал дээр туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчийн мэргэжлийн эрхийг хүний эрхийг хамгаалагч, мэргэжлийн оролцогчийн түвшинд олон улсын жишигт ойртуулах, хүний эрхийг хамгаалах олон улсын механизмтай холбох зайлшгүй шаардлагатай байна. Монгол Улсын Хүний эрхийн олон улсын гэрээ, пакт, хэлэлцээрт нэгдсэн орсон байдаг боловч эдгээр баримт бичгийг шүүхийн процесс, шүүхийн практикт хэрэглэх явдал учир дутагдалтай байсаар ирлээ.

Монгол Улс хүний эрх хамгаалагчийн хуулийг батлан гаргасан бөгөөд өмгөөлөгч бол ажил мэргэжлийн хувьд хүний эрхийг хамгаалагч юм. “Хүний эрхийг хамгаалах эрх” нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бөгөөд уг эрхийг олон этгээд эдэлж байдгаас гадна өмгөөлөгч, хуульчид хүний эрхийг хамгаалагчдын нэг. УИХ-аас 2021 онд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан гаргасан бөгөөд уг хуульд зарим ойлголт, нэр томъёог тодорхойлсон байдаг болно. Үүнд:

4.1.1.“Хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2.“Хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, аливаа хэлбэрээр хүний эрхийг хамгаалахыг;

⁵³ Өмгөөлөл судлал 1-р боть, УБ., 2011 он, 400 дахь тал

4.1.4.“Хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“Хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгих, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэжээ.

Хүний эрхийг хамгаалагч нар нь орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын түвшинд ганцаарчлан болон бусадтай эвсэж хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, үүний төлөө эрмэлзэж” ажилладаг бөгөөд аливаа ялгаварлалгүйгээр бүх хүнд хамаатай хүний эрхийн түгээмэл чанарыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийг тайван замаар хамгаалдаг. Төр хүний эрхийг хүндлэх, хамгаалах үүрэг нь дараах агуулгатай байна. Үүнд: а) Хүний эрхийн талаарх үйл ажиллагааны улмаас хүний эрхийг хамгаалагчдын аливаа эрхийг зөрчих үйлдэл гаргахаас татгалзах; б) Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааных нь улмаас гуравдагч талаас үзүүлэх дарамт шахалтаас хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, энэ үйл явцыг зохих журмын дагуу шийдвэрлэх; в) Хүний эрхийг хамгаалагчдын эрх, түүний дотор хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн санаачилгатай алхмуудыг авч хэрэгжүүлэх зэрэг болно.⁵⁴

ЭХХШТХ-ийн 31 дүгээр бүлэгт заасан процессын хувьд авч үзвэл Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж, яллагдагчаар татагдах процесс бол төрийн албадлага юм. Иргэн хүн гэмт хэрэгт яллагдаж төрийн албадлага, машинтай нүүр тулж эхэлж буй эхний үе шат юм.Иргэн

⁵⁴ <https://www.osce.org/files/f/documents/1/7/454269.pdf>

хүн эрх чөлөөтэй байх, халдашгүй байх эрхтэй. Гэтэл эрх хэдэн байдлаар энэ процесст зөрчигдөж байна.

Хууль зүйн доктор С.Цэрэндорж 2008 онд “Өмгөөлөгч” сэтгүүлд⁵⁵ хэвлүүлсэн өгүүлэлдээ “...эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо, эрх мэдэл, тодорхой үндэслэл байгаа тохиолдолд хэргийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлүүлэх боломж, нөлөөллийн арга хэрэгсэл тун хангалтгүй байна. Энэ нь бүхэлдээ байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийг бусдаас хараат, идэвхгүй байдалд оруулахын зэрэгцээ бүхэлдээ манай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэг талыг барьсан, байцаалт, яллах эрүү шүүлтийн хандлагатай, хүний эрхийн зөрчлийг байнга нөхцөлдүүлсэн шинжтэй болгодог.

Өмгөөлөгчийг хэлбэрийн төдий процесст оруулдаг байсан, гэм бурууг хүлээлгэхийг гол зорилтоо болгож байсан 45 жилийн өмнөх үеэс өмгөөлөгчийн эрхэд зарчмын өөрчлөлт гараагүй, харин ч зарим тодорхой эрх бүдгэрч, ерөнхий байдлаар тусгагдсан. Хуулийн төслийг прокурор, шүүх, цагдаагийн практик ажилтнууд голлосон бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг боловсруулж, эрдэмтэд, хүний эрхийн судлаач, мэргэжилтнүүдийн санаа зөвлөгөөг тэр бүр авдаггүй, бусад улс орны чиг хандлага, олон улсын гэрээ конвенцын гол үзэл санааг төдийлөн анхаардаггүйтэй энэ бүхэн нь холбоотой.

Манайд хэзээнээс шүүх, прокурор, цагдааг төрийн байгууллага, төрийн бодит нэг биет илэрхийлэл гэдэг ойлголтын хүрээнд төр засгаас зориуд анхаарч, бодлого зохицуулалт, санхүү, техник болон боловсон хүчний хангамж, менежмент, давтан сургалт, мэргэжил дээшлүүлэлтийн хувьд зохих хөрөнгө оруулалт хийж ирсэн. Цаашид өмгөөлөх байгууллагын хувьд төр засгийн дэмжлэг хэрэгтэй байна. Шүүх засаглалд зөвхөн сайн шүүгч, прокурор, мөрдөн байцаагч төдийгүй сайн өмгөөлөгч нэг адил хэрэгтэй гэдгийг бид байнга санавал зохилтой. Цаашид өмгөөлөгчийн эрхийг өргөтгөх, өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоход:

⁵⁵ Монголын өмгөөлөгчдийн холбоо, Өмгөөлөл судлал, /Өгүүлэл, нийтлэлийн эмхтгэл/, I Боть, УБ., 2011 он, 339 дэх тал

- Өмгөөлөгч бие даан нотлох баримт цуглуулах,
- Шүүх хуралд гэрч дуудах,
- Өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч заавал шалгаж шийдвэрлэдэг байх,
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын буруутай үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх (мөрдөн байцаах ажиллагаанд тавих шүүхийн хяналтын эхлэл тавигдсан гэж үзэх үндэстэй),
- Хавтаст хэрэгт авагдаагүй шинэ нотлох баримтыг шүүх хуралдаанд хэлэлцүүлэх,
- Зэрэгцсэн мөрдөн байцаалт явуулах зэрэг тодорхой эрхийг хуульд тусгах шаардлагатай. Энэ нь олон улс орны хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн байгууллага, хуульчид, өмгөөлөгчдийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон олон улсын гэрээ, баримт бичгүүдэд нэгэнт тусгагдаж, ердийн хэм хэмжээ болжээ” гэсэн байдаг.

Доктор Ж.Бямбаа “Мөрдөн мөшгөх, шүүн таслах ажиллагаан дахь өмгөөллийн зарим асуудал”⁵⁶ нийтлэлдээ “мөрдөн байцаалтын ажиллагаа нь мөрдөлт, байцаалт гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр нь дангаараа, бас хослол, цогц зэрэг янз бүрийн хэлбэрээр явагдана. Чухам мөрдөн байцаалтын төрөл, хэлбэрийн үед процессын баталгаа, түүний дотор өмгөөллийн үйлчлэл, үр нөлөө, онцлог ямар байх вэ гэдэг нь судлаачдын төдийгүй практик ажилтын анхаарлыг байнга татаж байдаг юм. Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх нь манай хуульд заасан ёсоор эрүүгийн хэрэг үүсгэсэн (сэжигтнийг баривчлах) үеэс эхлэн идэвхтэй үйлчлэх учиртай. Мэтгэлцэх зарчмыг шүүн таслах ажиллагаанд жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд дараах алхмуудыг хийх шаардлагатай. Үүнд:

- Шүүхийн өмнөх шатанд процессын баталгааг бодтойгоор хангах (түүний дотор мэтгэлцээнд өмгөөлөгч тал бэлдэх) бүхий л боломжийг бүрдүүлэх;
- Хуралдааны үед мөрдөн байцаалтын дутууг гүйцээхийн

⁵⁶ Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Өмгөөлөл судлал, /Өгүүлэл, нийтлэлийн эмхтгэл/, I Боть, УБ., 2011 он, 350 дахь тал

тулд яллах, өмгөөлөх чиг үүргийн аливаа хэлбэрийг шүүх дангаараа эрхлэхээс татгалзах;

- Яллах тал мэтгэлцээнд оролцохгүй байх, идэвх гаргаагүй тохиолдолд шүүх түүнийг үл орлох;
- Шүүгдэгчийн гэм бурууг нотлуулахаар шүүх өөрөө санаачлан нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах;
- Өмгөөлөх тал нэн түрүүнд мэргэжлийн өмгөөлөгч шүүхийн өмнө тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн баримт, мэдээллээ шинээр гаргаж тавих;
- Улсын яллагч, өмгөөлөгч хоёр бие биедээ шүүхээр хэлэлцүүлж буй хэргийн ямар ч асуудлаар асуулт тавьж хариулт авах замаар мэтгэлцээний агуулгыг өргөжүүлэх, улам бодитой болгох эрх зүйн зохицуулалтыг хуульд тусган, 261 дүгээр зүйлийг бодитоор хэрэгжих нөхцөлийг бий болгох зэргийг дурдаж болно” гэсэн байна.

Мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд нь ийм байдлаар хөндлөнгөөс нөлөөлөх явдлаас хуульчдыг хамгаалахад Засгийн газрууд бололцоотой бүх арга хэмжээ авах нь чухал юм. Ялангуяа хүний эрх хамгаалагчдыг төлөөлөн өмгөөлөл хийж байгаа өмгөөлөгч нарыг тэдний үйлчлүүлэгчидтэй адилтган үзэх явдал олонтоо гардаг байна. Иймд өмгөөлөгчдийг ч мөн мэргэжлийн үүргээ төрийн болон бусад хөндлөнгийн зүй бус оролцоогүйгээр хараат бус, үр ашигтай гүйцэтгэх боломжоор хангаж аюулгүй байдлыг баталгаатай хангах ёстой. Давтан тэмдэглэхэд, мэргэжлийн аливаа алдаа зөрчил гаргавал тусгайлан байгуулсан хараат бус байгууллагаар шийдвэрлүүлэх ёстой.⁵⁷

Өмгөөллийн тухай хуулийн 32 дугаар зүйлд Мэргэжлийн хариуцлагын хороог байгуулахаар заасан байдаг. Мэргэжлийн хариуцлагын хороо нь өмгөөлөгч хууль болон Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, энэ хууль болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэгтэй байгууллага юм.

⁵⁷ мөн тэнд

Хуулийн 32.4-д “Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн төлөөлөл тус бүр нэг, Өмгөөлөгчдийн Холбооны төлөөлөл долоо байна” гэж заасан нь мэргэжлийн аливаа зөрчил дутагдалтай холбоотой асуудлыг шүүх, прокурор, Хууль зүй, дотоод хэргийн яамны нөлөө, оролцоогүй хараат бус байгууллагаар шийдвэрлүүлэх зарчимд нийцэхгүй байна.

Хуульчдын гүйцэтгэх үүргийн тухай суурь зарчмуудын 23-д:

“Хуульчид нь бусад иргэдийн нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Ялангуяа, тэд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, шударга ёс тогтоох болох хууль тогтоожмийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, түүнчлэн орон нутгийн, үндэсний болон олон улсын байгууллага байгуулах, нэгдэх эрхийг ямар нэг мэргэжлийн үйл ажиллагааны хязгаарлалтгүйгээр эдэлнэ. Хуульчид эдгээр эрхээ хэрэгжүүлэхдээ хуульчийн мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг чандлан сахина.

Францад өмгөөлөгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласантай холбоотой хэргийг (*Ezelin v. France*, 26 April 1991 § 37) Европын хүний эрхийн шүүхэд авч хэлэлцсэн байдаг. Уг хэргийн үйл баримт нь өмгөөлөгч Эзелин жагсаал цуглаанд оролцсон бөгөөд жагсаалын үеэр болсон жижиг хэмжээний үймээнд өөрөө оролцоогүй хэдий ч энэ хэрэг явдлаас ангид байж чадаагүй гэж үзэх түүнд өмгөөлөгчийнх нь хувьд “мэргэжлийн хувьд хүлээсэн үүргээ зөрчсөн” гэж үзэн сахилгын хариуцлага оногдуулсан явдал юм. Хүний эрхийн шүүх уг хэргийг шийдвэрлэдээ Европын хүний эрхийн конвенцийн тайван жагсаал цуглаан хийх эрхийн тухай 11, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай 10 дугаар зүйлийг баримталж шийдсэн байна. Ингэхдээ үзэл бодлоо илэрхийлсэн иргэнийг ажил мэргэжлийнх нь хувьд алдаа гаргасан гэж үзэж сахилгын хариуцлага хүлээлгэх нь өмгөөлөгчдийг цаашид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхээс айх, үзэл бодлоо илэрхийлсэн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээх юм байна гэсэн итгэл үнэмшил бий болгож байгаа нь хүний эрхийн зөрчил гэж үзсэн байна.

Нөгөөтэйгээгүүр Европын хүний эрхийн шүүхийн өөр нэг шийдвэрт (Schopfer v. Switzerland) өмгөөлөгч Шопфэр хэвлэлийн бага хурал зохион байгуулж өөрийн үйлчлүүлэгчийн цагдан хоригдсон нь хууль бус бөгөөд прокурорын байгууллагын ажилтнууд хууль зөрчсөн гэж үзэж байгаа тухай мэдээлсэн нь өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйг зөрчсөн гэж сахилгын шийтгэл хүлээлгэсэн нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь хязгаарласан гэж үзэхгүй гэжээ. Шийдвэрийн үндэслэлд өмгөөлөгч хэдийгээр өөрийн ажиллаж буй хэрэг маргаан, түүнд холбогдох процессын талаар олон нийтэд мэдээлэх, тайлбарлах эрхтэй ч олон нийтийн итгэлийг хүлээсэн байх ёстой хуулийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлэхлээ тодорхой хязгаараас хэтэрч үл болох тухай дурдсан байна.

Үүнтэй холбоотойгоор шүүхийн шийдвэрийн талаар мэдээлэл олж авах олон нийтийн эрх, шүүн таслах ажиллагааг зүй ёсоор явуулах шаардлага, өмгөөлөгчийн мэргэжлийн нэр хүнд гэсэн олон төрлийн ашиг сонирхлуудын хоорондох зөв харьцаа буюу тэнцвэрийг тооцож үзэх ёстой. Энэ зөв харьцааны талаар тухайн тохиолдолд үнэлгээ өгөхөд гишүүдтэйгээ шууд болон байнгын харьцаанд байдаг Барын удирдлага ба дотоодын шүүх нь олон улсын шүүхээс илүү дөхөмтэй байдаг. Энэ салбарт хөндлөнгөөс оролцох зайлшгүй шаардлага байсан эсэхийг тэд шийдвэрлэх илүү бололцоотой. Гэхдээ тухайн хэргийн талаар гаргасан шийдвэр ба баримталсан дүрэм журмын аль аль Европын хяналтын байгууллагаар хянагдана гэж цохон тэмдэглэсэн юм.⁵⁸

Прокурор болон өмгөөлөгчид нь мэтгэлцээний эсрэг талууд бөгөөд НҮБ-аас баталсан Хуульчдын гүйцэтгэх үүргийн суурь зарчмуудтай хамт батлагдсан баримт бичиг бол Прокурорын үүргийн удирдах зарчмууд⁵⁹ юм. Уг зарчимд прокурор нь шүүх эрх мэдлийг

⁵⁸ Хүний эрхийн Дээд Комиссарын алба, Олон улсын Барын холбоо, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Шүүгч, прокурор, өмгөөлөгчид зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 149-152 дахь тал

⁵⁹ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл (Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй), УБ., 2012 он, 88 дахь тал

хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг этгээд гэдгийг дурдаж, ёс зүйн өндөр хэм хэмжээ, чадвартай, зохих бэлтгэл, мэргэшилтэй байх ёстой гэжээ. Мөн “Прокурорууд алагчлалгүй, мөрдөн байцаалтаар үндэслэлгүйг тогтоосон тохиолдолд хэрэг үүсэхгүй байх буюу эрүүгийн мөрдөлтийг үргэлжлүүлэхгүй байх, эсхүл байцаан шийтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийн тулд боломжтой бүх зүйлийг хийх ёстой.”, “Прокурорын мэдэлд тэдний мэдэж байгаагаар болон хууль бус аргаар ялангуяа эрүүдэн шүүх болон харгис хэрцгийгээр, хүнлэг бусаар, эсхүл хүний нэрийг доромжлон бусад хэлбэрээр харьцах буюу шийтгэх явдлыг бүрдүүлж байгаа тийм аргаар олж авсан эсхүл олж авсан гэж тодорхой үндэслэлээр үзэж болох бөгөөд эдгээр нь сэжигтний хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн тийм нотлох баримтууд байгаа бол тэдгээрийг хэрэглэсэн хүмүүсийн эсрэг л биш бол хэний ч эсрэг ашиглах ёсгүй бөгөөд шүүхэд ч энэ тухай зохих байдлаар мэдэгдэх ёстой хийгээд тийм нотолгоонуудыг хэрэглэсэн гэм буруутай этгээдүүдийг шүүхэд татах талаар шаардлагатай алхмууд хийх ёстой.” гэж заасан.

Европын зөвлөлөөс Хуульчийн мэргэжлийг чөлөөтэй хэрэгжүүлэх тухай R(2000)21 зааварт⁶⁰ хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангахад хуульчид, мэргэжлийн холбоод үндсэн үүрэг гүйцэтгэдэг гэдгийг онцлон, хүний эрхийг хамгаалах, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх чөлөөг дэмжих нь чухал гэдгийг тэмдэглэсэн байдаг.

Иймд өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелүүлэхэд аливаа зүй бус хязгаарлалт, өдөөлт, дарамт шахалт, заналхийлэл, хөндлөнгийн шууд болон шууд бус нөлөөллөөс ангид, бие даасан байдлыг баталгаажуулсан шударга ёсны тогтолцоо шаардлагатай гэж үзсэн байдаг. Уг зааврын 1-д “Хуульчийн мэргэжлийг хэрэгжүүлэх эрх чөлөөний зарчим”-ын талаар Хуульчид Европын хүний эрхийн конвенцид заасанчлан ямарваа хэлбэрийн алагчлал, эрх бүхий байгууллага, олон нийтийн зүй бус нөлөөллөөс ангид, чөлөөтэй мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, хуульчид

⁶⁰ <https://www.icj.org/wp-content/uploads/2014/10/CoF-rec200021-freedom-exercise-profession-lawyer.pdf>

хууль, шүүхийн шинэтгэлийн талаар болон бусад асуудлаар дуу хоолойгоо сонсгох, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй эвлэлдэх нэгдэх эрхтэй бөгөөд мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө аливаа хариуцлагад татагдахгүй байх баталгаагаар хангуулах, эрх чөлөө нь хязгаарлагдсан үйлчлүүлэгчтэйгээ уулзах, зохих хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжоор хангагдах, өмгөөлөгч-үйлчлүүлэгчийн нууцлалыг бүрэн дүүрэн хангуулах, үйлчлүүлэгчээ төлөөлөх, эрх ашгийг хамгаалах үүднээс шүүх болон төрийн бусад байгууллагад чөлөөтэй хандах, мэдээлэл олж авах эрхтэй тухай дурдсан байна.

2.3. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭДЛЭХ ЭРХИЙГ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД БАТАЛГААЖУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн зорилтод иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах эрхийг хангах, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулах талаар заажээ. Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд өмгөөллийн үйл ажиллагаанд баримтлах зургаан зарчмыг тусгасан байх бөгөөд эдгээр зарчим дээр нэмж өмгөөлөгч нь шүүх, прокурорын нэгэн адил аливаа төрлийн дарамт шахалтаас чөлөөтэй халдлага, авлига ба бусад төрлийн сүрдүүлгээс ангид ажиллах, хуульчийн мэргэжлийн ёс суртахууны дагуу хараат бусаар, өөрийн итгэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулах, өөрийн мэргэжлийн үүргийг гүйцэтгэх явцдаа амаар хийсэн мэдэгдлийнхээ төлөө иргэний болон эрүүгийн хариуцлагад татагдахгүй, халдашгүй байх зэрэг асуудлыг хөндсөн баталгаа, зарчмыг шинээр тусгаж өгөх нь цаашид өмгөөлөгчийн мэргэжлийн хараат бус, бие даасан байдлыг хангахад ач холбогдолтой байна. Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлд өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ эдлэх эрхийг заасан бөгөөд нотлох баримт цуглуулах эрх хэмжээний хүрээнд дараах эрхийг эдлэхээр заажээ. Үүнд:

13 дугаар зүйл. Өмгөөлөгчийн эрх

13.1. Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг эрх эдэлнэ:

13.1.1. нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх, эсхүл хэрэг, маргаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт сэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулах;

13.1.5. хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан баримт сэлт, нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;

13.1.6. шаардлагатай эд зүйл, баримт сэлт, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, түүнийгээ хэргийн материалд тусгуулах;

13.1.7. шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах, гарсан дүгнэлттэй танилцах, дүгнэлтийг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;

13.1.10. хуульд заасан үндэслэл, журмын дагуу шаардлагатай баримт сэлтийг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах;

13.1.11. тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, хүн, хуулийн этгээдээс өөрийнх нь зөвшөөрснөөр, эсхүл гэрээний үндсэн дээр зөвлөгөө авах, тодорхойлолт гаргуулах;

13.1.14. шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дуу-дүрсний бичлэгийг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах

ЭХХШтХ-ийн 5.1 дүгээр зүйлд Өмгөөлөгчийн эрх, үүргийг заасан бөгөөд уг зүйлийн 1-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна” гэж заажээ.

Өмгөөлөгч нотлох ажиллагаатай холбоотой дараах эрхийг эдэлнэ.
Үүнд:

5.1 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг

1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.

2. Өмгөөлөгч дараах эрхтэй:

2.1. гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан даруй уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт асуух;

2.2. хохирогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авхуулахаар хүсэлт гаргах;

2.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах, өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах;

2.4. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох;

2.5. өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах;

2.6. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, завсар оруулах тухай хүсэлт гаргах;

2.7. өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах;

ЭХХША-д өмгөөлөгч нь хүн, хуулийн этгээд зөвшөөрснөөр хэрэгт ач холбогдолтой тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах, эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, хавтаст хэрэгт авхуулах эрхтэй гэж заасан. Гэвч эрүүгийн хэрэгт шалгагдаж буй асуудлаар иргэн, хуулийн этгээд ямар нэг тайлбар, баримт бичиг, лавлагааг өмгөөлөгчид гаргаж өгөхөөс зайлсхийж, болгоомжлох хандлагатай тул дээрх эрх хэрэгжих боломж хомс байдаг. Заавал мөрдөх байгууллагын албан бичиг байх шаардлагатай гэсэн тайлбарыг хэлж, баримт гаргаж өгөхөөс олонх тохиолдолд татгалздаг. Нэгэнт нотлох баримтыг цуглуулах эрхийг

ЭХХШХ-д заасан тул уг эрхээ өмгөөлөгч баталгаатай эдлэх арга, хэлбэрийг нарийвчлан зохицуулах шаардлагатай юм.

Өмгөөллийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Өмгөөлөгчийн хүсэлтийн талаар заасан бөгөөд 20.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, баримт сэлтийг тухайн асуудлыг хариуцсан төрийн, төрийн бус байгууллагаас гаргуулан авах зорилгоор өмгөөлөгчийн хүсэлт гаргах эрхтэй”, 20.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгчийн хүсэлтийг хүлээн авсан төрийн, төрийн бус байгууллага 14 хоногийн дотор бичгээр хариу өгнө.”, 20.4-д “Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгчийн хүсэлтийг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 20.5-д “Энэ хуулийн 20.1-д заасан лавлагаа, мэдээлэл, баримт сэлтийг холбогдох байгууллага гаргаж өгөөгүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлж болно.” гэж өмгөөлөгчийн нотлох баримт цуглуулах эрхийн хууль зүйн баталгааг заасан.

Гэвч бодит практик дээр өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу ЭХХША-ны явцад баримт сэлт, нотлох баримт гаргаж өгөх байгууллага, хүн цөөн бөгөөд өмгөөлөгчийн зүгээс Өмгөөллийн тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх тохиолдол харьцангуй ховор байдаг.

Өмгөөллийн тухай хуулийн 26 дугаар зүйлд Өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг харьцангуй сайн баталгаажуулж өгсөн байна.

26 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа

26.1. Төрийн байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх болон үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглоно.

26.2. Төрийн байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч, улс төрийн нам, хүн, хуулийн этгээд хэн боловч өмгөөлөгч хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлэх, саад учруулах, баталгаа шаардах, заналхийлэх, бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

26.3. Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөллийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах, өмгөөллийн хуулийн этгээдийн ажилтны яриаг чагнах, албан байр болон орон байр, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, мөрдөн мөшгих, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой баримт сэлтийг гаргуулан авахыг хориглоно.

26.4. Өмгөөлөгчийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах явцдаа тухайн хэрэгт хамааралгүй, бусад үйлчлүүлэгчтэй холбоотой баримт сэлтийг гаргуулан авахыг хориглоно.

Харин ЭХХШТХ-ийн 5.4 дүгээр зүйлд Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах баталгааг заасан нь мэргэжлийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хамгаалахад чухал зүйл болжээ.

5.4 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулах баталгаа

1. Хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа эрүүгийн хэрэгтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс мэдүүлэг авах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгч, прокурор, мөрдөгч нь өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчтэйгээ байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг шаардахыг хориглоно.

Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ”, 29.2-д “Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл батална”, 29.3-д “Өмгөөлөгч энэ хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс төрийн байгууллага, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заасан. Өмгөөллийн тухай хууль 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд уг хууль 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Төрийн мэдээлэлд нийтлэгдсэн. Уг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хойш өмгөөлөгчид 2022 оны 11 дүгээр сард хүртэл хугацаанд өмгөөлөгчийн нэрээр шүүхэд хандах эрх нь бүрэн хэрэгжих асуудал ихээхэн бэрхшээлтэй тулгарсаар байна. МӨХ-ны Удирдах зөвлөлөөс Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг батлан гараагүй 2 жил гаруй хугацаа өнгөрсөн байна.

ГУРАВ. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүний эрхийг зөрчих, ялангуяа гэмт хэрэг мөрдөн шалгах явцад үндэслэлгүйгээр сэжигтнээр тооцох, шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, байцаалт явуулахдаа эрүүдэн шүүх, нотлох баримтгүйгээр удаан хугацаанд цагдан хорих, түүнчлэн нэгжлэг үзлэг хийх болон албадлага хэрэглэх үед хуулийг буруу хэрэглэх, хүнлэг бус харьцах, гэрч, хохирогчийн эрх, аюулгүй байдлыг алдагдуулах, шүүх хуралдааныг мэтгэлцээний бус аргаар явуулах, нотлох баримтыг зориуд дутуу үнэлэх зэрэг нийтлэг зөрчлүүд олон улс оронд түгээмэл байдлаар илэрч, тэдгээрийг таслан зогсоох талаар тэмцээр иржээ. Өөрийн эрх, эрх чөлөөнийхөө төлөө тэмцсэн үйлчлүүлэгчдэд хууль зүйн туслалцаа авахад саад болох, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг зогсоохын тулд өмгөөлөгчийг заналхийлэх, элдэв аргаар дарамтлах явдал улс орнуудад түгээмэл гарсаар байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагчаар оролцож иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө, баталгаа зөрчигдөж байгаа нь өмгөөлөгчөөс хүний эрхийг хамгаалахад тулгарч буй хамгийн гол саад бэрхшээл юм. Практик дээр өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгаа алдагдаж, эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй гарч байна.

Энэ бүлэгт Монголын өмгөөлөгчдөд тулгамдаж буй асуудлыг бодит кэйс тохиолдолд үндэслэн харуулахыг зорилоо.

3.1. КЭЙС СУДАЛГАА

Тохиолдол 1. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан өмгөөлөгч Д нь өмнө мэдүүлэг өгсөн гэрч нараас дахин мэдүүлэг авхуулах тухай хүсэлтийг 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдөр цагдаагийн ахлах мөрдөгч Б-д өгөхөөр ажлын байранд дээр нь очиж уулзахад мөрдөгч Б нь чанга дуугаар өмгөөлөгч Д-г “Чи одоо гар, би мэдэхгүй гээд байгаа юм биш үү, би дүлий бишээ сонсож байна” гэж хэлээд өрөөнөөс түлхэж гаргаж, өөр мөрдөгч С нь өмгөөлөгч Д-г заамдаж багалзуурдаад 2 давхрын коридорын хананд шахаад “Чи муу п... яаж байна” гэж хэлээд татаж түлхээд толгойгоор нь хана мөргүүлсэн, өмгөөлөгч Д-ийн амны хаалтыг татаж тастаж авснаа “Энэ муу п... чинь согтуурсан, мансуурсан юм биш үү” гэж гүтгэсэн байдаг. Улмаар өмгөөлөгч Д-г саатуулах байранд оруулж 2 цаг орчим эрүүлжүүлэхийн камерт саатуулсан. Өмгөөлөгч Д-г цааш нь Дэнжийн 1000 саатуулах байранд авчирсан байдаг бөгөөд тэнд согтуурал шалгах багаж шалгахад эрүүл гэж тогтоогдсон тул саатуулаагүй байна.

Өмгөөлөгч Д-г өмгөөллийн мэргэжлийн ажлаа гүйцэтгэж байхад нь албадан эрүүлжүүлэх үндэслэл тогтоогдоогүй байхад албадан эрүүлжүүлэх чиглэл, тушаалыг өгч, 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 14.31 цагаас 18 цагийн орчимд Эрүүлжүүлэх, саатуулах төвд саатуулсан нь хүний эрх чөлөөнд халдсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлийн 1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн шийтгэх тогтоолоор мөрдөгч Б-г гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож шийтгэсэн байна.

Тохиолдол 2. Өмгөөлөгч А нь 2021 оны 10 дугаар сарын 4-5-нд шилжих шөнө БГД-ийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангийн байрнаас эрүүгийн 210901282 дугаартай хэргийн сэжигтэн Д-г авч явах зорилгоор “Хууль бус баривчилгаа явагдаж байна, хүнээ авъя” гэх зэргээр яллагдагч Э нарыг уриалж, улмаар албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэн эсэргүүцсэн гэмт хэрэг үйлдэхэд зориуд хүргэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулийн

тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна.

Өмгөөлөгч А нь 2021.10.22-ны өдөр “Өдрийн сонин”-нд өгсөн ярилцлагадаа⁶¹ : “Аравдугаар сарын 4-5-нд шилжих шөнө клубхаус дээр 200 орчим хүн өрөө нээгээд ярилцаж байсан. Тэнд Д орж ирээд 10 орчим минут болж байхад баривчилгаа болоод явчихсан. Д өөрөө “Намайг гэрийн гаднаас баривчлаад явж байна” гэсэн бөгөөд цаана нь мөрдөгч байцаагчид бололтой хүмүүс “Хойшлуулшгүй ажиллагаа явагдаж байна. Очиж мэдүүлэг өгнө, та дагаад яв” гэх нь сонсогдсон. Тухайн өдөр улс орон даяар фейсбүүк, инстаграм тасарчихсан үе, түүнийг ашигласан уу, гэнэт ийм баривчилгаа болсон.

Шөнийн 01:00 цаг өнгөрч байхад Д надаас өмгөөллийн туслалцаа хүссэн ба өмнө нь би Д-ийн зөрчлийн хэрэг дээр өмгөөлөгчөөр ажиллаж байсан учир хүсэлтийн дагуу нийслэлийн Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс дээр яваад очиход намайг үйлчлүүлэгчтэй уулзуулаагүй. Ямар ч шалтгаангүй хагас цаг орчим хүлээлгэж, эцэст нь хуулийн шаардлага тавьж байж дээш гартал зөрүүлээд Д-г Цагдан хорих 461 дүгээр анги руу аваад явчихсан. Өмгөөлөгч хүн Өмгөөллийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиараа нэн даруй үйлчлүүлэгчтэйгээ уулзах, ямар нэгэн саадгүйгээр нэвтрэх ёстой. Өмгөөлөгчгүй аваад явсан нь хууль бус үйл ажиллагаа явагдаж байгаа гэх хардлага төрүүлсэн. Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах нь хүний эрхийн хамгийн том баталгаа. Өмгөөлөгчийн үйл ажиллагааны ч том баталгаа. Энэ хоёр үндсэн эрх тэр үед зөрчигдсэн. Би Д-ийн араас 461 дүгээр анги руу очиход гадна нь хэсэг залуус хууль ёс шаардаж байсан. Би ч үнэмлэхээ үзүүлээд дотогш нэвтэрсэн. Намайг ороход энгийн хувцастай хүн “Өөрөө өмгөөлөгч нь үү, түр хүлээж бай, удахгүй уулзуулна” гээд хүлээлгэсэн. Энд бас л хууль зөрчигдөж байгаа юм. Нэлээд байсны эцэст эмчийн үзлэгийн өрөөнөөс Д “Би энд байна” гээд орилсон нь шөнийн 02:00 цаг өнгөрч байсан үе ба, яг түүнтэй давхцаад шүүхийн шийдвэрийнхэн “Хүнээ аваарай, явууллаа” гээд Д-г гаргаад ирсэн.

⁶¹ <https://dnn.mn/>

Прокурорын тогтоолгүй, баривчлах зөвшөөрөлгүй хүнийг цагдаа нар баривчлаад аваад ирсэн учраас шүүхийн шийдвэрийнхэн хуулиа мөрдөөд гаргасан ба гадна байсан залуус Д-г гаргаад ирэхэд бүчиж аваад гарсан ийм л үйл явдал болсон, би тэр үед хөндлөнгөөс хараад зогсож байсан хүн” гэж ярьсан.

Нийслэлийн прокурорын зүгээс эрүүгийн хэргийг шалгах явцад яллагдагч А нь хуулийн байгууллага өөрийнх нь үйлчлүүлэгч Д-г хууль бусаар баривчилсан гэж үзсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу холбогдох албан тушаалтанд гомдол, хүсэлтээ гаргаж, өмгөөллийн үйлчилгээ явуулаагүй нь түүнийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл болохгүй юм. Өмгөөлөгчийн зүгээс тухайн үед Цагдан хорих 461 дүгээр ангид хамт очсон Э нарын хууль сахиулагчийг эсэргүүцсэн, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан хууль бус үйлдлийг таслан зогсоох, анхааруулах, тэдэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй нь хуульчийн хувьд ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл байна. Яллагдагч А-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэрэг үйлдсэн эсэх нь эргэлзээтэй гэж үзэж түүнд холбогдох хэргийг гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн прокурорын тогтоолоор⁶² хэрэгсэхгүй болгожээ.

Тохиолдол 3. 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн орой жагсаал, цуглааны үед баривчлагдсан иргэдэд хууль зүй туслалцаа үзүүлэхээр МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч Г.Төгсбаяр, Ч.Өнөржаргал, А.Пүрэвдулам нарын 10 гаруй өмгөөлөгчид нэгдэж, 4 сарын 9-ны өдрийн өглөө 09.00 цагт Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Түр саатуулах 111 дүгээр төв дээр очсон байна.

Энэ талаар өмгөөлөгч Г.Төгсбаяр 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр medee.mn сайтад өгсөн ярилцлагадаа⁶³ “Түр саатуулах

⁶² Нийслэлийн Прокурорын газрын прокурорын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 57 тоот тогтоол

⁶³ <https://www.medee.mn/p/169383>

байран дээр анх биднийг очиход үүдний харуулууд “Тус төвд саатуулагдсан этгээд байхгүй” гэж мэдэгдсэн ч удалгүй тус төвийн удирдлагууд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийсний дагуу бид саатуулагдсан хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор дотогш нэвтрэх хүсэлт гаргасан юм. Гэтэл бидний өөдөөс “Хүний эрхийн үндэсний комиссоос зохих албаны хүмүүс ирсэн, энд хүний эрх зөрчигдсөн асуудал байхгүй” гээд оруулахаас дахин татгалзсан. Биднийг очих үед хүүхдүүд нь саатуулагдсан гэсэн таван хүн гадна байсан. Гадаа хүлээж байсан ар гэрийнхний хүсэлтээр таван иргэнийг өмгөөлөх хүсэлт гаргахад өмгөөлөгчдийг оруулаагүй. Уг нь саатуулагдсан иргэн эрх зүйн туслалцаа авах эрхтэй шүү дээ гэжээ. Энэ үеэр бичиг баримтаа шалгуулж, өмгөөлөгчийн эрхээ хэрэгжүүлэн хууль ёсны шаардлага тавьж, хууль зүйн туслалцаа үзүүлэхээр орох гэсэн өмгөөлөгч нарыг нэвтрүүлээгүйн дээр биед нь халдаж, түлхэж гаргасан байна.

Эдгээр баримт, жишээ бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэн, түүний өмгөөлөгчид тохиолдож буй нийтэд илэрхий болсон зөрчлийн үйл баримт юм, гэвч ил тод болоогүй нуугдмал зөрчил, дутагдал цөөнгүй.

Иймд Үндсэн хуульд заасан иргэний хууль зүйн туслалцаа авах эрх, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгаа, түүний бодит практик хоёр ихээхэн зөрүүтэй, гарч буй зөрчил, дутагдал нь ноцтой байгаа нь өнөөдөр хүний эрхийн тулгамдсан асуудал болоод байна.

Тохиолдол 4. Өмгөөлөгчид нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах асуудал практик саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Өмгөөлөгч, нэхэмжлэгч Б.Анирмаа, Б.Наранцэцэг, Б.Баялагмаа, Э.Энхцэцэг нар Эрүүл мэндийн яам болон Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2020 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжийн хэмжээ, тэдгээрийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд шилэн дансанд мэдээлэхгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, 2020, 2021 оны хандив, тусламжийн хэмжээ, тэдгээрийн зарцуулалтыг хууль заасны дагуу иж бүрэн, ойлгомжтой, тогтоосон

хугацаанд шилэн дансанд мэдээлэхийг Эрүүл мэндийн яам болон Халдварт өвчин судлалын үндэсний төвд даалгах, хуульд заасан хугацаанд шилэн дансны мэдээллийг олон нийтэд хүргэх үүргийг биелүүлээгүй Шилэн дансны тухай хуулийн 7.1-д заасан буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхийг Эрүүл мэндийн сайдад даалгах нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан байна. Анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 12 дугаар сарны 10-ны өдрийн “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” 9884 дүгээр захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байдаг. Уг захирамжид давж заалдах гомдол гаргасан байдаг боловч дээд шатны шүүхээс захирамжийг хэвээр үлдээсэн байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №221/ШТ2022/0020 Магадлалд “Нэхэмжлэгч нар Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д заасан эрхийн хүрээнд буюу өмгөөлөгч энэ хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс “Эрүүл мэндийн яам болон Халдварт өвчин судлалын үндэсний төвийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжийн хэмжээ, тэдгээрийн зарцуулалтын мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэхгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгох” нэхэмжлэлийг гаргасан хэмээн тайлбарласнаас үзвэл нэхэмжлэгч нарын маргаж буй асуудал дээр дурдсан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн шүүхэд нэхэмжлэл гарах эрхтэй байхаар хуулиар тогтоосон асуудлын хүрээнд буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “... хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах” гэж заасан хуулийн зохицуулалтад хамаарахгүй байх тул нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлгүй, энэ талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй.” байна гэж дурджээ.

Тохиолдол 5. Өмгөөлөгч М-г Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эрүүлийн

офицер, цагдаагийн ахмад Л нь 2020 оны 9 дүгээр сарын 4-ны өдрийн №0029428 шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 15.29 дүгээр зүйлийн (Өмгөөллийн тухай хууль зөрчих) 2-т зааснаар 500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулжээ. Тэрээр өмгөөлөгч М-ийг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийг хүртэл хугацаанд олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр эцэслэн шийдвэрлэгдээгүй зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаар бусдад буруу ташаа ойлголт түрүүлэхүйц мэдээ нийтлэлийг удаа дараа түгээсэн гэж буруутгасан бөгөөд уг зөрчлийн хэрэг шалгах явцдаа өмгөөлөгч М-ийн гар утаст үзлэг хийж, дуудаж мэдүүлэг, тайлбар авч мэргэжлийн үйл ажиллагааны баталгааг алдагдуулсан байна. Зөрчлийн шийтгэвэрт гомдол гаргаж шүүхээс уг шийтгэврийг хүчингүй болгосон байдаг.⁶⁴ Гэвч бодит байдал дээр өмгөөлөгч М-ийн мэргэжлийн үйл ажиллагаа зөрчигдсөн, хязгаарлагдсан нь үнэн бөгөөд өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа хангагдаагүй.

Өмгөөллийн тухай хуульд “Өмгөөллийн үйл ажиллагаа” гэж өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийнхээ эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Дээр дурдсан тохиолдлын тухайд цагдаагийн байгууллага өмгөөлөгч нарт Өмгөөллийн тухай хуулийн 13.1.2, 13.1.4, 13.4.4-т заасан эрхээ эдлэх боломж бүрдүүлээгүй, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан байна.

⁶⁴ Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 1-ны өдрийн №2020/ЗШ/1237 Шийтгэвэр

3.2. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ НИЙТЛЭГ АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 (3) (d), Хүний эрхийн тухай Америкийн Конвенцын 8 (2) (d), Хүний эрхийн тухай Европын Конвенцын 6 (3) (c) дүгээр зүйлүүдэд эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа хүн бүр өөрийгөө өмгөөлөх буюу сонгосон хуульчаараа өмгөөлүүлэх эрхтэй болохыг баталгаажуулсан байна. 14 дүгээр зүйлийн талаарх Ерөнхий Тайлбар №13-т, Хүний Эрхийн хороо “яллагдагч буюу түүний өмгөөлөгч айж эмээхгүйгээр хичээнгүй өмгөөлөх бүх боломжийг ашиглах, хэрэв хэрэг шүүх ажиллагааг шударга бус явагдаж байна гэж үзэж байгаа бол маргах эрхтэй. Хэрэв үндэслэлтэй шалтгаанаар онцгой тохиолдолд яллагдагчийг шүүх хуралд оролцуулахгүйгээр хийвэл өмгөөллийн бүх эрхийг нь хатуу чанд биелүүлэх шаардлагатай” гэж онцлон тэмдэглэсэн. Хууль зүйн туслалцаа авах эрхийг бодитой хангах ёстой бөгөөд хэрэв ийм бололцоо олгоогүй бол 14 (3) дахь заалтыг зөрчсөнд тооцно гэж Хүний эрхийн хороо дүгнэжээ.⁶⁵

Өмгөөлөгч, хуульчийн мэргэжлийн сургалтад Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний үндсэн эрх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь үндсэн эрх, өмгөөлөгчийн мэргэжлийн эрх чөлөө, мэргэжлийн үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах баталгаа, эрхийн олон улсын баримт бичгийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр дутагдаж байгаа бөгөөд өмгөөлөгч нарт зориулсан сургалтын хөтөлбөр, бодлогын хүрээнд өмгөөлөгчийн мэргэжлийн эрх чөлөөний үндсэн ойлголт, өмгөөлөгчийн мэргэжлийн олон улсын стандарт, жишиг, зарчим, шударгаар шүүгдэх эрхийн тухай, нотлох баримтын онол, арга зүй, нотлох баримт цуглуулах эрх зүйн боломж, арга зүй, мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай юм.

⁶⁵ Хүний эрхийн Дээд Комиссарын алба, Олон улсын Барын холбоо, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, Шүүгч, прокурор, өмгөөлөгчид зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 265 дахь тал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ажиллагаанд мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад өмгөөлөгчтэй ёс бусаар харьцах, эд зүйлс, биед нь үзлэг, нэгжлэг хийх, хуульд заасан эрхийн хүрээнд хэргийн материалтай танилцах эрхийг хязгаарлах, өмгөөлөгчийн гаргасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдлыг шийдвэрлэхгүй орхих, гомдлыг шийдвэрлэх хугацаанд зохих хариуг өгөхгүйгээр шүүхэд хэргийг шилжүүлэх зэрэг асуудлууд шүүхийн өмнөх шатанд гарсаар байна. Тухайлбал:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хүний эрхийг зөрчих, өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх процессын баталгааг эдлүүлэхгүй, хязгаарлах цаашлаад Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй байх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхийг эрх бүхий албан тушаалтнаас гаргасан дүрэм, журмаар хязгаарлаж, хууль зөрчих явдал газар авсаар байна. Тухайлбал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт “...хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах”, 2.6 дахь хэсэгт “... өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж завсар оруулах хүсэлт гаргах”, 2.9 дахь хэсэгт “... хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах” талаар хуульчилсан байхад мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд өмгөөлөгчийн утас болон электрон хэрэгслүүдийг хураан авч “хуулбарлан авах” хуульд заасан дээрх эрхийг хязгаарлаж байгууллагын дотоод журам, даргын заавар, тушаал биелүүлж буй нэрээр хуулиас давсан тодорхой дүрэм, журам, зааврыг тайлбарлан хэрэгжүүлж буйг засах зайлшгүй шаардлагатай юм. Тухайлбал: АТГ болон зарим цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах албад нь өмгөөлөгчийн цүнх, гар утас, айпад, бусад техник хэрэгслүүдийг хураан авч хэргийн материалаас холбогдох хэсгийг хуульч, өмгөөлөгч хуулбарлаж авах хуульд заасан эрхийг байнга

зөрчиж, хязгаарлаж буй талаар судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн дийлэнх нь санал, хүсэлт гаргаж практикт нэг мөр жишиг тогтоох талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, боловсронгуй болгох нь зайлшгүй шаардлагатай гэдгийг судалгааны багт удаа дараа гаргаж, саналаа дэмжиж байсан.

2. Сэжигтэн, яллагдагч ямар хэрэгт сэжиглэгдэж, яллагдаж, шаллагдаж байгаага мэдэх эрхтэй боловч практикт бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал “Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоол” дунджаар 3-10 хуудас байдаг ба үүнийг хуулбарлан өгдөггүй, ЭХХША-г эрхлэн явуулж буй субъектээс уншаад танилцах чиглэл өгч, хуулбарлаж авах эрхгүй, хувилж өгөхгүй, үл ойлголцол гарч байх тул цаашид уг тогтоолыг хувилж өгдөг байхаар эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй байна. Мөрдөгчийн магадлагааг хувилж хуулбарлаж авч болдоггүй, шинжээчийн дүгнэлтэй танилц гэсэн зохицуулалт байхаас магадалгаа гэж байхгүй гэж хууль зүйн зохицуулалтыг өөрийнхөө үзэмжээр буруу ойлгон тайлбарлаж хэрэглэж буй байдал практикт байсаар байна.

Нэгэнт мөрдөгчийн магадалгааг шинжээчийн дүгнэлттэй адилтгаж үзэж байгаа тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж шаардлагаар адил тэгш байх боломж нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Иймд энэ талаар албан ёсны тайлбар гаргаж практикт хэрэгжүүлэх нь ач холбогдолтой байна.

3. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах ажиллагаа нь хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдах бөгөөд практикт хөөн хэлэлцэх хугацааг дуусахаас өмнө хэт нэг талыг барьж, яллах хангалттай нотлох баримтууд бүрдүүлэхгүйгээр, хүний эрхийг зөрчиж, үндэслэлгүйгээр яллагдагчаар татдаг, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж буй байдал газар авсан байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж заасан тул хөөн хэлэлцэх хугацааг дуусгахаас өмнө хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан

тогтоолд өмгөөлөгчөөс гомдол гаргасан тохиолдолд хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн, бодитойгоор нотолбол зохих байдлуудыг тодруулалгүй зөвхөн яллах талаас хандаж гомдолд дурдсан үндэслэлд бодитой хариу өгдөггүй зөвхөн шалгаж байна, хянаж байна, үндэслэлгүй байна гэх цөөн өгүүлбэрээр хариу өгдөг байдал хавтгайрчээ.

4. Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж гаргаж буй хүсэлт, гомдолд эрх бүхий субъектүүдээс үндэслэл бүхий хариу өгөх үүрэгтэй ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй субъектээс хэтэрхий ерөнхий хариу өгөх, ойлгомжгүй байдлаар тайлбарлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна гэдгээр шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгөх байдал нийтлэг практик болж тогтсон байна.

5. Мөн ЭХХША-нд гомдол шийдвэрлэх хугацаа хэтэрхий удаан /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ»/ прокурорын шатанд гомдол гаргахаар хэргийг яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлдэг практик тогтсон, мөрдөгч, прокурорын ёс зүй, мэргэжлийн хариуцлагыг журам, дүрэмд өөрчлөлт оруулах асуудал тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд шүүгчтэй адил, шүүгчийн ёс зүйн дүрэмтэй харьцуулах, прокурорын хуульд шинжлэх ухааны үндэслэлтэй нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

6. Прокурор, шүүгч, мөрдөгч мэргэжлийн ямар ч алдаа гаргасан хариуцлага хүлээдэггүй энэ талаар хуульд хариуцлагын механизмыг тодорхой хуульчилж өгөөгүйгээс хүний эрх зөрчигдөх тохиолдол гарсаар байна.

7. ЭХХШтХ-ийн 1.13 дугаар зүйлийн 1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй” гэж заасан боловч уг заалт өнөөдрийг хүртэл практикт ашиглагдаагүй, Улсын Дээд шүүхээс тус зүйл заалттай холбогдуулан

ямар нэг тайлбар хийгээгүй, хуульчид энэ талаар төдийлөн нэгдмэл ойлголттой бус байна. Цаашид энэ талаар албан ёсны тайлбар хийж уг зохицуулалтыг бодитойгоор хэрэгжүүлэх шаардлагатай.

8. ЭХХШтХ-ийн 9.6 дугаар зүйлийн 1–д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд хэрэгт сэжиглэгдэж байгаа хүний гэрчээр мэдүүлэг авч тодорхой хугацаа өнгөрсний дараа яллагдагч болгох нь иргэний өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуульд заасан эрхийн ноцтой зөрчил мөн. Гэрчээс мэдүүлэг авахдаа өмгөөлөгч авах эрхийг тайлбарлаж өгдөггүй, зөвхөн гарын үсэг бланк дээр зуруулдаг, эрх үүргийг нь сайтар тайлбарлаж өгдөг явдал хангалтгүй, хуулийн мэргэжлийн хүмүүс биш тул бичсэн зүйлийг уншаад сайн ойлгохгүй байдаг, эрх, үүргийг өмгөөлөгчөөр тайлбарлуулах асуудлыг хуульд тодорхойлон заах, өмгөөллийн тактик, ур чадварыг нь нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрүүд шаардлагатай.

9. Хэргийн материалтай танилцах хугацаа богино, ихэвчлэн тулгаж танилцуулдаг байдал газар авсан. Мөрдөн шалгах ажиллагаа дуусаж, прокурорт хэргийг шилжүүлсний дараа прокурор дээр хэргийн материалтай хагас дутуу танилцуулаад гомдол хүсэлт гаргах эрхийг хугацаагаар хязгаарлаж, хэргийг шууд шүүхэд шилжүүлж байна. Иймд мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн материалтай танилцах хугацааг тусад нь зааж хуульчлах, тэрхүү хугацааг боломжит хангалттай байдлаар зааж өгөх, түүний дараа хэргийг прокурорт шилжүүлдэг болох процессыг нэмж хуульчлах нь ач холбогдолтой. Өмгөөлөгчдийн хувьд мөрдөгчийн бүрдүүлсэн материалыг араас нь хөөх байдлаар өмгөөллийн үйлчилгээ явуулж байгаад судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн дийлэнх нь шүүмжлэлтэй хандаж байлаа.

10. Мөрдөгч нарын хувьд шинжээчийг өөрөө томилдог байдал нь хэргийн оролцогчдын хувьд хардах, тухайн дүгнэлтийг зөвшөөрөхгүй байхад нөлөөлж байна.

11. Манай эрх зүйн тогтолцооноос шалтгаалан өмгөөлөгч буюу өмгөөлөх тал нотлох баримтыг цуглуулах эрх эдэлдэггүй. Тодорхой

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоолгох, түүнчлэн үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн дээр эрх бүхий субъектэд хандаж өмгөөлөгч хүсэлт гаргаж болно. Хүсэлт гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тухайлсан ажиллагаа явуулж хэргийг алагчлалгүй шийдвэрлүүлэхийн тулд ач холбогдолтой хэмээн үзсэн нөхцөл байдлыг шалгуулах, авагдсан баримтат мэдээллүүдийг нягтлуулах, түүнчлэн хуульчлагдсан эрх ашиг сонирхлоо хамгаалуулахаар мөрдөгч, прокурор, шүүхэд гаргаж буй хууль ёсны шаардлага юм.⁶⁶


Хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэг бүхий прокурор нь шүүх хуралдааны үед улсын яллагч болдог. Өмгөөлөгч нь мэтгэлцээний эсрэг тал болох прокурорт өөрийн өмгөөллийн тактик, хэргийн онолоо шүүхээс өмнө дэлгээд байх нь төдийлөн ашиггүй. Өөрөөр хэлбэл аливаа маргаан эргэлзээтэй асуудлынхаа талаар өмгөөлөгч өөрийн санал, дүгнэлтээ шүүх, /шүүгч/-д шууд хүргэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар хуульчлах нь хүний эрхийг хангаж хамгаалах, аливаа зөрчил, гажуудлыг таслан зогсоох баталгаа төдийгүй Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх сайн талтай юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд мэтгэлцэх зарчим үйлчилдэг байх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид хувийн мөрдлөгийн зарчмыг өмгөөлөгч хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох нь зүйтэй.

Монгол Улсын хэмжээнд шүүхийн өмнөх шатанд хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт шийдвэрлэсэн байдлаар авч үзэхэд 2015 онд 6114 хүсэлт гаргаснаас бүрэн хангасан нь 30 хувийг буюу 2236, хэсэгчлэн хангасан 425, хангахаас татгалзсан 3288, 2016 онд 6352 хүсэлт гаргаснаас бүрэн хангасан 2469 хэсэгчлэн хангасан 460, хангахаас татгалзсан 3191, 2017 онд 5627 хүсэлт хүлээн авснаас 2336 бүрэн хангаж, 375 хүсэлтийг хэсэгчлэн хангасан, 3016 хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн байна⁶⁷.

⁶⁶ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан “Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал” УБ., 2018 он 41 дэх тал

⁶⁷ Улсын Ерөнхий Прокурорын газрын статистикийн мэдээлэл 2015, 2016, 2017 он

График 1. Шүүхийн өмнөх шатанд хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийн шийдвэрлэлт



Гомдол гаргах нь нэг талаас хэрэгт холбогдсон этгээд өөрийгөө хамгаалах хэрэгсэл болж байдаг бол нөгөө талаас тухайн хэргийг мөрдөн шалгаж, шүүн шийдвэрлэж байгаа албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэднийг хуулийн дагуу шударгаар ажиллахад нь нөлөөлөх гол хэрэгсэл юм. ЭХХШ ажиллагаа бүрэн бус эсхүл хууль зөрчиж явагдсаны улмаас үйлчлүүлэгчийн эрх ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд тэрхүү зөрчлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгуулах, цаашид тийм зөрчил гаргуулахгүй байх талаар шаардсан өргөдөл гэж томъёолж болно.⁶⁸ Эрүүгийн процесс дахь гомдлыг дараах төрлүүдэд хуваан авч үзэж болно.


1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл
2. Процесс ажиллагаа, шийдвэрт гаргах гомдол
3. Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрт гаргах гомдол

Улсын хэмжээнд шүүхийн өмнөх шатанд хэргийн оролцогчдоос гаргасан гомдлын шийдвэрлэлтийг сүүлийн гурван жилээр авч үзэхэд 2015 онд 10553 гомдол бүртгэгдсэнээс гомдлыг хүлээн авахаас татгалзсан нь 5543, хүлээн авсан 1732, хүлээн авч, өмнө нь гаргасан

⁶⁸ Б.Бат-эрдэнэ “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй ерөнхий анги” УБ., 2006 он 27 дахь тал

шийдвэр үйл ажиллагааг өөрчилсөн 102, гомдлыг хүлээн авах 1362, гомдлыг хүлээн авч, өмнө гаргасан шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгосон 752, 2016 онд 9109 гомдол бүртгэгдсэнээс гомдлыг хүлээн авахаас татгалзсан нь 5454, хүлээн авсан 1398, хүлээн авч, өмнө нь гаргасан шийдвэр үйл ажиллагааг өөрчилж 144, гомдлыг хүлээн авах 1362, гомдлыг хүлээн авч, өмнө гаргасан шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгож 902, 2017 онд 6926 гомдол бүртгэгдсэнээс гомдлыг хүлээн авахаас татгалзсан нь 4923, хүлээн авсан 983, хүлээн авч, өмнө нь гаргасан шийдвэр үйл ажиллагааг өөрчилсөн 77, гомдлыг хүлээн авах 1362, гомдлыг хүлээн авч, өмнө гаргасан шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгож 943⁶⁹ болгож тус тус шийдвэрлэсэнээс үзэхэд хэргийн оролцогчийн гомдол, хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн 30 хувь байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэг талын хүсэл зоригийн үндсэн дээр явагдаж байгаа нь дээрх судалгаанаас тодорхой харагдаж байна.

График 2. Шүүхийн өмнөх шатанд хэргийн оролцогчдоос гаргасан гомдлын шийдвэрлэлт



⁶⁹ Улсын Ерөнхий Прокурорын газрын статистикийн мэдээлэл 2015, 2016, 2017 он

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байхад хүсэлт гомдол авдаггүй, хэргийн нөхцөл байдал, мөрдөн шалгах ажиллагааны тухай өмгөөлөгч мэдээлэлгүй байдаг. Хүсэлт, гомдол гаргалгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нотолбол зохих байдлыг бүрэн тогтоолгүйгээр мөрдөгч яллах талын нотлох баримтыг цуглуулах ажиллагааг явуулсан байдаг. Энэ нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн зөрчил юм.

3.3. ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ОРОЛЦОЖ БУЙ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж хууль зүйн туслалцаа үзүүлж оролцох бөгөөд хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслийг ашиглан хэргийн онол (Case Theory) боловсруулж эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Үүнээс гадна өмгөөлөгч нь нийтийн байгууллагад хууль зүйн ач холбогдолтой баримт бичиг зохиож өгөх зөвлөгөө өгөх зэргээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ.⁷⁰

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13⁷¹-т “Оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хамааруулж, тус хуулийн тавдугаар бүлэгт “Өмгөөлөгчийн эрх, үүрэг, өмгөөлөгчийг сонгох, оролцуулах, үйл ажиллагаа явуулах баталгаа”-г тус тус хуульчилсан.

Иргэдийн хувьд “гэрч” нэртэй ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэхгүй “сэжигтэн” яваад байдаг. Гэрчийн эрх, үүрэг өөр, өөрийгөө өмгөөлөх эрхийн асуудал яригдахгүй. Статус тодорхой бол ямар хэрэгт сэжиглэгдэж шалгагдаж байгаагаа эрт мэдэж, өөрийгөө өмгөөлөх эрхээ шаардах боломжтой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

⁷⁰ Ред. Ж.Амарсанаа “Эрх зүйн мэдлэгийн товч толь” УБ., 1986 он. 109 дэх тал

⁷¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2015 он

ажиллагаанд гол оролцогч атлаа эрх үүрэг нь тодорхой бус оролцогч “сэжигтэн”-ий эрх зүйн байдлыг тодорхойлох, тухайлбал сэжигтэн нь дээрх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох үүрэг хүлээж буй хуулийн хийдлийг арилгах зохицуулалт хийх буюу сэжигтнээс мэдүүлэг авах, эрх, үүргийг нь танилцуулах тодорхой заалтыг хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.⁷²

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.” гэж тодорхойлсон. ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталж, иргэнийг баривчлах, цагдан хорих тогтолцоогоо олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа уялдуулах зорилготой хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Шинэчлэгдсэн ЭХХШТХ-ийн дагуу цагдаагийн байгууллагад сэжигтнийг цагдан хорих хугацаа 6 цагаас илүүгүй байна гэж заасан ба сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах дээд хугацаа 72 цаг байсныг 48 цаг болгон бууруулсан нь сайшаалтай.⁷³ Цаашилбал, баривчлах ажиллагаа явагдсаны дараа цагдан хорьсон байгууллага нь прокурорт нэн даруй мэдэгдэх⁷⁴ бөгөөд прокурор сэжигтнийг үргэлжлүүлэн хорих талаар шүүхээс зөвшөөрөл авах ёстой.

Баривчилснаас хойш 48 цаг дуусаж, сэжиглэгдэж байгаа хүнд цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга холбогдох байгууллагад мэдэгдэж, түүнийг суллана.⁷⁵ Сэжигтнийг цагдан хорих тухай шүүгчийн шийдвэр нь оргон зайлах эрсдэл, нотлох баримтыг өөрчлөх, хэргийн оролцогч хүмүүст хохирол учруулах болон хуульд дурдагдсан шалтгаан зэрэг бодитой

⁷² Б.Өнөрмаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “Сэжигтэн”-ий талаархи зохицуулалтыг ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /StPO/ зохицуулалттай харьцуулах нь, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 6 дахь тал

⁷³ НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, 2014 оны 35 дугаар Ерөнхий тайлбар зөвлөмж

⁷⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 30.9

⁷⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 31.12.2

үндэслэлд суурилсан байх ёстой.⁷⁶ Өмнөх хуулиар шүүгчид нь шүүх хурал хийхгүй үргэлжлүүлэн хорих шийдвэрийг гаргадаг байсан бол одоо сэжигтэн, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан шүүхийн хэлэлцүүлэг явуулдаг байхаар хуульд зааж өгсөн байна. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүнийг баривчилсан, саатуулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 13.9-д зааснаар түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл ногдуулдаг.

2017 оны ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулга нь сэжигтэнд цагдан хорих үндэслэлийг эсэргүүцэх, хууль бус баривчилгаанаас зайлсхийх боломж өгсөн зэрэг эерэг өөрчлөлтүүд авчирсан ч хэрэгжилт учир дутагдалтай байна.

2022 онд гаргасан НҮБ-ын Дур зоргоор саатуулахтай тэмцэх тусгай илтгэгчийн урьдчилсан тайланд дараах мэдээллийг дурдсан байна. Үүнд:

- Цагдаа нар анхнаасаа иргэдийг цагдаагийн хэлтэс рүү гэрчээр дуудах нь хэвийн үзэгдэл бөгөөд дуудагдсан хүмүүс үнэн хэрэгтээ чөлөөтэй явах эрхгүй байдаг. Ийм нөхцөлд цагдаагийн хэлтэст бүтэн өдрийг өнгөрөөж байсан боловч энэ хугацааг хуульд заасан 6 цаг болон 48 цагт албан ёсоор тооцдоггүй.⁷⁷
- Цагдаагийн газарт хүмүүсийг гэрчээр мэдүүлэг өгнө үү хэмээн дууддаг ч тухайн хүнээс мэдүүлэг авах үед тавьж буй асуултуудаас нь түүнийг сэжигтнээр тооцож байгаа нь тодорхой болдог байна. Үүнээс болж сэжигтэн нь өмгөөлөгчтэй зөвлөлдөх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг чухал хамгаалалтаа ашиглаж чадахгүй байж болзошгүй юм.
- Бодит байдал дээр дийлэнх тохиолдолд цагдаагийн албадан саатуулах хугацаа нь зөвшөөрөгдсөн дээд хэмжээ буюу

⁷⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 31.4

⁷⁷ Нэгдсэн Үндэсний байгууллагын дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт (2022 он)

48 цагаас хэтэрсэн тохиолдлууд байгааг онцолж байна. ЭХХШТХ хүчин төгөлдөр болсноос хойш таван жил өнгөрч байгаа хэдий ч ийм зөрчил дутагдал гарсаар байгаа тухай удаа дараа дурдагдсан тул Засгийн газраас ЭХХШАны хэрэгжилтийг яаралтай байдлаар шалгаж үзэхийг Ажлын хэсэг хүсэж байна.

- Цагдаагийн байгууллагад хоригдох сэжигтнүүдээс цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөөнд мэдүүлэг авч байгаа тухайд сэжигтнүүд ихэвчлэн мэдүүлэг өгсний дараа явах эрхгүй байдаг талаар Ажлын хэсэг мэдээлэл авсан. Мэдүүлэг авсны дараа тэднийг ихэвчлэн албан ёсоор баривчилж, цагдан хорих байр луу шилжүүлдэг. Олон улсын хүний эрхийн хуульд “хүн өөрийнх нь сайн дурын зөвшөөрөлгүйгээр саатуулагдсан”⁷⁸ тохиолдолд тухайн хүний эрх чөлөөг нь хассанд тооцдог.
- Эрх чөлөөгөө хасуулсан хугацаа нь цөөн цаг байсан ч, үргэлжлэх хугацаанаас үл хамааран, үүнийг саатуулсанд тооцно. Монголын нөхцөлд хэрэв сэжигтэн мэдүүлэг өгөх үйл ажиллагаанаас гарах эрхгүй бол тухайн сэжигтэн цагдаагийн хэлтэс дээр ирж, тухайн мөрдөгчийн хяналтад орсон мөчөөс хойш саатуулагдсанд тооцогдоно. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдүүлэг авах өрөөнүүд дүрс, дууны бичлэг хийхээр тоноглогдсон байх ёстой байдаг ба энэ нь зүй бус харьцах, эрүүдэн шүүх зэрэг ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал хүчин зүйл болдог. Гэсэн хэдий ч энэ нь олон улсын хүний эрхийн хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрэн эрхээ эдлэх хангалттай боломжийг сэжигтэнд олгож чадахгүй байна.
- Хамгийн гол нь түр хоригдсоноос хойш 48 цагийн дотор шүүхэл хандах эрх нь эрх чөлөөгөө хасуулсан мөчөөс эхлэн хэрэгждэг ба хоригдогчийг нэг төрлийн байрнаас нөгөө рүү шилжүүлсэн тохиолдолд уг хугацаа шинээр тоологдож эхлэхгүй. Зөрчил гаргасан хүнийг эхлээд эрүүлжүүлэх байранд албадан

⁷⁸ A/HRC/36/37, para 51. See also CCPR/C/GC/35at para.

эрүүлжүүлээд, дараа нь цагдаагийн мэдэлд шилжүүлсэн тохиолдолд хүндрэлтэй асуудал үүсдэг гэдгийг Ажлын хэсэг тэмдэглэж байна. Учир нь хүнийг эрүүлжүүлэх байранд 24 цаг хүртэл хугацаагаар байлгаж болдог, харин цагдаагийн хэлтсийн түр хорих байранд 48 цаг хүртэл саатуулж болдог. Ийм тохиолдолд тухайн хүнийг эрүүлжүүлэх байрнаас цагдаагийн хэлтэс рүү шилжүүлэхдээ хугацааг (48 цагийг) шинээр тооцож эхэлдэг нь хэвийн үзэгдэл болсон бөгөөд энэ нь бодит саатуулах хугацааг зөвшөөрөгдсөн 48 цагаас хэтрүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

- Шүүгчид амралтын өдрүүдээр ажилладаггүй учир хэрэв тухайн этгээд Баасан гарагт саатуулагдсан бол 48 цагийн хязгаарлалтыг дагаж мөрдөхөд хүндрэл үүсдэг байна. Энэ байдлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай. Ажлын хэсэг хэд хэдэн байршилд үйл ажиллагаа явуулж буй эрүүлжүүлэх байртай танилцсан ба эдгээр байрууд ерөнхийдөө энгийн боловч эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг тодорхой зориулалтын өрөөнүүдтэй болохыг тэмдэглэсэн.
- Саатуулагдсан этгээдүүдийг зөвшөөрөгдсөн дээд хязгаар болох 24 цагийн дотор суллаж, эрүүл мэндийн үзлэгт 5-7 хамруулж, тэмдэглэл хөтөлдөг болох нь бүртгэлийн дэвтрээс харагдсан ба бүх эрүүлжүүлэх байранд хяналтын камерууд ажиллаж байсан. Гэвч долоо хоног хүртэл дараалан үргэлжилдэг тодорхой улсын баяр ёслолын үеэр саатуулагдсан этгээдүүдийг зарим эрүүлжүүлэх байранд 24 цагаас илүү хугацаанд байлгасан, мөн ЛГБТИ хүмүүс хэл ам, бие махбодын хүчирхийлэлд өртөх тохиолдол цөөнгүй гардаг тухай Ажлын хэсэг олж мэдсэн ба үүнд санаа зовж байна. Тухайн этгээд эрүүлжүүлэх байранд саатуулагдах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу явагддаггүй тул эрүүлжүүлэх байрууд шийтгэх арга хэрэглэхээс зайлсхийх нь чухал. Мөн эрүүлжүүлэх байруудад хэл ам, бие мах бодийн хүчирхийлэл үйлдэхийг бүрмөсөн хориглож, буруутай албан хаагчид хариуцлага тооцдог байх шаардлагатай.

Дээр дурдсанчлан мөрдөх чиг үүрэг бүхий субъектүүд сэжигтнийг баривчлан зарим тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасны дагуу холбогдох хүнд (ар гэр, өмгөөлөгч) мэдэгдэхгүйгээр хууль зөрчсөн ажиллагааг хийдэг байдал практикт гарсаар байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийн 1 “Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй”, Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйлийн 1 “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан” гэсний дагуу сураггүй алга болгох гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй.

Мөн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”, мөн 14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй” гэж заасан бөгөөд ЭХХША-аг явуулж байгаа эрх бүхий албан тушаалтнууд зарим тохиолдолд дээрх эрхүүдийг зөрчсөн үйлдлийг гаргасаар байгаа нь судалгааны ажлын явцад тогтоогдсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1-д “Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар дуудан ирүүлж болно. Мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй” гэж тодорхой зохицуулсан ба хуульд яллах тал давуу тал бий болгохгүйгээр тэгш эрх, хүний эрхийн хангахын тулд процессын үе шат бүрийн хугацааг нэг бүрчлэн зааж хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн мөрдөгч сэжигтнийг ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйлийн 1-д заасан үндэслэлээр баривчилсан бол 24 цагийн дотор

шүүх шийдвэрлэхээр хуульчилсан хэдий ч амралтын цаг хугацаанд жижүүрийн шүүгч ажиллуулах, асуудлыг нэн даруй яаралтай шийдвэрлэж байх тухай нарийвчилсан зохицуулалт ЭХХШтХ-д оруулах нь хуулийн хэрэгжилтийг хангаж, хүний эрхийг хамгаалахад нэн чухлаар тавигдаж байна. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд ёс зүйн болон сахилгын шийтгэл оногдуулдаг. Өмгөөлөгчийн мэргэжлийн эрх, баталгаа, хараат бус байдлыг хангах үүднээс өмгөөлөгчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдах юм бол хариуцлага хүлээх “Зөрчлийн хууль”-ийн заалт оруулах, эрүүгийн хуульд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг хуулиар хамгаалалт хийх, өмгөөллийн үйл ажиллагаа явуулж буй ажлын байр, харилцаа холбооны хэрэгсэлд халдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх баталгааг хангах, хариуцлага хүлээлгэх тодорхой механизмыг бий болгох шаардлагатай.

Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх боломжтой.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль⁷⁹-ийн 44-р бүлэгт “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” талаар хуульчилсан ба хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.⁸⁰

⁷⁹ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль. 2002 он.

⁸⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2015 он.

Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг хүн, хуулийн этгээд өөрөө, түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл тухайн хүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч гаргах ба хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 жилийн дотор шийдвэрлэдэг зохицуулалттай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”⁸¹-д заасны дагуу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болсон.

Өмгөөлөгч үйлчлүүлэгчээ цагдан хоригдсон үед уулзах, утсаар ярих эрхийг нээлттэй болгох, эд зүйл, ахуйн зүйл дамжуулж өгөх, цагдан хорих байрнаас лавлагаа өгдөг болох, 2021, 2022 онд хэдэн өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ уулзсан, цаг, ирсэн, очсон тухай тоо бүртгэл хөтөлсөн баримт албан бичгээр гаргаж өгдөг болох шаардлагатай.

⁸¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он.

ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦООНЫ АСУУДЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, таслах зогсоох, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх зорилт, чиг үүргийн хүрээнд хүний тодорхой эрхийг хязгаарлаж байдаг. Гадаадын зарим улс орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгч, түүний эрх зүйн байдал, оролцоо, нотлох процессын зарим асуудлыг Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харилцаатай харьцуулан авч үзье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шалган тогтоох зорилго, агуулга бүхий маш нарийн үйл ажиллагаа бөгөөд төрийн оролцооны императив чиг үүрэг бүхий харилцаа юм.⁸² 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь зүйл заалтыг тодорхой, дэлгэрэнгүй зааж өгснөөрөө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн ажлын удирдамж болж, түүнчлэн эрх зүйт төрийн зарчимд суурилан оролцогчдын эрхийг хангасан төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ажиллагааг богино хугацаанд хэрэгжүүлж байхаар заасан зэрэг ач холбогдолтой болсон ба үндсэн бүтэц нь эх газрын эрх зүйн тогтолцоотой Герман Улсын хуультай адил юм.⁸³

Орчин үед нотолгооны процесст өмгөөлөгч ямар байр суурьтай оролцох эсэх асуудлаар судлаачдын дунд нэлээд маргаан өрнөх болсон бөгөөд энэ нь сүүлийн үед анхаарал татах сэдэв болсон.

Гадаадын судлаачдын зонхилох хэсгийн үзэж байгаагаар өмгөөлөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

⁸² Д.Баярсайхан, Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, чиг хандлага, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 6 дахь тал

⁸³ Бернд Шюнемани, 2002 оны Монгол Улсын ЭБШХ-д хийх шинжлэх ухааны тайлбар, УБ., 2003 он

харилцаанд идэвхгүй оролцогч биш харин хэрэгжүүлэгч субъектийн нэг бөгөөд нотлох баримтыг цуглуулах, шалгахад оролцох эрх эдлэхээс гадна шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэх хуралдаанд мэтгэлцээний цагаатгах талыг төлөөлж оролцох, ингэхдээ шүүхийн процесст асуулт асуух, нотлох баримтыг шинжлэн судлах, баримт сэлт гаргаж өгөх зэрэг тодорхой эрхтэйгээр өмгөөлөл явуулах статустай байх явдал цаашид төлөвших хандлагатай байна.⁸⁴ Канадын эрдэмтэн Кент Роуж, АНУ-ын эрдэмтэн Грейг М.Брэдлэй, Английн эрдэмтэн Давид Фэйлдман нарын үзэж байгаагаар “... өмгөөллийг хэрэгжүүлж буй субъект нь хууль зүйн агуулгаараа нотолгооны үйл явцыг зохион байгуулж байгаа этгээд мөн бөгөөд өмгөөлөл нь нотолгооны үе шат бүхэнд идэвхтэй хэлбэрээр илэрч, энэхүү онцлог процесс нь яллагдаж буй аливаа этгээдийн эрхийг хамгаалах, түүнд үйлчлэх төдийгөөр хязгаарлагдахгүй, харин нотлох баримтыг олж илрүүлэх, цуглуулж бэхжүүлэх, шалган үнэлэх болон шийдвэрлэн тогтооход санаачилгатай бөгөөд нээлттэй оролцох ёстой. Энэ бүхэн нь эрүүгийн хэргийг шударга шүүхээр мэтгэлцээний замаар шийдвэрлэх урьдчилсан нөхцөл болно”⁸⁵ гэжээ. Мөн ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн 75.1-д зааснаар бол шүүхийн өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийг авахдаа өмгөөлөгч оролцуулаагүй бол нотлох баримтад тооцохгүй байх, гэрч нь мэдүүлэг өгөхдөө нотолгооны баримттай тодорхой эх сурвалжийг нэрлэж заагаагүй бол нотлох баримт гэж үзэхгүй байх зэрэг зохицуулалтыг тусгажээ.⁸⁶

ХБНГУ-ын профессор Бернд Шюнеманн: мөрдөн байцаалтын ажиллагааг талуудад нээлттэй байлгах тухай асуудал өөрөөр хэлбэл мөрдөн байцаалтын ажиллагааны явцад гэрчийг байцаахад яллагдагчийг оролцуулах тухай асуудал Европ дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэтгэлийн нэг чухал сэдэв болоод байна.

⁸⁴ Д.Баярсайхан, Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал, УБ., 2012 он, 60-64 дэх тал

⁸⁵ Criminal procedure a worldwide study. Edited by Craig M. Bradley. Carolina Academic Press 2007, p.87-89

⁸⁶ Коврига З.Ф.Новый Уголовно-процессуальный кодекс Российской Федерации: Вопросы теории и правоприменительной практики /Юридические записки Вып 4.2003/

ЭБШХ-д сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчид байцаалт болох тухай урьдчилан мэдэгдэх асуудал тодорхой зохицуулалтгүйн дээр хохирогчийн эрхийг хэт өргөжүүлсэн байдал нь прокурорын давуу эрхтэй нийлж хоёр яллах талын чиг үүрэг түлхүү гарч ирэх болсноор шүүхээс өмнөх шатанд яллагдагчийг өмгөөлөх боломж хангагдах эсэх нь эргэлзээ төрүүлж байна⁸⁷ гэжээ.

Сүүлийн жилүүдэд үндэсний болон олон улсын эрх зүйн тогтолцооны харилцан хамаарал, нөлөөлөл улам гүнзгийрч, улс орон бүхэнд шинэ нөхцөлд нийцсэн эрх зүйн рецепци хийх шаардлага бий болж байгаагаас үүдэн эрх зүйн системийн загварчлалд үндсэн өөрчлөлт гарах боллоо. Олон орны эрдэмтэд, судлаачдын харьцангуй олонхын үзэж байгаагаар эрх зүйн системийн загвар, бүлийн талаар дараах хандлагыг сүүлийн үед хүлээн зөвшөөрөх болжээ. Үүнд: 1. Эх газрын буюу баруун Европын эрх зүй; 2. Англи-Америкийн эрх зүй; 3. Хосолсон ба холимог эрх г.м.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд эрх зүйн тогтолцооны загварчлалын хандлагыг харгалзах боловч түүний мөн чанар, агуулга, зарчим зэргийг иш үндэс болговол процессын эрх зүй талаасаа нэлээд ялгаатай авч үзэхэд хүргэдэг. Ихэнхдээ дараах шалгуурыг гол үндэслэл болгон авч үздэг ажээ. Үүнд:

1. Мэтгэлцэх арга, соёл (нотлох ажиллагаа);
2. Процессын зарчим (бодит үнэний ба оролцогчийн эрхийг хангах);
3. Эрх зүйн эх сурвалж, хууль зүйн техник;
4. Шүүхээр хэрэг шийдвэрлэх жишиг, практик г.м.⁸⁸

Дэлхийн улс орнуудад 1. Аккусацн систем, 2. Инквизици систем, 3. Хосолсон систем гэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны загвар хөгжиж ирсэн бөгөөд манай улс инквизици системд хамаардаг ч холимог системийн зарим элементийг нэвтрүүлэхийг зорих болсон байна.

⁸⁷ Ханнс Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжлэх ухааны тайлбар, УБ., 2003 он, 38, 49 дэх тал

⁸⁸ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 32 дахь тал

Инквизици систем нь хаалттай, хязгаарлалт бүхий мэтгэлцээний бус систем бөгөөд Баруун Европ, эх газрын системийн орнуудад өргөн дэлгэрсэн бөгөөд мөрдөн байцаалтаар заавал дамжин, шүүх хэргийг шийдвэрлэнэ. Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны агуулга нь чөлөөт мэтгэлцээний болон хялбаршуулсан, ял тохиролцох зэрэг процедурыг үгүйсгэдэг. Энэ загвар нь хэргийн хувь заяа нь мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслах ажиллагаа явагддаг, шүүхээс өмнөх мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байх ба өмгөөлөгчийн оролцоо нэлээд хязгаарлагдмал шинжтэй байдаг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь хэргийн бодит үнэнийг бүрэн тогтооход чиглэгдсэн байдаг, инквизицийн процесс нь хэргийн бодит үнэнийг тогтоох талыг илүү түлхүү барьж, хуульд заасан хугацаа, үе шатыг дамжин хэрэгждэг тул зарим талаар хорьж мөрдөх явцад хүний эрх зөрчигдөх, хэргийг шийдвэрлэх үйл явц сунжрах, шүүхийн тогтоол, шийдвэр олон дахин өөрчлөгдөх зэрэг үр дагавар бий болгодог.⁸⁹ Эрүүгийн хэргийн хувь заяа мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслах ажиллагаа явагддаг нь уг процессын гол онцлог юм.⁹⁰

Судлаачдын үзэж байгаагаар энэхүү тогтолцооны мөн чанар, агуулга, үзэл баримтлалыг тодорхойлж ирсэн гурван онолын үндэслэл бий. Эдгээрийг дурдвал:

1. Бодит үнэнийг тогтоох онол (Neutral theory)
2. Мөрдөн шалгах тогтолцоонд тулгуурлах үзэл (Crime control)
3. Объектив нотолгооны формаль ба материаллаг чиг үүргийг зааглан ялгах баримтлал (Formal and objective evidence)

⁸⁹ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 32 дахь тал

⁹⁰ Д.Баярсайхан, Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, чиг хандлага, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 10 дахь тал

Бодит үнэнийг тогтоох онол нь эрх зүйн төрийн буюу хууль ёсны зарчимтай салшгүй холбоотойн дээр тухайн үед үйлчилж буй хуулийн заалт хэм хэмжээнд хатуу захирагдаж хэргийн ямар ч үед бүрэн гүйцэд тогтоох шаардлагыг хангахад чиглэгдэг. Мөрдөн шалгах тогтолцоонд тулгуурлах үзэл нь бодит үнэнийг тогтоох онолын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эрүү үүсгэн яллах чиг үүргийн зайлшгүй байдлыг хамгаалах, хэргийн ангилал, төрөл, онцлогийг харгалзахгүйгээр ямар ч хэрэгт заавал мөрдөн байцаалт явуулж байж шүүхэд шилжүүлэх агуулгыг илэрхийлнэ.

Объектив нотолгооны формаль ба материаллаг чиг үүргийг зааглан ялгах баримтлал нь нотлох ажиллагааны органик ба функциональ шалгуурыг бүрэн зохистойгоор хангах нөхцөлөөр илэрдэг ба мэдүүлгэн баримт, хөндлөнгийн хамааралт баримт сэлт нь субъектив процедураас үл хамаарч бодитойгоор үнэлэгдэх зарчимд үндэслэгдэнэ. Эх газрын системийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зайлшгүй удирдлага болгох эрх зүйн зарчмуудтай. Үүнд:

1. Хуульд үндэслэгдэх буюу хуулийн дагуу байх зарчим;
2. Процессын чиг үүргийн хуваарилалтын зарчим;
3. Яллах чиг үүргийн давуу байдлын зарчим;
4. Хэргийг үе шаттай хянан шийдвэрлэх зарчим;
5. Нотолгооны бодит үнэнд нийцүүлэх зарчим;
6. Гэм бурууг зөвхөн шүүх тогтоох зарчим;
7. Процесс ажиллагаа саадгүй тасралтгүй явагдах зарчим;
8. Шүүн таслах ажиллагаа тодорхой, бодиттой явагдах зарчим;
9. Шүүх эрх мэдлийн харьцангуй оролцооны зарчим гэх мэт

Дээр дурдсан зарчмууд нь энэхүү тогтолцоон дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, агуулгыг тодорхойлох чухал үзэл баримтлал болж байна. Зарим зарчмыг тодруулбал: процессын чиг үүргийн хуваарилалтын зарчим нь мөрдөн шалгах ба яллах чиг үүргийг ялган зааглахаас гадна шүүхийн ба шүүхийн өмнө шатны процедурыг ялгамжтайгаар хуульчлан зохицуулах онцлогтой болохыг илэрхийлнэ. Түүнчлэн яллах чиг үүргийн давуу байдлын зарчим нь шүүхийн өмнөх шатанд төрийг төлөөлсөн субъект

(прокурор, цагдаа, мөрдөгч) нотлох баримтыг цуглуулах, шалгах, бэхжүүлэхэд илүү голлох оролцоо бүхий эрх мэдэлтэй байдгаар илэрнэ. Шүүх эрх мэдлийн харьцангуй оролцооны зарчим нь “... нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэхэд шүүх хязгаарлагдмал чиг үүрэгтэй оролцдог боловч түүнийг шалгах, үнэлэхэд давуу эрхтэй оролцож шаардлага бий болдогтой холбоотой.”⁹¹

Эрүүгийн хосолсон процесс буюу хосолсон систем нь орчин үед шинээр хөгжиж буй загвар, хандлага юм. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг загварын зарим хэлбэр, зарчим нэвтэрч байна.

Аливаа улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны суурь зарчим болон өөрийн орны эрх зүйн соёл, уламжлал, онцлогт суурилан бүрэлдэн тогтсон байдаг. Онолын хувьд дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь эрх зүйн бүл буюу аймгуудад хуваагдан хөгжиж ирсэн түүхтэй боловч даяаршиж буй өнөөгийн нийгэмд эрх зүйн аймгийн холимог шинжийг агуулсан хууль тогтоомжууд ихээр төрөн гарах боллоо.⁹²

Уг загвар нь мэтгэлцээний болон мэтгэлцээний бус хэлбэрийн аль алиныг хослуулсан зохистойгоор уялдуулан зохицуулахад чиглэгдсэн систем юм. Энэ чиглэлийг баримжаалах болсон орнуудад Япон, Филиппин, Өмнөд Солонгос болон Скандиновын зарим орнууд (Швед, Норвег) хамаарна.

Дээрх орнууд өмнө нь үндэсний уламжлалт болон эх газрын системд харьяалагдан, түүнийг баримжаалж байсан орнууд юм. Жишээ нь: Японы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн 289.1, 41 дүгээр зүйлд зааснаар өмгөөлөгч нь нотлох баримт цуглуулах эрхтэй ба хуулиар хориглоогүй бол мэтгэлцэх зарчмын дагуу нотлох ажиллагааг бие даан явуулж болохоор хуульчилсан,

⁹¹ Д.Баярсайхан, Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, чиг хандлага, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 7-9 дэх тал

⁹² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 1 дэх тал

түүнчлэн уг хуулийн 289.2 дугаар зүйлд зааснаас үзэхэд шүүгч нь өөрийн санаачилгаар шаардлагатай үед нотлох баримтыг шинжлэн шалгах эрхтэй байдаг.⁹³ Эндээс харахад мэтгэлцэгч талуудын тэгш байдлыг хангах, мэтгэлцэх процессыг шүүн таслах ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг бий болгосон гэж үзэх үндэстэй юм. Ингэснээрээ Япон Улс нь инквизицийн мөрдөн шалгах тогтолцоог шүүхийн өмнөх шатанд тухайн жишгээр нь хэрэгжүүлдэг боловч шүүхийн шатанд мэтгэлцэх зарчмын агуулгыг тусгасан аккусацийн систем илүү тод илэрсэн байдгийг дурдаж болно. Японд инквизици ба аккусацийн системийг хооронд нь сөрөгдүүлж, зөрчилдүүлэхгүйгээр аль алиных нь дутагдалтай талыг харилцан нөхөх байдлаар, зохистойгоор уялдуулж чадсан байна гэж доктор Д.Баярсайхан дүгнэсэнтэй санал нэгдэж байна.

2008 онд НҮБ-аас дэмжиж гаргасан дэлхийн улсуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны загвар хуулийн үзэл баримтлал, агуулга нь хэдийгээр дундын буюу хосолсон хэв маяг бүхий эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанарыг илэрхийлдэг ч инквизицийн процессын үнэт зүйлс, зарчмууд нь нэлээд тодорхой тусгагдсан нь судлаачдын анхаарлыг татсаар байна.⁹⁴

Европын холбооны зөвлөлөөс 1987 онд батлан гаргасан (R(87)18) “Эрүүгийн шүүхийн хялбаршуулсан журмын тухай зөвлөмж”-д заасны дагуу хэт нүсэр, чирэгдэл хүндрэл бүхий уламжлалт процесс ажиллагаанаас аль болох зайлсхийж, ил тодорхой нотлогдсон буюу гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн шийдвэрлэх боломж бүхий хэргүүдийг түргэвчилсэн журмаар хялбаршуулж, формал процессын аргаар шийддэг байх чиг хандлагыг цөөнгүй улс орон хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албадлага хэрэглэх ажиллагаанд хүний эрхийг хангах зарчим шаардлагыг илүү

⁹³ “JUS”. Оюутны шилдэг илтгэлийн эмхтгэл., УБ., 2012., 141-142-р тал

⁹⁴ Д.Баярсайхан, Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, чиг хандлага, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 11 дэх тал

тодорхой тусган хуульчлах болсон ба НҮБ-ын болон Европын Хүний эрхийн гэрээ, конвенцын заалт, зарчмуудыг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх нөхцөл, журмыг тогтоон хэрэгжүүлж байна. Эрүүгийн хэргийн шүүх процесс ажиллагааны эрх зүйн орчныг өөрчлөн шинэчлэх, мэтгэлцэх зарчмыг илүү нээлттэй сонгодог байдлаар нэвтрүүлэх, хавтаст хэргийг уншиж, мөрдөн байцаалтын үр дүнд хэт найдаж шүүх хуралд ордог уламжлалт хандлагаас зайлсхийж, “Charge statement and only” зарчмын дагуу шүүх хуралдааны процессыг илүү шударга, бодитой, зохистой, оновчтой хэрэгжүүлэх арга, механизмыг эрэлхийлж байна.⁹⁵

4.1. ГЕРМАН УЛС

Герман улс нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бичмэл хуулийн бүтэц, хэлбэрийг бий болгох, хэргийн бодит үнэнийг тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, харьяаллын үндсийг тодорхойлоход анхдагч түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Германы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эх газрын уламжлалт хэв шинжийг хадгалж, эрх зүйн төрийг хамгаалах, хуульд үндэслэгдэх зарчмыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг.⁹⁶

ХБНГУ-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэж журам нь 8 бүлэг, 495 эрх зүйн зохицуулалтаас бүрддэг. Эрүүгийн гэмт хэргийг онцгой ба энгийн журмаар хянан шийдвэрлэдэг. Эрүүгийн гэмт хэргийг онцгой журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх, гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх, хувь хүн бие дааж шүүхэд яллах бичиг өргөх, хохирогч эрүүгийн

⁹⁵ Д.Баярсайхан, Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, чиг хандлага, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь, онол, практикийн хэлэлцүүлэг, итгэлийн эмхтгэл, УБ., 2019 он, 11-12 дахь тал

⁹⁶ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 41 дэх тал

гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд оролцох гэсэн онцгой хэлбэрүүд багтдаг.⁹⁷

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийн халдашгүй байх шаардлагатай уялдаж Үндсэн хуулийн суурь зарчимд нийцсэн байхаас гадна эрүүгийн хэргийг мөрдөн шалгах хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг тусгасан тусгайлан зарчмуудтай⁹⁸ байдаг. Энэ зарчмууд нь Германы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанарыг бүрэн илэрхийлэхийн зэрэгцээ тухайн процессын эрх зүйн гол үзэл баримтлал болж төлөвшсөн байдаг гэж доктор Д.Баярсайхан дүгнэсэн байна.

Эдгээр зарчмуудаас “Хэргийг шүүх шийдвэрлэхээс өмнө хэргийн нотлох баримтыг шүүх урьдчилан шалгаж, үнэлэх зарчим”, “Нотлох баримтыг хуваарилан үнэлэх зарчим”⁹⁹ анхаарал татаж байна. Мөн Германы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь таван үе шатаас бүрдэх бөгөөд түүний нэг гол үе шат бол “Шүүхээс нотлох баримтыг урьдчилан үнэлэн шалгах үе шат”¹⁰⁰ (*Хэргийг шүүхэд хэлэлцэх эсэхийг хянан шалгах процесс*) юм. Герман Улсын хувьд яллах дүгнэлт шүүхэд ирснээс хойших шүүх хуралдаан хүртэл завсрын үе шат болон шүүхийн үе шат гэсэн төрөлтэй. Завсрын үе шатанд сэжигтэнд яллах тухай бичгийг хүргүүлдэг ба үүндээ эд мөрийн баримт, тус хэргийг шүүх харьяаллын шүүх сэжигтний өмгөөлөгч болоод мөрдөн байцаалтын явцад илэрсэн үр дүнг танилцуулна. Энэ үе шатанд тухайн шүүх тус хэргийг хянан шийдвэрлэх харьяаллын шүүх мөн эсэхийг тогтоож, шүүх хурлыг нээх, эсхүл татгалзах талаар урьдчилан шийддэг.

Прокурорын газар шүүхэд шүүх хуралдаан эхлүүлэхээс татгалзсан албан бичиг хүргүүлсэн байсан ч завсрын ажиллагааны шалгалтын явцад шүүх хуралдаан эхлүүлэх тухай шийдвэр гарч

⁹⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 22 дахь тал

⁹⁸ Michael Bohlander The principles of German criminal procedure. Н., 2011. р.108

⁹⁹ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 44 дэх тал

¹⁰⁰ Мөн тэнд

болно. Энэ нь завсрын ажиллагааны шийдвэр Прокурорын газраас ирүүлсэн ялын бичигтэй заавал нийцэх албагүй гэсэн үг бөгөөд хурдавчилсан ажиллагаа шаардлагатай үед завсрын ажиллагааг явуулах хэрэггүй байдаг.¹⁰¹

Германы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотолгооны онолд нотлох баримтыг цуглуулах үнэлэх болон бэхжүүлэх аргыг зохистой харьцааны болон бодит үнэний зарчмаар тайлбарласан байдаг. Хэдийгээр мөрдөн байцаалтын үр дүнд бэхжүүлж цуглуулсан баримт сэлтүүд шүүх дээр нотлох баримт болгон үнэлэгдэх процесс шууд явагддаг боловч гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлтийг давхар шалгах, процедурын үр дагавар бүхий байцаалтыг зөвхөн шүүхийн хяналт, оролцоотой явуулах, яллагч өмгөөлөгч талуудын ашиг сонирхлыг тэнцвэртэй зохицуулах талаар нарийвчилсан журмыг хэрэгжүүлдэг байна.¹⁰²

4.2. ФРАНЦ УЛС

Франц нь эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны анхны төрөлжсөн хуулийг бүтээгч, эх газрын системийг үүсгэн хөгжүүлсэн орны хувьд гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны арвин баялаг уламжлалтай орон билээ. Тэр тусмаа шүүхийн өмнөх шатан дахь мөрдөн шалгах болон мөрдөн байцаалтын харьяалал, үе шатыг процессын болон мөрдөн байцаалтын харьяалал, үе шатыг процессын нарийвчилсан нөхцөлүүдээр зохицуулах, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааг шүүхийн хяналт, эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх, ЭБША-нд процессын хэлбэрүүдийг бий болгох талаар анхны жишиг журмуудыг нэвтрүүлж хэвшүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн оршлын 1-р зүйл: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

¹⁰¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 43 дахь тал

¹⁰² Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 55 дахь тал

нь уг ажиллагаанд оролцогчдын эрхийг тэнцвэртэйгээр хангаж, шударга, зохистой байдлыг хамгаалахад чиглэгдсэн байна.” Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л ажиллагаа хүнлэг ёс, шударга ёс, хуулийг гуйвалтгүй биелүүлэх шаардлагад нийцсэн байхаас гадна чирэгдэлгүй, дарамт шахалт болон эрүү шүүлтээс ангид байхаар хуульчлагдсан байна.¹⁰³

Прокурор нь мөрдөн мөшгих ажиллагааг эхлүүлж, шүүхэд яллах талыг төлөөлж оролцох, мөрдөн байцаалтын шүүгчийн зөвшөөрөл, хяналтын дор мөрдөн шалгах тодорхой ажиллагааг удирдан чиглүүлж, зохион байгуулах, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх чиг үүрэгтэй байна.

Францын ЭБША-ны бас нэг онцлог нь нотлох баримтыг цуглуулж, шалгах чиг үүргийн ялгаанаас хамаарч шуурхай илрүүлэх, хялбаршуулж шийдвэрлэхээс гадна мөрдөн мөшгих болон мөрдөн шалгах ажиллагааг цагдаагийн мөрдөгч, прокурор, мөрдөн байцаалтын шүүгч зэрэг субъект өөр өөрийн онцлог, зарчмаар хэрэгжүүлдэг. Мөрдөн байцаалтын шүүгч нь шүүх эрх мэдлийн субъект мөн боловч шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны үе шатанд бие даасан байр сууринд, эрүүгийн хэргийн нотлох ажиллагаа хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй субъект юм.

Энэ субъект нь эрүүгийн хэргийг шүүн таслах, ял оногдуулах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлдэггүй. Мөрдөн байцаалтын шүүгч нь эрүүгийн хэргийн нөхцөл байдлын талаарх яллах, цагаатгах бүхий л баримтыг шалган цуглуулж нотлох ажиллагаанд бие даан оролцоно. Процессын шүүхийн бүрэлдэхүүнд багтаж, тухайн харьяалах шүүхээс 3 жилийн хугацаагаар сонгогдон томилогддог мөрдөн байцаалтын шүүгч прокурорын чиг үүргээс ангид үйл ажиллагаа явуулж, цагдаагийн гүйцэтгэх, эрэн сурвалжлах болон мөрдөн мөшгих, баривчлах, цагдан хорих болон нэгжлэг, таньж оруулах болон мэдүүлэг гаргуулах ажиллагаанд хяналт тавина.

Мөрдөн шалгах ажиллагааны бүхий л үйл явцад шүүхийн хяналт, оролцоо маш хүчтэй, өргөн хүрээнд хэрэгждэг, Францын

¹⁰³ Мөн тэнд, УБ., 2015 он, 55, 61 дахь тал

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг харьцангуйгаар шатлан үнэлэх зарчим үйлчилдэг бөгөөд шүүх хуралдаан дээр шүүхийн тогтоолд тусгагдсанаар нотлох баримтыг эцэслэн үнэлж, гэмт хэрэг хийсэн гэм буруутай нь тогтоогдсон гэж үзнэ.¹⁰⁴

4.3. АНУ

Америкийн Нэгдсэн Улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцооны аккусацийн загварыг бий болгох, түүнийг хөгжүүлэн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Ялангуяа эрүүгийн хэргийг олон шат дамжлагагүй, түргэн шуурхай шийдвэрлэх, ялын олон сонголттой нөхцөлийг бий болгон хялбаршуулж шийдвэрлэх талаар нэлээд туршлага хуримтлуулсан орон гэж үздэг. Түүнчлэн эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчмыг бий болгох, төлөвшүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан билээ.¹⁰⁵

Америкийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн шалгуур бүхий дор дурдсан агуулгыг шүүн таслах ажиллагаанд заавал хангах нөхцөл болгон тогтоосон байдаг. Үүнд:

1. Нэгэнт ил тодорхой болсон буюу хохирол нь төлөгдөж, ял тохиролцох боломжтой хэргүүдийг түргэвчилсэн журмаар шийдвэрлэх;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн урьдчилсан болон шүүн таслах хуралдааны агуулгаар тодорхойлогдох бөгөөд шууд бус утгаараа шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны үе шатыг үгүйсгэх;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах;
4. Шүүх хуралдааныг чөлөөтэй мэтгэлцэх аргаар явуулах;

¹⁰⁴ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 59, 63-64, 65, 70 дахь тал

¹⁰⁵ С.Франковски, Р. Гольдман, Э.Лентовска Верховный суд США: Гражданских правах и свободах М., 1999 с.84

5. Нотолгооны агуулгыг шүүх дээр мэтгэлцэгч талууд тодорхойлох;
6. Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн харилцаанд оролцогч бүхэн үүрэг, хариуцлагаа өөрсдөө бие даан хүлээх;
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны институт, тогтолцоо, систем нь төвлөрсөн бус, задран хуваарилагдаж, тус тусдаа боловч функциональ түвшинд чиг үүрэг нь хоорондоо харилцан уялдсан байх;
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц, чиг үүрэг бүхэнд нотолгооны стандарт аргачлал, зарчмуудтайн дээр албадан гүйцэтгэх, баривчлах ажиллагаанд хүний хувийн эрх чөлөө, халдашгүй чөлөөт байдлыг байнга анхаарч харгалзах;
9. Эрүүгийн хэргийн нотлох ажиллагаанд нээлттэй буюу урьдчилсан хэлэлцүүлгийн аргаар зохистой, уян хатан шударга ёсны зарчимд нийцсэн харьцангуй үнэлгээний шаардлагыг хангах г.м¹⁰⁶

Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудын ЭБША-ны үндсэн зарчмууд:

- Гэм буруугийн зарчим буюу бүхий л эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэмт хэргийг сэжигтнийг гэм буруугүй гэж таамаглах таамаглалаас эхэлдэг;
- Эрх зүйн зайлшгүй процесс (Due process), гэм буруугүйн дээрх зарчимтай холбоотойгоор яригддаг. Гэмт хэргийн үйл явдлыг шинжлэхдээ тухайн сэжиглэгдэж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг хамгаалах явдлыг чухалчилдаг.¹⁰⁷

¹⁰⁶ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 74 дэх тал

¹⁰⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 40 дахь тал

4.4. АНГЛИ УЛС

Англи нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь аккусацийн системийг бүрдүүлж, хөгжүүлэхэд анхдагчийн түүхэн үүрэг гүйцэтгэсэн.¹⁰⁸ Нотолгооны эрх зүйн эх сурвалжид нотлох баримтын хууль, нотолгооны стандарт, журмуудаас гадна тухайн хэргийн нөхцөл байдлаас үүдэлтэй нотлох процессын хамаарал, холбогдол, шалтгаант фактын талаарх прецедентийн жишиг, зарчмууд багтдаг. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээлэл, баримт сэлтүүд нь зөвхөн шалгаж, цуглуулснаар нотлох баримт болохгүй.

Энэ нь эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бүхий зарчим, стандарт, шалгуурыг хангаж байж, нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ гэсэн үг юм. Английн нотлох баримтын хууль, стандарт, журмуудад заасны дагуу эрүүгийн хэргийн нотолгоонд дараах суурь зарчмуудыг (Foundational principles) заавал удирдлага болгодог байна.

- Суурь зарчим 1. Гэм буруугүйд тооцогдох эрхийг харгалзах зарчим
- Суурь зарчим 2. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө гэм буруутай гэж үзэхгүй байх онцгой эрхийг хүндэтгэх зарчим
- Суурь зарчим 3. Нотолгооны боломжит, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг ажиглалт, туршилтаар хангах зарчим (Admissibility of evidence)
- Суурь зарчим 4. Нотолгооны боломжит, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хуурамч мэдээлэл, баримт сэлтийг илрүүлэх замаар хангах зарчим
- Суурь зарчим 5. Нотолгооны боломжит, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг няцаалтыг үгүйсгэх, шалган батлах замаар хангах зарчим

¹⁰⁸P.Уолкер Английская судебная система М., 1980 с 123-125

* “Нотолгооны боломжит, хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэдэг нь Монгол Улсын ЭБШ эрх зүй дэх Нотлох баримтын болохуйц байдлаас огт өөр утгатай ойлголт (Д.Б)

Суурь зарчим 6. Гэрчийг шалган тогтоох, гэрчийн мэдүүлгийг шүүхийн хяналт, зөвшөөрлөөр гаргуулах зарчим (The right to examine witnesses)

Суурь зарчим 7. Нотлох баримтыг шүүхээс үе шаттайгаар үнэлэх зарчим гэх мэт. (магистрат, тангарагтны, мэргэжлийн шүүх)¹⁰⁹

Дээр дурдсан зарчмуудаас гадна нотолгооны үнэлгээг хангах, логикийн арга, нөхцөлүүдийг жишиг болгон тогтоосон нь бий. Тухайлбал: нотолгоог түдгэлзүүлж, тохиролцсоноор тооцох зарчим, нөхцөл байдал буюу бодит фактад тулгуурлах зарчим, чөлөөт мэтгэлцээний үр дүнг харгалзах зарчим г.м. Эдгээр нь шүүгчийн мэргэжлийн итгэл үнэмшил, ухамсар зан үйлийн зарчмуудад тусгагдаж хэвшсэн байдаг.¹¹⁰ Өөрөөр хэлбэл нотлох баримтыг зөвхөн цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааны хэргийн баримт, материалаар хязгаарлан үнэлэхгүй гэсэн үг юм.¹¹¹

Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь мэтгэлцэх зарчим дээр суурилдаг ба өөрөөр хэлбэл, талууд шүүхийн хэлэлцүүлгийн агуулгыг өөрсдөө тодорхойлдог мөн өмгөөлөх ба яллах талууд шүүхэд мэдүүлэх нотлох баримтаа өөрсдөө мэдэж шийддэг буюу гаргадаг байна.¹¹²

4.5. ОХУ

Оросын Холбооны Улс нь хэдийгээр Баруун Европын кодификацичлалын уламжлалыг Франц, Германаас өвлөн авч, эх газрын системийн хэв шинжийг тусган хөгжүүлж байсан боловч 70 шахам жил социалист эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоо бүрэлдэн тогтож, үзэл онолын хувьд түүнийг

¹⁰⁹ Д.Баярсайхан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй. УБ., 2014 он, 96 дэх тал

¹¹⁰ Doak J and McGourlay. Criminal Evidence in Context. L.M., 2012 p 98-99

¹¹¹ Б.Амарсанаа Харьцуулсан эрх зүйн судлал, УБ., 2014, 153 дахь тал

¹¹² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 1 дэх тал

бүхэлд нь тодорхойлж ирсэн юм.¹¹³

Дэлхийн хоёрдугаар дайны өмнө болон дараах үед (1938-1948 оны үед) А.Я.Вышинскийн нотолгооны догматик онолд үндэслэгдсэн эрүү шүүлт хэрэглэх замаар байцаалтаар хэрэг хүлээлгэх тогтолцоо Оросын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уламжлалт агуулгыг алдагдуулахад хүргэсэн төдийгүй түүний үр дагавар социалист системийн бусад орнуудад ч сөргөөр нөлөөлсөн байдаг.¹¹⁴ 1990-ээд оноос хүний эрх, хууль дээдлэх ёс, ардчиллыг эрхэм зорилгоо болгосон зах зээлийн нийгэмд шилжин орж, ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталснаар (1993.12.12) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарсан билээ.

Оросын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь кодификацчилал болон эрх зүйн эх сурвалж талаас нь авч үзвэл эх газрын системийн хүрээнд хамаарагддаг боловч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим, субъектийн болон чиг үүргийн хуваарилалт, агуулга, мөн чанарын хувьд Франц, Герман, Итали, Испани зэрэг Европын орнуудын нийтлэг загвараас илт ялгагддаг.¹¹⁵

Хамгийн гол нь прокурорын хяналтын онцгой чиг үүргээс гадна шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгах ажиллагааны процедур, шүүх хуралдааны үйл явц, баривчлах, цагдан хорих хугацаа болон албадлагын арга хэмжээг авах процедур зэргээрээ зарчмын ялгаатай гэж үзэж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд тусгагдсан эрүүгийн шүүн таслах ажиллагааны зарчмуудыг тухайлан тодруулж авч үзье.

1. Шүүх мөрдөх байгууллага биш бөгөөд яллах эсвэл, өмгөөлөх талд орохгүй. Шүүх нь ЭВША-нд оролцогчдын эдлэх эрх, гүйцэтгэх үүрэг тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангана. (ЭПХ-ийн 15.3-р зүйл);
2. Эрүүгийн шүүн таслах ажиллагаа талуудын мэтгэлцээний

¹¹³ Willam Burnham. Law and the legal system of the Russian Federation., 2004

¹¹⁴ Д.Баярсайхан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй. УБ., 2014 он, 58-59 дэх тал

¹¹⁵ Stephen C. Thaman, Comparative criminal procedure C.A ., 2002. p 91

- үндсэн дээр явагдана.(ЭПХ-ийн 15.1-р зүйл) “Яллах өмгөөлөх талууд шүүхийн өмнө тэгш эрхтэй. (ЭПХ-ийн 15.4-р зүйл);
3. Сэжигтэн, яллагдагч өөрийгөө өмгөөлөх болон хууль ёсны төлөөлөгчийн тусламжтайгаар өмгөөлүүлэх эрхээр хангагдах ёстой. (ЭПХ-ийн 16.1-р зүйл);
 4. Ямар ч нотлох баримтыг шүүхээс өмнө урьдчилсан байдлаар үнэлэхгүй. (ЭПХ-ийн 17.1-р зүйл).¹¹⁶

Прокурор нь процессын хяналтын болон яллах чиг үүргийн хүрээнд дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ. (ЭПХ-ийн 37-р зүйл)
Үүнд:

- Гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, мэдээллийг хэрхэн хүлээж авч хянан шийдвэрлэж байгаад хяналт тавих;
- Эрүүгийн хэрэг үүсгэх болон татгалзах тогтоолын хуульд нийцсэн болон үндэслэлтэй эсэхийг хянаж, хүчингүй болгох буюу батлах;
- Хэрэг бүртгэлийн ажиллагаанд үүрэг чиглэл өгөх;
- Мөрдөн байцаалтын явцад баривчлах, цагдан хорих болон нэгжлэг хийх, хураан авах ажиллагаанд хяналт тавих, шүүхэд шийдвэрлүүлэхээр зөвшөөрөл олгох;
- Яллах актыг баталж, эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх;
- Шүүхийн өмнөх шатанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажиллагаанд холбогдох гомдол, процессын маргаан хүний эрхийн асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хэлэлцэхэд оролцох;
- Хэрэг бүртгэлийн хугацааг сунгах;
- Эрүүгийн шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох гэх мэт¹¹⁷

Өмгөөлөгч нь (ЭПХ-ийн 49-53-р зүйл) сэжигтэн, яллагдагчийг баривчлагдсан болон сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрхийг нь хамгаалж өмгөөлөгчөөр оролцох бөгөөд насанд хүрээгүй этгээд, хэл, сонсгол, ярианы бэрхшээлтэй тахир дутуу иргэд түүнчлэн 15 жилээс

¹¹⁶ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 112 дахь тал

¹¹⁷ Мөн тэнд, 106 дахь тал

дээш хорих ял бүхий зэрэг зарим онцлог этгээдийн хэрэгт заавал өмгөөлөл явуулна. (ЭПХ-ийн 51-р зүйл)

Өмгөөлөгч нь сэжигтнийг баривчлах, нэгжлэг хийх, байцаах болон хойшлуулшгүй ажиллагаа явуулах зэрэг процесс ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, цагаатгах болон хамааралт нотлох баримтыг цуглуулах, шүүх хуралдаанд өмгөөлөх талыг төлөөлж оролцох эрхээр хангагдсан байна. Сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, шинжээч зэрэг оролцогчдын эрхийг ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд ерөнхий ангид тодорхой хуульчилсан нь тэдний эрх ашгийг хамгаалах чухал хүчин зүйл болдог.¹¹⁸

Оросын эрдэмтэн, профессор А.Э.Жалинскийн цохон тэмдэглэснээр ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль нь өмнөх хуулиудтай харьцуулахад дараах шинэлэг өөрчлөлтийг тусгаснаараа онцлогтой. Үүнд:

1. Ардын төлөөлөгчөөс татгалзаж, тангарагтны шүүх, эвлэрлийн шүүгчийг шинээр бий болгосон;
2. Хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн олон заалтууд нэмэгдсэний дотор өмгөөлөгчийн нотлох ажиллагаанд оролцох эрхийг өргөтгөсөн;
3. Албадлагын арга хэмжээг хэрэглэх журмыг шинэчилсэн, жишээ нь цагдан хорих арга хэмжээг хэрэглэх хүрээг хумьж, багасгасан;
4. Байцаан шийтгэх ажиллагааны явцад гарч буй шийдвэрүүдэд гомдол гаргах боломж нэмэгдсэн ба шүүхийн хяналтын чиг үүргийг өргөтгөсөн;
5. Хуучин зохицуулагдаж байсан байдлаар нэмэлт мөрдөн байцаалтад буцаах явдлыг үндсэнд нь устгасан;
6. Яллагдагч сонсгосон ялыг зөвшөөрсөн тохиолдолд шүүхээс хэргийг шууд шийдвэрлэх онцгой журмыг бий болгосон.¹¹⁹

¹¹⁸ Мөн тэнд 107-108 дахь тал

¹¹⁹ Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шинжлэх ухааны тайлбар, Ханнс Зайделийн сан, УБ., 2003 он, 98 дахь тал

ОХУ болон Монгол Улс нь социалист эрх зүйн системд 70 гаруй жил оршиж, улмаар ардчилсан нийгэмд шилжсэн хэдий ч хуучин тогтолцооны үр дагавар бүрэн арилж чадаагүй тал ажиглагдаж байна.

Социалист эрх зүй нь ямар онцлогтой байв?

1. Социалист эрх зүй нь урт удаан хугацааны туршид ажилчин, тариачин, хөдөлмөрчдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн ангич шинжтэй байв.
2. Эрх зүй нь төрийн эрх мэдлийн зэвсэг гэж тооцогдож байв.
3. Эрх зүй нь төрийн ашиг сонирхлыг, төрийн өмчийн давуу байдлыг хамгаалж байв.
4. Хүний эрхийг анхдагч, давуу гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй байв.
5. Эрх зүйн системд хууль гол байр суурь эзэлдэггүй, харин нам, захиргааны шийдвэр чухалчилдаг байв.
6. Иргэд, хуулийн этгээдийн эрхийг шүүхээр хамгаалуулах боломж хангалтгүй байв.¹²⁰

4.6. БНСУ

Өмгөөлөгч гэдэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь сэжигтэн, яллагдагчийн өөрийгөө хамгаалах эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй нэг төрлийн туслагч¹²¹ тул өмгөөлөгчийн оролцоо нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын эрх тэгш үйлчлэхийн бодит баталгаа, хүний эрхийг хамгаалахад томоохон ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл өмгөөлөгчийн оролцоо, өмгөөлөгчөөс авах туслалцаатай холбоотойгоор тогтолцоо хэрхэн сайн хэрэгжиж байгаа, бодит байдалд тулгуурлаж

¹²⁰ Ж.Амарсанаа, Посткоммунист орнууд дахь эрх зүйн тогтолцооны төлөвшил, хандлага илтгэл, Посткоммунист орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба Монголын эрх зүйн тогтолцооны төлөвшил, онцлог (Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл), УБ., 2015 он, 8 дахь тал

¹²¹ 친진호 (Jin Ho Chun). "제4회 중.한 형사소송법 학술대회 : 형사절차에서 변호인의 역할 제고 방안." 법학논총 28.4 (2011): 366

байгаагаар тухайн улс орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хөгжлийг тодорхойлох боломжтой.

БНСУ-ын Үндсэн хуулийн 12-р зүйлийн 12.4-т “Хэн ч бай баривчлагдсан эсхүл цагдан хоригдсон тохиолдолд өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй” гэж өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхийг тодорхой тусгасан бөгөөд ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчийн эрхээс ангид бие даан өмгөөлөгчийн эрхийг 34-р зүйлд “Өмгөөлөгч эсхүл өмгөөлөгч болох гэж буй хүн нь баривчлагдсан сэжигтэн, яллагдагчтай уулзаж бичиг баримт эсхүл эд зүйлийг харилцан солилцож болох бөгөөд эмчийн туслалцаа авхуулах эрхтэй” гэж зохицуулж сэжигтэн болон яллагдагчтай уулзалт хийх эрхийг тодорхойлсон байна.

1954 онд Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид БНСУ гэх)-ын Үндэсний Ассамблей тус улсын анхны орчин үеийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (цаашид ЭХХШТХ гэх)-ийг баталсан нь хүчин төгөлдөр үйлчилж байна. Ингэхдээ хуульд 1961, 1963, 1973, 1980, 1987, 1994, 1995, 1997, 2002, 2004, 2005, 2006, 2007, 2009, 2011, 2012, 2013, 2014 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон байна.¹²²

Сүүлийн жилүүдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэтгэлийг эрчимтэй хийж байгаагийн дээр аккусацийн болон инквизицийн тогтолцооны аль алиных нь үнэт зүйлсийг Солонгосын онцлогт зохистойгоор тохируулж, төлөвшүүлснээрээ нэлээд туршлага хуримтлуулсныг нь хүлээн зөвшөөрөх ёстой. Өмгөөлөгч нь сэжигтнийг баривчлагдсан болон цагдаад дуудагдсан үеэс оролцох эрхтэй бөгөөд байцаалтад байлцах, шүүхэд шилжихээс өмнө байцаалт, нэгжлэг, үзлэгийн тэмдэглэл, шинжилгээний дүгнэлттэй танилцах боломжтойгоос гадна өөрийн цуглуулсан баримт сэлтийг шалгуулж үнэлүүлэх талаар шүүхэд хүсэлт гаргах, шүүх хуралдаанд мэтгэлцээний нэг болж оролцох зэрэг эрхээр хангагдсан байна. Сэжигтэн, яллагдагч болон түүний өмгөөлөгч гэрчээс нэмэлт мэдээлэл шаардах, нэмж гаргуулах баримт

¹²² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 2 дахь тал

сэлтийн талаар прокурорт шаардлага, хүсэлт тавьж болох ба прокурор тэдгээрийг хүлээн авч шалгах үүрэгтэй.¹²³

2007 онд шинээр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар Америкийн системийн мэтгэлцэх зарчмыг зохистой хэмжээнд хязгаарлан тогтоож, мөрдөн шалгах тогтолцооны суурь зарчим, чиг үүргийг нэмж тусгах замаар ЭБША-ны журмыг бүхэлд нь шинэчлэн тогтоожээ. 2007 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэ хуульд дараах томоохон суурь өөрчлөлтүүд оруулжээ. Үүнд:

1. Цагдан хорих тогтолцоог хүний эрхийн шаардлагад нийцүүлж, стандарттай болгон шинэчилсэн,
2. Нотлох баримтыг оролцогчид зөвхөн шүүх дээр үнэлүүлэх шинэ дэг журам тогтоосон,
3. Өмгөөлөгчийн эрхийг өргөжүүлж, түүний баталгааг хангасан,
4. Мөрдөн шалгах хойшлуулагшгүй ажиллагааг видео бичлэгт бэхжүүлэх журам баталсан,
5. Нотолгооны бүх үйл явцыг стандарт, журамтай болгосон,
6. Гэрч, хохирогчийг хамгаалах шинэ журам баталсан,
7. Прокурорын шийдвэрт гомдол гаргах нөхцөл, журмыг шинээр хуульчилсан,
8. Шүүх хуралдааны тэмдэглэлийг ил тод болсон.¹²⁴

Энэхүү судалгаанд БНСУ-ын эрүүгийн процессын давуу талууд, шинэтгэлийг гүнзгийрүүлэн авч үзсэн бөгөөд судлаачдын хувьд МУ-ын эрүүгийн процесст авч хэрэгжүүлэх боломжтой зохицуулалтууд байгааг онцолж байна.

БНСУ-ын Дээд шүүх нотлох ажиллагаанд баримтлах дараах хоёр үндсэн зарчмыг удирдамж болгон тогтоосон байдаг. Үүнд:

1. Нотлох баримтын нотолгооны хүчин чадлыг чөлөөтэй шинжиж үнэлэх;
2. Эргэлзээ гарвал яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим орно.

¹²³ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 136 дахь тал

¹²⁴ Мөн тэнд, 128 дахь тал

Сүүлийн зарчмын хувьд мөрдөн шалгах болон хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед нотлох ажиллагаа хангалттай хийгдсэн боловч шүүгдэгчийн гэм бурууг тогтооход эргэлзээ гарвал түүнийг гэм буруутайд тооцохгүй гэсэн дүгнэлтэд хүрнэ гэсэн үг юм. Харин эхний зарчим нь нотлох баримтыг хуульд зөвшөөрсөн ямар нэг аргаар олж авсан, энэ нь тухайн гэмт хэрэгт ямар холбогдлоор хамааралтай болохыг мэтгэлцээний талууд чөлөөтэй хэлэлцэж, харилцан маргах замаар шүүхээр үнэлүүлэхэд чиглэгдсэн зарчим юм.¹²⁵

ЭХХША дахь өмгөөлөгчийн оролцоотой холбоотойгоор өмгөөлөгчийн уулзалт хийх эрх, хэргийн материалтай танилцах болон хуулбарлах эрх, сэжигтнээс мэдүүлэг авахад оролцох эрх зэрэг өмгөөлөгчийн эрхүүдийг БНСУ-ын хуульд хэрхэн зохицуулсан, Улсын Дээд шүүх болон Үндсэн хуулийн шүүхээс хэрхэн тайлбарлаж байгаа болон өмгөөлөгч нь ЭХХША-нд ямар үүрэг, оролцоотой оролцож буй талаар авч үзье.

4.6.1 БНСУ-ын ЭХХШТХ-ийн 2007 оны шинэчилсэн найруулга

2007 оноос өмнөх ЭХХШТХ-ийн хувьд өмгөөлөгчдийн оролцоо, сэжигтэн болон яллагдагчийн эрхийг хамгаалах тал дээр дутагдалтай зүйл байсан. Харин 2007 онд ЭХХШТХ-ийг шинээр батлах замаар Америкийн системийн мэтгэлцэх зарчмыг зохистой хэмжээнд хязгаарлан тогтоож, мөрдөн шалгах тогтолцооны суурь зарчим, чиг үүргийг нэмж тусгах замаар мөрдөн шалгах ажиллагааны журмыг бүхэлд нь шинэчлэн тогтоожээ. 2007 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэ хуульд дараах томоохон суурь өөрчлөлтүүдийг оруулжээ. Үүнд:

1. Өмнө нь шүүгч баривчлах зөвшөөрөл олгохдоо сэжигтнээс байцаалт хийлгүүлэх хүсэлт ирүүлээгүй бол түүнийг байцаахгүйгээр зөвхөн бичиг баримтад үндэслэн зөвшөөрөл олгодог байсан бол 2007 оны шинэ хуулиар шүүгч баривчлах зөвшөөрөл олгохдоо сэжигтнээр байцаах болгосон.

¹²⁵ Мөн тэнд 133 дахь тал

2. Сэжигтэн байцаалт өгөх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцох эрхийг тодорхой тусгаж, мөрдөгч нь өмгөөлөгчийг оролцуулсан эсэх, хэрвээ оролцуулаагүй бол үндэслэлээ тэмдэглэлд тусгах болсон.
3. Сэжигтнийг байцаахад дүрс, дууны бичлэгт бэхжүүлэх, байцаалт эхэлснээс дуусах хүртэлх бүх үеийн бичлэг хийнэ. Бичлэг хийж дууссан бол өмгөөлөгч, сэжигтний өмнө түүний эх хувийг хадгалж сэжигтнээр гарын үсэг зуруулах, өмгөөлөгчийн хүсэлтээр бичлэгийг үзүүлэхээр шинээр зохицуулсан.
4. Прокурорын суудал болон яллагдагч, өмгөөлөгчийн суудал тэгш байх бөгөөд зүүн, баруун талд суудаг болгосон. Хуучин шүүх хурал явуулахад яллагдагчийг өмгөөлөгчийн хажууд суулгадаггүй байсан учраас шүүх хуралдааны явцад яаралтай асуудлаар өмгөөлөгч болон яллагдагч хоорондоо ярилцах боломжгүй байсан тул яллагдагчийн өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхийг бодитоор хэрэгжүүлэхийн тул суудлын байрлалыг өөрчилсөн.
5. Нотлох баримтын стандарт, нотолгооны процессыг өөрчилсөн. Нотлох баримт судлах үе шатыг сайжруулж шүүгч нотлох баримт судлах ажиллагаа дуусахаас өмнө яллагдагчаас асуулт тавих нь үндэслэлтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд прокурор болон өмгөөлөгч нотлох баримт судлах ажиллагаа дууссаны дараа яллагдагчаас асуулт асуух боломжтой болгосон. БНСУ-ын Дээд шүүх нотлох ажиллагаанд баримтлах дараах хоёр үндсэн зарчмыг удирдамж болгон тогтоосон байдаг.

Гэмт хэргийг мөрдөн шалгах зайлшгүй хэрэгцээг үндэслэн гаргасан прокурорын хүсэлтээр олгосон эсхүл шүүхийн цагдаагийн ажилтан прокурорт хүсэлт гаргасныг прокурор шүүхэд уламжилсны үндсэн дээр олгосон шүүхийн зөвшөөрлийн дагуу нотлох баримтыг хайх, шалгах, олж авах ажиллагааг прокурор болон шүүхийн цагдаагийн ажилтан хариуцна.

Эндээс харахад мөрдөн байцаах эрх бүхий этгээд болох шүүхийн цагдаагийн ажилтан нь шүүхэд өөрөө шууд хүсэлт гаргах эрхгүй бөгөөд түүний хүсэлт зайлшгүй прокуророор дамжиж байж шүүхээс зөвшөөрөл авах эсэх нь шийдэгддэг.¹²⁶

6. Шүүхийн урьдчилсан сонгол, хэлэлцүүлэг буюу шүүх хуралдааны бэлтгэх хийх ажиллагааг бий болгосон. Энэ нь Шүүхийн үр дүнтэй болон төвлөрсөн ажиллагааг явуулах зорилгоор харьяалал бүхий шүүхийн санаачилгаар прокурор, сэжигтэн эсхүл өмгөөлөгчийн хүсэлтэд үндэслэн шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн гол агуулга болон нотлох баримтыг хянах ажиллагааг хэлж байгаа юм. Энэхүү шинэчлэл нь шүүхэд бүх ажиллагааг төвлөрүүлэхийн тул урьд нь бичмэл нотлох баримтад үндэслэн шийдвэрлэдэг байсныг мэтгэлцээний зарчим болгон өөрчилсөнтэй холбоотой.

Солонгосын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн шалгуур бүхий зүй ёсны шударга процессын (Due process of Law) зарчмыг тухайн ажиллагааны бүхий л үйл явцад тууштай хангахад чиглэгдсэн эрх зүйн орчныг бий болгоход нэлээд анхаарчээ. Гэмт хэргийг мөрдөн шалгах арга, ажиллагааны нөхцөл, хэлбэрүүдийг нарийвчлан хуульчилж, албадлагын болон хүний эрхийг хязгаарлахад чиглэгдсэн ажиллагаанд шүүхийн хяналт, зөвшөөрлийн системийг нэвтрүүлснээс гадна тухайн этгээдийг сэжигтэн, яллагдагчаар татсан тохиолдолд гэр бүлийн гишүүдийг холбогдуулж шалгахгүй байх, ялыг халдаан хэрэглэхгүй байх зэрэгт анхаарч, зохицуулсан байдаг.¹²⁷

¹²⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 7 дахь тал

¹²⁷ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 134 дэх тал

4.6.2. Эрүүгийн хэргийн шүүхийн урьдчилсан сонголт, хэлэлцүүлэг

Шүүхийн бэлтгэл хуралдаан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөө, нарийн нягт байдлыг нэмэгдүүлэх, шүүгч тухайн хэрэг, нотлох баримтын талаар шүүх хуралдаанаас өмнө илүү сайн мэдээлэлтэй болох ач холбогдолтой юм. Энэ процессын үеэр прокурор, шүүгдэгч, шүүгдэгчийн өмгөөлөгч нотлох баримтыг цуглуулах, урьдчилсан дэс дараалалд оруулж бэлтгэх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан (шүүх хуралдаан) тасралтгүй явагдахад шаардлагатай бэлтгэл ажиллагаануудыг хамтран хийнэ.¹²⁸

Энэ нь эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэхтэй холбогдсон нотлох ажиллагааны нэг бие даасан үе шат бөгөөд цаг хугацааны хувьд 3 сар хүртэл байна. Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шүүхийн зүгээс (ЭПХ-ийн 266.9-р зүйл) яллах дүгнэлт нь тухайн хэргийн факт, баримт сэлтүүдтэй хэрхэн тохирч байгааг хянаж, нотолгоог тодруулж, цугларсан нотлох баримтыг талууд хэрхэн хүлээн авч байгааг байцаан шалгана. Зарим эргэлзээтэй, зөрүүтэй баримт сэлтийг гүйцэд нотлохыг шүүх талуудаас шаардах эрхтэй. Түүнчлэн нэмж шалгах, болон зарим тодруулах тайлбарыг гаргуулж болно. Нэг талаас эрүүгийн хэргийн шүүхээр хэлэлцэж шийдвэрлэх бэлтгэл хангагдсан эсэхийг нотлох баримтыг урьдчилан шалгах замаар тодруулах процесс ажиллагааг явуулна.¹²⁹

Бэлтгэл хуралдааны үеийн шүүхийн эрх хэмжээ:

- а) Ялын төлөвлөгөөнд заасан үйл баримтыг тодруулах эсхүл хуулийн холбогдох заалтыг тодруулах;
- б) Ялын төлөвлөгөөнд тусгагдсан үйл баримт, хуулийн зүйл, заалтыг өөрчлөх, нэмэх, хасах асуудлыг зөвшөөрөх;
- в) Хэргийн яллах үйл баримтад холбогдох үндэслэлүүдийг дарааллын дагуу тодруулах;

¹²⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 12 дахь тал

¹²⁹ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 136-137 дахь тал

- г) Бусад төвөгтэй тодорхойлолт болон тооцоог агуулсан асуудлыг тайлбарлахыг шаардах;
- д) Нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх талаар хүсэлт гаргахыг шаардах;
- е) Нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргах;
- ё) Нотлох баримтыг үнэлэн шалгах арга хэрэгсэл, дэс дарааллыг тогтоох;
- ж) Баримт бичигтэй танилцах, хувилахтай холбогдон гаргасан хүсэлтийн талаар шийдвэр гаргах;
- з) Хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны өдрийг товлох, өөрчлөх;
- и) Хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны ажиллагаанд шаардлагатай бусад асуудлыг тодорхойлох¹³⁰

Бэлтгэл хуралдаан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөө, нарийн нягт байдлыг нэмэгдүүлэх, шүүгч тухайн хэрэг, нотлох баримтын талаар шүүх хуралдаанаас өмнө илүү сайн мэдээлэлтэй болох ач холбогдолтой юм. Бэлтгэл хуралдааны үеэр шүүх ялын төлөвлөгөөг тодруулах, нотлох баримтыг зөвшөөрөх талаар шийдвэр гаргах гэх мэт чухал асуудлыг шийдвэрлэсэн байдаг онцлогтой.¹³¹

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 33 дугаар бүлэг буюу 33.1, 33.2, 33.3, 33.4 дүгээр зүйлд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааг заасан. ЭХХШТХ-д прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүгч хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг прокурорт буцаах, хэргийг түдгэлзүүлэх, хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх шийдвэрийн аль нэгийг гаргадаг. Уг 15 хоногийн хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол 30 хүртэл хоногоор сунгаж болохоор заажээ. Хуульд урьдчилсан хэлэлцүүлэг явуулахтай холбоотой хугацааг урьдчилсан хэлэлцүүлгийн үйл явцтай холбоотойгоор нарийн тодорхойлоогүй,

¹³⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 14 дахь тал

¹³¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 42 дахь тал

зөвхөн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байх дээд хугацааг 15, 30 хоног дотор байхаар заасан нь харьцангуй богино хугацаа юм.

МУ-ын ЭХХШХ-ийн 31.1 дүгээр зүйлд заасанчлан урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд дурдсан гэмт хэргийн хүрээнд талуудын гомдол, хүсэлтээр, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргахаар заасан байдаг. Үүнд:

6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана:
 - 6.1. өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;
 - 6.2. хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;
 - 6.3. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;
 - 6.4. прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;
 - 6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;
 - 6.6. хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт;
 - 6.7. яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;
 - 6.8. яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;
 - 6.9. шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт;
 - 6.10. шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал, хүсэлт;
 - 6.11. шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;
 - 6.12. таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;
 - 6.13. нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;
 - 6.14. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;
 - 6.15. мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;
 - 6.16. хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;
 - 6.17. эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.

Хуульд нотлох ажиллагаатай холбоотой асуудлын хүрээнд зөвхөн “шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал, хүсэлт”, “нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол” гэж заасан нь хязгаарлагдмал шинжтэй болжээ.

БНСУ-д ЭХХШТХ-д зааснаар нотлох баримтын хүрээнд “нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх талаар хүсэлт гаргахыг шаардах”, “нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргах”, “нотлох баримтыг үнэлэн шалгах арга хэрэгсэл, дэс дарааллыг тогтоох” зэрэг асуудлыг шийдвэрлэхээр заасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, шүүхээс чанартай шийдвэр гаргах нөхцөл байдлыг олгоход илүү ач холбогдолтой болсон байна. Бэлтгэл, урьдчилан хуралдаан нь нотлох ажиллагааны бие даасан нэг үе шат тул харьцангуй боломжит хугацаагаар хурлыг үргэлжлүүлдэг.

Бэлтгэл, урьдчилсан хуралдааны явцад яллах дүгнэлт нь тухайн хэргийн факт, баримт сэлтүүдтэй хэрхэн тохирч байгааг хянаж, нотолгоог тодруулж, цугларсан нотлох баримтыг талууд хэрхэн хүлээн авч байгааг байцаан шалгана.

Зарим эргэлзээтэй, зөрүүтэй баримт сэлтийг гүйцэд нотлохыг шүүх талуудаас шаардах эрхтэй. Түүнчлэн нэмж шалгах болон зарим тодруулах тайлбарыг гаргуулах зэргээр үр бүтээмжтэйгээр хийдэг байна.

Прокурор нь шүүгдэгч, түүний өмгөөлөгч үйл баримт болон эрх зүйн асуудалтай холбоотой асуудлаар нотолгоо гаргах үед дараах бичиг баримтыг хувилах, тэдгээртэй танилцахыг (бичгэн хэлбэрээр авахыг) шаардаж болно. Үүнд:

- а) Шүүгдэгч, түүний өмгөөлөгч нотлох баримт гэж хүлээн зөвшөөрөх хүсэлт гаргах зорилго бүхий баримт бичиг;
- б) Шүүгдэгч, түүний өмгөөлөгч нь гэрч болон хэрэгт хамаарал бүхий этгээд хэмээн хүлээн зөвшөөрөх хүсэлт гаргахыг зорьж буй хүмүүсийн нэрсийг тодорхойлсон тэмдэглэл;

- в) А, Б хэсэгт заасан баримт бичгийн үнэн гэдгийг нотолж буй баримт бичиг;
- г) Эрх зүйн асуудал, үйл баримттай холбоотой шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн гаргах нотолгоотой хамаарал бүхий баримт бичиг¹³²

Прокурорын дээрх шаардлагыг шүүгдэгч, түүний өмгөөлөгч үл биелүүлбэл прокурор нь шүүхэд хандаж болно. Бэлтгэл хуралдааныг дараах үндэслэл бүрдсэн үед хаана. Үүнд:

- а) Нотлох баримт болон холбогдох асуудлуудыг дэс дараалуулан бүрэн байрлуулсан;
- б) Бэлтгэл хэлэлцүүлгийн процесс эхэлснээс хойш 3 сарын өнгөрсөн;
- в) Прокурор, өмгөөлөгч, шүүхийн зарлан дуудах хүлээн авсан шүүгдэгч хүрэлцэн ирээгүй.¹³³

4.6.2. ЭХХША дахь өмгөөлөгчийн эдлэх үндсэн эрхүүд:

- **Хэргийн материалтай танилцах болон хуулбарлах эрх**

Өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцах, хуулбарлах эрх нь сэжигтэн болон яллагдагчийн өөрийгөө хамгаалах эрхийг бодит байдал дээр хэрэгжүүлэхийн бэлтгэх үе шат байдаг тул өмгөөлөгчийн туслалцаа үзүүлэх эрх болон мэдэх эрхтэй нягт холбоотой¹³⁴ байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаанаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох хүртэлх өмгөөлөгчийн хэргийн материалтай танилцах болон хуулбарлах эрхтэй холбоотой зохицуулалтуудыг судалбал:

¹³² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 14 дэх тал

¹³³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 14 дахь тал

¹³⁴ 박혜림, “변호인의 조력을 받을 권리의 현황 및 개선과제”, NARS 현안분석 vol.53, (2019), 3면

Прокурор хэргийг шүүх рүү шилжүүлэхээс өмнөх үе шатанд хэргийн материалтай танилцах болон хуулбарлах эрхийг БНСУ-ын ЭХХШтХ-аар зохицуулаагүй, зөвхөн Прокурорын ерөнхий газрын журам болох “Хэргийн материалтай танилцах болон хуулбарлах ажлын тухай зөвлөмж”¹³⁵ болон Хууль зүйн яамнаас баталсан “Прокурорын хэргийг хадгалах тухай журам”¹³⁶-аар зохицуулж байна. Хэргийн материалтай танилцах болон хуулбарлах ажлын тухай зөвлөмжийн 3-р зүйлд заасны дагуу хэргийн холбогдогч (өмгөөлөгчийг хамруулна) эсхүл бусад оролцогч (гэрч зэрэг) нь хянан шийдвэрлэж буй хэргийн тэмдэглэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоосон тэмдэглэл, хаасан тэмдэглэлээс өөртэй холбоотой эсхүл өөрийн гаргаж өгсөн бичиг баримтын бүхэлд нь эсхүл зарим хэсэгтэй холбогдуулан танилцах, хуулбарлах хүсэлт гаргаж болох бөгөөд прокурор нь тэмдэглэл үзүүлэх нь төрийн аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хэргийн холбогдогчдын нэр хүнд, хувийн нууц зэрэгт ноцтой зөрчил үүсгэхээр байгаагаас бусад тохиолдолд үзүүлж болно.

Прокурор хэргийг шилжүүлсний дараах үе шатанд хэргийн материалтай танилцах болон хуулбарлах эрхийн тухайд ЭХХШтХ-ийн 35-р зүйлд ‘Прокурор хэргийг шүүхэд шилжүүлсний дараа өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой материал эсхүл нотлох баримттай танилцах, хуулбарлаж авах эрхтэй’ гэж, уг хуулийн 266-р зүйлийн 3 дахь хэсэгт яллагдагч эсхүл өмгөөлөгч нь прокурорын шүүхэд шилжүүлсэн хэрэгтэй холбоотой материал, эд зүйлийн жагсаалт, ял оногдуулахад ач холбогдол бүхий материалтай танилцах, хуулбарлах эсхүл бичгээр хүлээн авах хүсэлт гаргаж болно.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа хэргийн материалтай танилцах, хуулбарлах нь ЭХХШтХ-ийн 59-р зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэн ч хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэртэй танилцах эсхүл хуулбарлах хүсэлт гаргаж болохоор

¹³⁵ <https://www.law.go.kr/LSW/admRulLsInfoP.do?admRulSeq=2100000036214>

¹³⁶ <https://www.law.go.kr/>

заасан байна. Энэхүү эрхтэй холбоотойгоор прокуророос шүүхэд хэргийг шилжүүлэхээс өмнөх үе шатанд өмгөөлөгчийн хэргийн материалтай танилцах, хуулбарлах хүсэлт гаргах эрхийг хуулиар бус прокурорын ажиллах журмаар зохицуулсан нь өмгөөлөгчийн эрхийг зөрчсөн талаар Үндсэн хуулийн шүүхээс тогтоол гаргасан¹³⁷ учраас ЭХХШТХ-ийн журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. Харин ЭХХШТХ-д ч гэсэн ижил утгатай зохицуулалтыг оруулахаар олон судлаачид санал дэвшүүлж байгаа¹³⁸ болно.

· **Сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгчийн оролцох эрх**

Сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа нь хэргийн бодит нөхцөл байдлыг шалгахад их ач холбогдолтой¹³⁹. Учир нь прокурор болон мөрдөн шалгах цагдаагийн сэжигтнээс авсан мэдүүлэг нь сэжигтнийг гэм буруутайг нотлоход чухал нотлох баримтаар ашиглагдах боломжтой, онцгойлон прокурорын үе шатанд бичигдсэн сэжигтнээс авсан мэдүүлэг нь процессын алдаа гаргаагүй бол нотлох баримтаар шууд хэрэглэгдэх боломжтой.¹⁴⁰

Мөрдөн шалгах ажиллагаанд хамгийн их нотлох баримт цугларч, эцсийн шийдвэрийн ерөнхий чиглэл гардаг. Тиймээс энэ ажиллагааны үе шатан дахь өмгөөлөгчийн оролцоо нь шүүхийн үе шатаас илүү чухал үе шат байдаг.¹⁴¹

2017 онд ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулан 243-р зүйлийн 2 дахь хэсгийг дараах байдлаар шинээр зохицуулжээ.

243-р зүйлийн 2 (өмгөөлөгчийг оролцуулах)

(1) Прокурор, мөрдөн шалгах цагдаа нь сэжигтэн эсхүл түүний өмгөөлөгч, Хууль ёсны төлөөлөгч, гэрлэгч, гэр бүлийн гишүүдийн хүсэлтэд үндэслэн сэжигтнийг өмгөөлөгчтэй

¹³⁷ Хүнбүжэпвэсэ 2003.3.27снго 2000хүнмэ 474гэжэ

¹³⁸ Бэхтэрип, “бнхонини зорьку бэвэл кинри хнхвэ мнэ гэсэнкэжэ”, NARS хнхвэбнхэ vol.53, (2019), 5бн

¹³⁹ Ихэнгүн, зонкэ, имисн. “сусэвэни шнжэни зосри хэвкэ мнэчн хнхвэ.” хнхвэшнхэвхэвхэ: бэп 11.3 (2020): 267.

¹⁴⁰ Хүнбүжэпвэсэ 2017.11.30 снго 2016хүнмэ503гэжэ

¹⁴¹ зэснэнгил. “хнхвэжэчэсэ бнхэвхэвхэвхэ кинрибнхэвхэ кэвн хнхвэ.” бнхвэвхэвхэ 37. (2010): 217.

уулзуулах, хүндэтгэн үзэх шалтгаантай байгаагаас бусад тохиолдолд мэдүцлэг авах ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.

Сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаанд хүсэлт гаргах замаар өмгөөлөгчийг оролцуулах боломжтой болохыг тодорхой тусгаж¹⁴², мөрдөн шалгах эрх бүхий субъект нь мэдүүлэг авахаас өмнө сэжигтэнд өмгөөлөгчийг оролцуулах, өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхтэй болохыг мэдэгдэх үүрэгтэй.¹⁴³ Зөвхөн баривчлагдсан сэжигтэн бус бүх сэжигтний өмгөөлөгчтэй уулзах эрх, мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулах эрхийг зохицуулсан байна.

Мөн 2018 оны 01-р сарын 07-ны өдөр прокурорын ажиллах журмыг шинэчилж мэдүүлэг авах ажиллагаанд саад учруулсан, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулсан тохиолдолд өмгөөлөгчийн оролцоог хязгаарлахаар тодорхой зохицуулсан.

2017 оноос өмнө сэжигтнээс мэдүүлэг авахад өмгөөлөгчийг сэжигтнээс хол зайтай суулгах, сэжигтний хойно суулгадаг тохиолдол практикт элбэг байсан. Харин Үндсэн хуулийн шүүх энэ практиктэй холбогдуулан 2017 оны 11-р сарын 30-ны өдөр дараах шийдвэрийг гаргажээ:

i. Хэргийн нөхцөл байдал.

Нэр бүхий өмгөөлөгчийг 2016.4.21-ны өдрийн 16:30 цагт цагдан хоригдсон сэжигтэн өмгөөлөгчгүйгээр байцаалтад оролцохгүй тул ирэхийг хүссэн мөрдөгчийн хүсэлтийн дагуу уг өдрийн 17:15 цагт прокурорын газарт очиж байцаалтын өрөө рүү ороод сэжигтний хажууд суух гэсэн боловч сэжигтний хойно суухыг шаардаж хол суулгасан байна. Улмаар өмгөөлөгч өөрийн өмгөөлөл хийх үйл ажиллагаанд саад учруулж, эрх зөрчигдсөн гэж үзэн Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргажээ.

¹⁴² БНСУ-ын Хууль зүйн яам, 2007 оны ЭХХШТХ-ийн нэмэлт өөрчлөлт

¹⁴³ 244.3-р зүйлийн 244.3.1: Прокурор эсхүл мөрдөн шалгах цагдаа сэжигтнээс мэдүүлэг авахаас өмнө дараах зүйлийг танилцуулна.

244.3-р зүйлийн 244.3.1.4. мэдүүлэг өгөхөд өмгөөлөгчийг оролцуулах зэрэг өмгөөлөгчөөс туслалцаа авах боломжтой болохыг;

ii. Шүцхээс шийдвэрлэсэн байдал

Сэжигтнээс байцаалт авахад өмгөөлөгч чөлөөтэй оролцох эрх нь сэжигтний өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхийг бодит байдал дээр хэрэгжүүлэх эхний алхам тул Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн хувьд хамгаалагдаж ёстой. Иймээс сэжигтнээс байцаалт авахад өмгөөлөгч сэжигтний хажууд суух нь мөрдөн шалгах ажиллагаанд саад болох, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах магадлал өндөр тул өмгөөлөгчийг хол суулгах нь зүйтэй гэх хариуцагчийн тайлбар үндэслэлгүй байна. Учир нь өмгөөлөгчийг хол суулгах нь өөрөө сэжигтний сэтгэл зүйн хувьд дарамт үзүүлж, өмгөөлөгчөөс идэвхтэй зөвлөгөө авах боломжгүй болж улмаар өмгөөлөгчийн хувьд ч гэсэн сэжигтэнд тулгарч байгаа нөхцөл байдлыг тодорхой мэдэх боломжгүй юм. Иймээс өмгөөлөгчийг сэжигтнээс хол суулгасан үйлдэл болон хол суухыг шаардсан нь өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхийг зөрчсөн байна гэж үзсэн байдаг.

Энэхүү сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй прокурорын шийдвэрт гомдол гаргасан дараах тохиолдол байдаг.

i. Хэргийн нөхцөл байдал.

Өмгөөлөгч А цагдан хоригдсон сэжигтэн Б-ийн өмгөөлөгчөөр прокуророос мэдүүлэг авах ажиллагаанд оролцох болсон. Харин прокурор сэжигтэн Б-гээс гавтай мэдүүлэг авах гэж байсан бөгөөд өмгөөлөгчийн зүгээс гавыг суллахыг шаардсан боловч прокурор эс зөвшөөрсөн. Өмгөөлөгчийн зүгээс гав суллахыг дахин шаардахад прокурор мэдүүлэг авах ажиллагаанд саад учруулж байна гэх шалтгаанаар өмгөөлөгчийг албадан гаргасан. Энэхүү прокурорын үйлдэлд дээд шатны прокурорын байгууллагад гомдол гаргасан боловч өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлгүй гэж үзжээ. Улмаар өмгөөлөгч нь шүцхэд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулсан, тайлбар гаргах эрхийг зөрчсөн үндэслэлээр төр болон прокуророос хохирол гаргуулах нэхэмжлэл гаргасан.

ii. Шүүхээс шийдвэрлэсэн байдал

Мэдүцлэг авах ажиллагаанд сэжигтэн зугтах, хүчирхийлэл үйлдэх зэргийн нөхцөл байдал үүсэх нь болзошгүй байгаагаас бусад тохиолдолд сэтгэл зүйн, бие махбодын хувьд дарамт шахалтгүйгээр өөрийгөө хамгаалах эрхээ хэрэгжүүлэх ёстой. Иймээс прокурорын шийдвэрт гаргасан өмгөөлөгчийн гомдол үндэслэлтэй байхад өмгөөлөгчийг албадан гаргасан прокурорын үйлдэл хууль бус тул өмгөөлөгчид хохирол барагдуулах нь зүйтэй гэж дүгнэсэн байдаг.

• **Өмгөөлөгчийн уулзах эрх**

БНСУ-ын ЭХХШТХ-ийн 34 дүгээр зүйлд “Өмгөөлөгч эсхүл өмгөөлөгч болох гэж буй хүн нь баривчлагдсан сэжигтэн, яллагдагчтай уулзаж бичиг баримт эсхүл эд зүйлийг харилцан солилцож болох бөгөөд эмчийн туслалцаа авхуулах эрхтэй.” гэж зохицуулж сэжигтэн болон яллагдагчтай уулзалт хийх эрхийг тодорхойлсон байна.

Өмгөөлөгч сэжигтэнтэй уулзсанаар хэргийн агуулгыг ойлгох, сэжигтнийг хамгаалах арга замыг бэлдэх боломжтой болно. Энэ нь өмгөөлөгчийн өвөрмөц эрх мөн.¹⁴⁴ БНСУ-ын энэхүү зохицуулалтын хэд хэдэн онцлог байдаг. Үүнд

i. Өмгөөлөгч болох гэж буй хүн ч гэсэн уг эрхээ эдлэх боломжтой.

Өмгөөлөгч болох гэж буй хүн гэдэг нь өмгөөлөгч болох эрх хангагдсан боловч хараахан өмгөөлөгчийн холбоонд бүртгүүлээгүй байгаа зэрэг өмгөөлөгч болох нь тодорхой болсон хүн эсхүл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг хараахан байгуулаагүй өмгөөлөгчийг хамруулна.¹⁴⁵

ii. Энэхүү эрхтэй холбоотойгоор өмгөөлөгч төрд оюун санааны хохирлыг шаардах боломжтой.

¹⁴⁴ 신이철 "피고인·피의자의 접견교통권에 대한 올바른 해석과 입법적 제언" 형사법의 신동향 66 pp.53

¹⁴⁵ 헌법재판소 2019.2.28. 2015헌마1204 결정, “Өмгөөлөгч болох нь тодорхой болсон хүн баривчлагдсан сэжигтэнтэй уулзах хүсэлт гаргахад үүнийг хязгаарлах нь өмгөөлөгчийн эдлэх эрхийг хязгаарласан үйлдэл болно” гэж Үндсэн хуулийн шүүхээс тайлбарлажээ.

Сэжигтэн, яллагдагч өөрийн эдлэх үндсэн эрхийг бүрэн ухамсарлаж өмгөөлөгчтэй уулзах эрхээс өөрөө татгалзсанаас бусад тохиолдолд мөрдөн шалгах эрх бүхий байгууллага өмгөөлөгчийн сэжигтэн, яллагдагчтай уулзах эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах нь өмгөөлөгчийн эдлэх эрхийг зөрчсөн гэж үзэж төр өмгөөлөгчийн оюун санааны хохирлыг барагдуулах хариуцлага хүлээдэг¹⁴⁶ Өмгөөлөгчийн уулзалт хийх эрхтэй холбогдуулан төрд оюун санааны хохирлыг шаардах тохиолдол бол элбэг гардаггүй, ховор байдаг ч гэсэн дараах кэйсийг дурдаж болно. Үүнд:

Өмгөөлөгч А нь прокуророос сэжигтэн Б-г байцаалт хийхэд хамт оролцох хүсэлт гаргасан боловч прокурорын зүгээс байцаалтын тэмдэглэлээ засах шаардлагатай гэх шалтгаанаар татгалзаж, өмгөөлөгчийг оролцуулахгүйгээр сэжигтэн Б-ээс байцаалт авч өмгөөлөгчийн уулзалт хийх эрхийг зөрчсөн гэсэн үндэслэлээр шүүхэд гомдол гаргасан ба шүүх “мөрдөгчийн үйлдэл нь өмгөөлөгчөөс туслалцаа авах сэжигтний эрх болон өмгөөлөгчийн уулзалт хийх эрхийг зөрчсөн байна” хэмээн өмгөөлөгч, сэжигтэн аль алинд оюуны хохирлоо барагдуулах нь зүйтэй гэж дүгнэжээ¹⁴⁷.

Өнөөдрийн байдлаар ЭХХШТХ-ын 91 дүгээр зүйлд “Шүүх оргон зайлах, хэргийн нотлох баримтыг устгах болзошгүй гэж үзэх үндэслэлтэй бол өөрийн эрхээр эсхүл прокурорын хүсэлтэд үндэслэн цагдан хоригдсон яллагдагч болон 34 дүгээр зүйлд заасан этгээд (өмгөөлөгч эсхүл өмгөөлөгч болох гэж буй хүн)-ээс бусад этгээдтэй уулзахыг хориглож болох бөгөөд...” гэж зохицуулан өмгөөлөгч бус этгээдийн сэжигтэн, яллагдагчтай уулзах эрхийг хязгаарласан зохицуулалт байгаа боловч өмгөөлөгчийн сэжигтэн, яллагдагчтай уулзалт хийх эрхийг хязгаарласан тусгай зохицуулалт байхгүй. Энэхүү зохицуулалт нь өмгөөлөгчийн сэжигтэн, яллагдагчтай уулзалт хийх эрх нь бусад субъектийн уулзах эрхээс ялгаатай болохыг харуулах зорилгоор оруулсан заалт юм.¹⁴⁸ Мөн Дээд шүүхээс

¹⁴⁶ дабыл 2003. 1. 10. 선고 2002да56628 판결; дабыл 2018. 12. 27. 선고 2016да266736 판결.

¹⁴⁷ <http://news.koreanbar.or.kr/news/articleView.html?idxno=23930>

¹⁴⁸ 강병훈, “변호인의 조력을 받을 권리”, 『형사소송 이론과 실무』, 형사소송법학회(2009), 208쪽.

“Өмгөөлөгчийн уулзалт хийх эрх нь баривчлагдсан яллагдагч эсхүл сэжигтний хүний эрхийн баталгаа болон өөрийгөө хамгаалах эрх нь заавал хэрэгжих ёстой, салиггүй эрх тул хууль тогтоомжид үндэслэсэн хязгаарлалт байгаагаас бусад тохиолдолд мөрдөн шалгах байгууллагын шийдвэрээр төдийгүй шүцхийн шийдвэрээр ч энэ эрхийг хязгаарлаж болохгүй”¹⁴⁹ гэж тайлбарласан юм.

1992 оны 01-р сарын 28-ны өдрийн Үндсэн хуулийн шүүхийн тогтоол¹⁵⁰-ын дагуу өмгөөлөгчийн уулзалт хийх эрх нь аливаа хяналтгүй, саадгүй эрх чөлөөтэй уулзалт хийх зарчимтай тул уулзалтын агуулгын нууц задрахгүй байх нөхцөлөөр хангах үүднээс ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх болон ялтны тухай хууль¹⁵¹-ийн 84 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу уулзалт хийхэд хорих ангийн албан хаагч эсхүл цагдаа оролцохыг зөвшөөрдөггүй бөгөөд уулзалтын агуулгыг сонсох, дуу хоолойн бичлэг хийж болохгүй. Харин ажиглалт хийж болохоор заасан байдаг юм. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн шүүхээс тайлбарлахдаа *“Цагдан хорих газарт байрлах өмгөөлөгчтэй уулзах өрөөнд хяналтын камер байршуулан шүцхийн шийдвэр гарахаас өмнө цагдан хоригдсон хүн болон өмгөөлөгч хоорондын уулзаж байгааг хянах нь өмгөөлөгчийн уулзалт хийх эрхэд халдсан гэж үзэх боломжгүй”* гэж тайлбарлан ямар үйлдэл нь өмгөөлөгчийн уулзалт хийх эрхийг зөрчөөгүй болохыг тодорхой дурджээ.

Мөн өмгөөлөгчийн уулзалт хийх эрх нь Үндсэн хуульд заасан өмгөөлөгчийн туслалцаа авах эрхийг бодит байдал дээр хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл болох тул хүсэлт гаргасан даруй уулзалт хийх боломжоор хангах шаардлагатай гэж үзэж өмгөөлөгч уулзалт хийх

¹⁴⁹ Дайрхын 1990. 2. 13. 89м37 гелж; дайрхын 1991. 3. 28. 91м24 гелж; дайрхын 1996. 6. 3.г96м 18 гелж; дайрхын 2002. 5. 6. 2000м112 гелж.

¹⁵⁰ [https://www.law.go.kr/%ED%97%8C%EC%9E%AC%EA%B2%B0%EC%A0%95%EB%A1%80/\(91%ED%97%8C%EB%A7%88111\)](https://www.law.go.kr/%ED%97%8C%EC%9E%AC%EA%B2%B0%EC%A0%95%EB%A1%80/(91%ED%97%8C%EB%A7%88111))

¹⁵¹ 1950 оны 03-р сарын 18-ны өдөр батлагдаж, 2020 оны 02-р сарын 04-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. <https://www.law.go.kr/lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%ED%98%95%EC%A7%91%ED%96%89%EB%B2%95#undefined>

хүсэлт гаргаснаас хойш боломжит хугацаа (10 хоног) өнгөрсөн¹⁵² эсхүл хүсэлтэд дурдсан хугацаанаас 1 цаг өнгөрсөн бол эрхэд халдсан¹⁵³ гэж үзэх ёстой хэмээн дүгнэдэг байна.

БНСУ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоогоо хөгжүүлэх, шинэтгэхийг эрмэлзэж байгаа нь Англи-Америкийн буюу нийтлэг эрх зүйн тогтолцооны зарим элементийг нутагшуулах гэсэн оролдлого гэж харагдаж байна. Монгол Улсын Эрүүгийн процессын систем нь эх газрын болон нийтийн эрх зүйн тогтолцоотой улсуудын аль “сайн” туршлагыг судалж нутагшуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, аливаа улсын эрх зүйн тогтолцоо ямар эрх зүйн бүл, уламжлалд хамаарна, тэрхүү бүл, уламжлалд хамаарах улсын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтыг нутагшуулан авах ёстой гэсэн уламжлалт хандлагын эсрэг жишээг эх газрын эрх зүйн бүлд хамаарах хэр нь жишгийн эрх зүйн бүлээс рецепци хийж байгаа БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.¹⁵⁴

4.6.3. ЭХХША-нд цахим технологи ашиглаж оролцож буй асуудал

БНСУ-ын хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч цахимаар шүүхийн бичиг баримт хүлээн авч танилцах, хадгалах нь нийтлэг практик болсон.¹⁵⁵ Ийнхүү цахимаар хялбар аргаар баримт бичиг гаргаж өгөх зэрэг нь иргэний шүүхэд чөлөөтэй хандах эрхийн баталгаа болохоос гадна шүүхийн ачааллыг бууруулж, үйл ажиллагааг хурдан шуурхай болгож байгаа явдал юм.

Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж цахим хэлбэр бүхий бичиг баримтыг ашиглан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

¹⁵² 대법원 1991. 3. 28. 91모24 결정.

¹⁵³ 서울민사지판 1991. 9. 19. 91가단24555.

¹⁵⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа: ХБНГУ, БНСУ, 2015 он, 44, 45 дахь тал

¹⁵⁵ Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хууль зүйн үйлчилгээний томоохон дэвшилт хэмээн тайлбарлажээ. 기우중, “소송의 새로운 틀 전자소송,” [저스티스, 2010.12. 한국법학원, хуудас 171]

явуулахыг хэлнэ. БНСУ-ын хувьд 2010 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэлбэр бүхий бичиг баримтыг ашиглах тухай хууль (цаашид “цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль” гэнэ).¹⁵⁶-ийн 1-р зүйлд заасан зорилгын¹⁵⁷ хүрээнд 2010 оноос эхлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулж 2015 онд шүүхээс гарах захирамж, тогтоол, шийдвэрийг биелүүлэх ажиллагааг хүртэл цахимаар явуулах болсон.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль батлагдаж 2010 оны 04-р сарын 26-ны өдрөөс патентын шүүхэд хэрэгжиж эхэлсэн ба 2011 оны 05-р сарын 02-ны өдрөөс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон эвлэрүүлэн зуучлалд хэрэгжиж эхэлж, захиргаа /гэр бүл/ дампуурлын хэрэгт хэрэгжих байдлаар хүрээ нь өргөжиж байгаа бөгөөд 2015 оны 03-р сарын 23-ны өдрөөс шүүхээс гарах шийдвэр, захирамж, тогтоолыг гүйцэтгүүлэх ажиллагаанд ч хэрэгжиж цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар төлөвлөж байсан бүх хүрээнд хэрэгжих болсон.

- **Систем ашиглах арга**

БНСУ-д хувь хүн цахим албан ёсны гэрчилгээтэй¹⁵⁸ байвал аль ч компьютероор нэвтрэх боломжтой буюу гар утаснаасаа нэвтрэх үйлдэл хийх боломжтой. Мөн нэг системээр бүх үйлдэл хийх боломжтойгоор онцлогтой байдаг.

¹⁵⁶ <https://www.law.go.kr/>

¹⁵⁷ Энэ хууль нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим бичиг баримтыг ашиглахтай холбоотой үндсэн зарчим болон процессийг зохицуулж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь мэдээлэл технологийг хөхүүлэн дэмжих, шуурхай байдал, ил тод байдлыг хангаж бодит байдал дээр иргэдийн эрхээ хэрэгжүүлэхэд оршино.

¹⁵⁸ Joint certificate

Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем хэрэглэгч

- (1) Талууд болон талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгч, хэргийн холбогдогчид¹⁵⁹ иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд бүр цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно. Үүнээс гадна хэргийн холбогдогчийн хувьд шүүхэд бичиг баримт гаргаж өгөх этгээд ч гэсэн шүүхийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг ашиглаж, цахимаар бичиг баримт гаргаж өгч болно. Өөрөөр хэлбэл энэхүү систем нь зөвхөн оролцогч талууд болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гадна хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч, эвлэрүүлэн зуучлагч, шүүхээс гарах шийдвэр болон захирамж, тогтоолыг гүйцэтгүүлэгч ч гэсэн ашиглах боломжтой гэсэн үг юм.
- (2) БНСУ-ын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гадаадын иргэний эрх зүйн байдлыг хязгаарласан зохицуулалт байхгүй¹⁶⁰ тул гадаад улсын иргэн иргэний эрх зүйн бүрэн чадамжтай бол цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.
- (3) Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг нэхэмжлэгч болон хариуцагч талууд тэдний өмгөөлөгчид ашиглаж, шүүх хэргийн материалыг цахим байдлаар хадгалах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүрэн явуулах боломжтой.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар шүүх талуудыг цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг ашиглах эсэхээс үл хамаараад зарчмын хувьд бүх иргэний хэргийн материал, тэмдэглэлийг цахим мэдээллийн системд бүртгүүлэх үүрэгтэй болсон тул цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийг ашиглахгүй байгаа оролцогч талууд болон итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд цахим систем хэрэглэхийг санал болгохоор зохицуулсан байдаг.

¹⁵⁹ Гэрч, шинжээч, бичиг баримт гаргаж өгөх үүрэг хүлээсэн гуравдагч этгээд, бичиг баримт хүргүүлэхээр үүрэг хүлээсэн этгээд зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд болох шууд бусаар холбогдсон аливаа этгээдийг хэлнэ.

¹⁶⁰ 정동윤 등, [민사소송법], 제5판, 2016 он, 186 хуудас

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах нь өмгөөлөгчийн хувьд маш үр дүнтэй тогтолцоо болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд голчлон оролцдог этгээдийн хувьд бичиг баримт гаргаж өгөх, тэмдэглэл үйлдэх, бичиг баримт хүргүүлэх болон хүлээн авах зэрэг ажлыг өмгөөлөгч гүйцэтгэдэг тул өмгөөлөгчийн ачааллыг ч хүртэл бууруулах боломжтой¹⁶¹ гэж БНСУ-ын Дээд шүүх болон БНСУ-ын Өмгөөлөгчдийн холбоо хамтарсан хурал болох шүүхийн тогтолцоог сайжруулах хороогоор дамжуулж дүгнэлт гаргасан байдаг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим болгосонтой адил эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим болгох зорилгоор 2021 оны 09-р сарын 19-ны өдөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим бичиг баримтыг ашиглах тухай хууль¹⁶²-ийг баталсан бөгөөд энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тодорхой хүрээнд цахимаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж эхэлж байна.

Холбогдох хууль тогтоомж

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахыг дэмжих тухай хууль

Тус хуулиар мөрдөн шалгах ажиллагаанаас шүүхэд хэрэг шилжүүлэх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх хүртэлх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатны үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохицуулсан байдаг.

Шүүх болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдох бичиг баримтыг эрүүгийн хэргийн мэдээллийн системийг ашиглаж хадгалах бөгөөд эрүүгийн хэргийн мэдээллийн системийн үйл ажиллагаа явуулах, хяналт тавих нь үүнийг ашиглаж буй тухайн шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцаж буй байгууллага өөрөө хариуцна.

¹⁶¹ <https://www.lawtimes.co.kr/Legal-News/Legal-News-View?serial=101700>

¹⁶² <https://www.law.go.kr/> энэхүү хуулийг 2024.10.20-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Өнөөдрийн байдлаар эрүүгийн хэргийн мэдээллийн системийг мөрдөн шалгах байгууллага өөрөө нэгдсэн байдлаар хяналт тавьж байгаа учраас хараат бус байдлыг хангах арга замыг олж нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байгаа¹⁶³ болно.

- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэргийн цахим бичиг баримтын тухай хууль

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэргийн цахим бичиг баримтын тухай хууль нь хэдийгээр хамаарах хүрээ согтуугаар жолоо барих болон жолоодох эрхгүйгээр жолоо барихтай холбогдох хэргээр хязгаарлагдмал байдлаар хэрэгжиж байгаа ч гэсэн цахимаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцооны анхны алхам болсон. Цахимаар хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаа явуулах нь бичгээр ажиллагаа явуулахаас илүү хурдан, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

- Цахим бичиг баримт болон цахим арилжааны ерөнхий хууль, цахим гарын үсгийн тухай хууль

Цахим бичиг баримт нь Цахим бичиг баримт болон цахим арилжааны ерөнхий хуулийн 4.1-д заасны дагуу бусад хуулиар тусгайлан зохицуулснаас бусад тохиолдол цахим хэлбэр гэсэн шалтгаанаар үүнийг хүчин төгөлдөр бусад тооцдоггүй бөгөөд цахим гарын үсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу бусад хууль тогтоомжоор аливаа бичигт гарын үсэг эсхүл хувийн тамга дарахаар зохицуулсан тохиолдолд гэрчилгээ бүхий гарын үсэг эсхүл хувийн тамга дарагдсан байвал бичиг баримтын шаардлага хангасанд тооцдог. Хуучин бичиг баримт болгонд тухайн хэрэгт төлөөлж өмгөөлж буй өмгөөлөгч бичиг баримт бүрд гараар нэг бүрчлэн гарын үсэг зурдаг байсан бол үүнийг илүү хялбаршуулсан гэж үзэж болно.

- Захиргааны акт болон журам

Цагдаагийн эрүүгийн хэргийн мэдээллийн системийн үйл ажиллагаа явуулах журам, эрүүгийн шийдвэр зэрэгтэй танилцах болон хуулбарлах журам, нотлох баримтын жагсаалт гаргах тухай

¹⁶³ 형사 전자소송의 바람직한 발전 방향, 2020.04.10, 사법정책 연구위원 정성민, 3 хуудас

тусгай журам гэх мэтийн зохицуулалтаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн ажлын ихэнх хэсэг нь цахимжиж бичгийн тэмдэглэлүүд нь цахим байдлаар хадгалагдаж байгаа.

- **БНСУ-ын цахимаар эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал болон үр дүн**

Хуучин хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тохиолдолд мөрдөгч хэргийг нээснээс хойш прокурорт шилжих хүртэл 29 хоног, прокурорт шилжсэнээс хойш шүүхэд шилжүүлэх хүртэл 17 хоног шаарддаг байсан бөгөөд өөрөөр хэлбэл хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах хугацаа нь ойролцоогоор 1.5 сар шаарддаг байсан¹⁶⁴. Харин хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулснаас хойш согтуугаар жолоо барих, жолоо барих эрхгүйгээр жолоо барихтай холбогдох хэргийг шийдвэрлэх нийт хугацаа нь 47 хоногоос 25 хоног шаарддаг болсон¹⁶⁵ гэх дүгнэлт гарсан. Цаашид эрүүгийн хэргийн бүх ажиллагаа цахимжиж өөрчлөгдвөл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах хугацаа богиносх, үр дүнтэй ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх боломжтой болно гэж үзэж байна.

4.6.4. Эрүүгийн хэргийн нөхөн олговор

БНСУ нь эрүүгийн хэргийн нөхөн олговор олгодог онцлогтой ба хэргийн нөхөн олговор гэж төрийн буруутай үйлдэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас шударга бусаар ял эдэлсэн эсхүл цагдан хорих арга хэмжээ авагдсантай холбогдуулан төрөөс олгож буй нөхөн олговор юм.

БНСУ-ын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд “*Эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчийн хувьд хоригдож байсан хүн хуульд заасны*

¹⁶⁴ 송광섭, “약식명령절차에서의 몇 가지 논쟁, 그 이용현황과 개선방안”, [형사법의 신동향], 제40호, 2013, 194 면

¹⁶⁵ БНСУ-ын хууль зүйн яамын эрүүгийн хэргийн албан ёсны цахим хаяг: https://www.kics.go.kr/portal/jsp/popup/kics_brochure.jsp

дагуу хэргийг шүүхэд шилжүүлээгүй эсхүл гэм буруугүй болох тухай шийдвэр гарсан бол хуульд заасны дагуу төрд хандан нөхөн олговрыг шаардаж болно” гэж зохицуулах замаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан нөхөн олговор авах нь үндсэн эрх болохыг харуулж байна. Хэдийгээр Үндсэн хуульд хоригдож байсан гэж субъектийн хязгаарыг тогтоосон мэт харагдаж байгаа ч цаазаар авах ял эсхүл эд хөрөнгийн шинжтэй ял эдэлсэн тохиолдолд ч гэсэн нэгэн адил хамаарна¹⁶⁶. Үндсэн хуульд заасан энэхүү үндсэн эрхийг эрүүгийн хэргийн нөхөн олговор болон нэр төрийг сэргээх тухай хууль баталж үүгээр тодорхой процессыг тусгасан байна.

1958 онд эрүүгийн хэргийн нөхөн олговрын тухай хууль батлагдаж энэхүү тогтолцоо нь 1959 оноос хэрэгжиж эхэлсэн боловч тухайн үед хэлбэр төдий олговор байсан учраас иргэдийн эрхийн баталгаагүй байсантай адил байсан тул 2011 оны 5-р сарын 23-ны өдрийн шинэчилсэн найруулгаар эрүүгийн хэргийн нөхөн олговрын хэмжээг ихэсгэж эрүүгийн хэргийн нөхөн олговор шаардах хугацаа болон гомдол гаргах хүрээг өргөжүүлсэн. Мөн гэм буруугүйг тогтоолгох шүүхийн тов тодорхой болбол БНСУ-ын хууль зүйн яамны цахим хаягт байрлуулах замаар тухайн этгээдийн нэр хүндийг сэргээх болгосон.

БНСУ-ын хууль тогтоомжид хэд хэдэн нөхөн олговортой холбоотой зохицуулалттай тул эрүүгийн хэргийн нөхөн олговор нь бусад хууль тогтоомжид заасан нөхөн олговроос хэрхэн ялгаатай байгааг ангилж үзэх нь судалгааны хувьд чухал нэгэн хэсэг болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зардлын нөхөн барагдуулах гэдэг нь төрөөс гэм буруугүйд тооцсон шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд тухайн хэргийн яллагдагч байсан хүнд уг шүүхийн шатанд гарсан зардлыг барагдуулахыг хэлнэ. Энэхүү зардлын нөхөн барагдуулах тогтолцоо нь төрийн буруутай үйл ажиллагааны улмаас яллагдагч өөрийгөө гэм буруугүй болохыг тогтоолгохын тулд гаргасан өмгөөлөгчийн хөлс, шүүхийн шатанд гарсан зардлыг олгодог тогтолцоо юм.

¹⁶⁶ 이창현, 형사소송법, 2020, 1424 хуудас

Хүснэгт 1. Эрүүгийн хэргийн нөхөн олговор

	Зардлын нөхөн барагдуулах	Эрүүгийн хэргийн нөхөн олговор
Үндэслэл	ЭХХШТХ-ийн 194-р зүйлийн 194.2.1	Үндсэн хууль болон эрүүгийн хэргийн нөхөн олговор болон нэр төрийг сэргээх тухай хууль
Шаардлага гаргах эрх бүхий этгээд	Гэм буруугүйд тооцсон шийдвэр авсан хүн	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруугүйд тооцогдсон этгээд - Сэжигтний хувьд хоригдож байсан этгээдийн дундаас прокурорын зүгээс хэргийг шүүхэд шилжүүлээгүй эсхүл мөрдөн шалгагчаас хэргийг прокурор руу шилжүүлэхгүй шийдвэр авсан этгээд - Процессын алдаанаас болж шүүхээс хэлэлцэхгүй байхаар шийдвэр гарсан эсхүл материаллаг эрх зүйн нэхэмжлэлийн шаардлага хангагдаагүй улмаас хэргийг хэлэлцэхээргүй болсон шүүхийн шийдвэр гарсан бол - Албадан эмчлүүлэх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр авсан хүн
Шаардах хугацаа	Гэм буруугүйд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон талаар мэдсэнээс хойш 3 жил, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор	
Харьяалал	Гэм буруугүй шийдвэр гаргасан шүүхэд	
Олговрын хэмжээ	Яллагдагч болон түүний өмгөөлөгчийн шүүхийн шатанд гарсан зардал буюу тээврийн хөлс, өдрийн хөлс, орон байрны зардал, өмгөөлөгчийн хөлс зэрэг	<p><i>Хорих</i>- хоригдсон тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш хэмжээгээр өдрөөр тооцож нөхөн олговор олгоно.</p> <p><i>Цаазаар авах ял</i>- цаазаар авах ялын өмнө хоригдож байсан бол түүний хугацааг 1-т заасны дагуу олгож 30,000,000 вон хүртэл хэмжээгээр олгоно</p> <p><i>Торгууль</i>- төлсөн торгуулийн хэмжээгээр буцаан олгож, нөхөн олговор олгохоор шийдвэр гаргах хүртэлх хугацааг иргэний хуульд заасан хүүгээр тооцож олгоно.</p>

	Зардлын нөхөн барагдуулах	Эрүүгийн хэргийн нөхөн олговор
Гомдол гаргах арга	Шууд гомдол гаргана.	Нөхөн олговор олгох талаар шийдвэр гарснаас долоо хоногийн дотор гомдол гаргана, хэрвээ нөхөн олговор олгохоос татгалзсан шийдвэртэй холбогдуулан гомдол гаргах тохиолдолд шууд гаргана.

Мөн эрүүгийн хэргийн нөхөн олговор нь төрөөс олгох нөхөн олговрын шинжтэй төстэй шинж агуулж байдаг.

Хүснэгт 2. Нөхөн олговор

	Төрийн нөхөн олговор	Эрүүгийн хэргийн нөхөн олговор
Үндэслэл	Үндсэн хууль болон төрийн нөхөн олговрын тухай хууль	Үндсэн хууль болон эрүүгийн хэргийн нөхөн олговор болон нэр төрийг сэргээх тухай хууль
Зорилго	Төр болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хохирол барагдуулах хариуцлага, нөхөн олговрыг олгох үйл ажиллагааг тогтооход оршино.	Гэм буруугүй болох тухай шүүхийн шийдвэр авсан этгээдэд зохих ёсоор нөхөн олговор олгох, нэр төрийг сэргээхэд оршино.
Шалгуур	Төр болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан санаатай, болгоомжгүй үйл ажиллагааны улмаас хууль тогтоомж зөрчиж бусдад хохирол учруулсан тохиолдолд	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруугүй болох тухай шийдвэр авсан эсхүл прокурор шүүхэд хэргийг шилжүүлээгүй, мөрдөгч прокурор луу хэргийг шилжүүлээгүй тохиолдолд
Нотлох үүрэг	Төр болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын санаатай эсхүл болгоомжгүй үйл ажиллагааны улмаас болсон талаар нотлох үүрэгтэй.	Нотлох үүрэг хүлээхгүй.

• **Эрүүгийн хэргийн нөхөн олговор олгох шалгуур**

Эрүүгийн нөхөн олговор авахын тулд дараах шалгуур хангагдсан байх ёстой. Үүнд, 1) гэм буруугүйд тооцох тухай шийдвэр гарч уг шийдвэр хүчин төгөлдөр болсноор нөхөн олговор авах эрх үүснэ. 2) сэжигтний хувьд хоригдож байсан этгээдийн дундаас прокурорын зүгээс хэргийг шүүхэд шилжүүлээгүй эсхүл мөрдөн шалгагчаас хэргийг прокурор лүү шилжүүлэхгүй шийдвэр авсан этгээдэд нөхөн олговрыг олгоно. Энэ тохиолдолд бодит байдал дээр гэмт хэрэг үйлдээгүй болохыг хүлээн зөвшөөрөхүйц илт үндэслэл байгаа эсхүл хоригдсоноос хойш прокуророос шүүхэд хэргийг шилжүүлэхгүй байх тодорхой үндэслэл байгаа тохиолдол юм.

Эрүүгийн хэргийн нөхөн олговор олгохоос татгалзах үндэслэлийг сэжигтэн, ялагдагчаар ангилж дараах байдлаар үзэх боломжтой.

1. Яллагдагч- 1) тухайн этгээд гэмт хэргийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, бие махбод, сэтгэцийн өвчний улмаас гэм буруугүйд тооцсон бол 2) яллагдагч мөрдөн шалгах ажиллагаа болон шүүхийн ажиллагаанд саад учруулах зорилгоор худал мэдүүлэг өгсөн, хуурамч нотлох баримтыг зориуд бий болгосон нь тогтоогдсон 3) хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүхээс хэлэлцэж байсан бөгөөд аль нэг гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон бол шүүх өөрийн санаачилгаар нөхөн олговор олгохоос татгалзаж болно.
2. Сэжигтэн- 1) мөрдөн шалгах ажиллагаа болон шүүхийн ажиллагаанд саад учруулах зорилгоор худал мэдүүлэг өгсөн, хуурамч нотлох баримтыг зориуд бий болгосон нь тогтоогдсон 2) нөхөн олговор олгох нь нийтийн зан ёсны суртахууныг илт зөрчихөөр бол нөхөн олговор олгохоос татгалзаж болно.

Хоригдсон тохиолдолд тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш хэмжээгээр өдрөөр тооцож нөхөн олговор олгоно. Харин шүүх нөхөн олговрын хэмжээг тогтоохдоо ямар төрлийн хоригдох арга хэмжээ авсан, хугацаа, уг хугацаанд үүссэн эд хөрөнгийн хохирол, сэтгэл санааны болон бие махбодын хохирол, цагдаа болон прокурорын санаатай болон болгоомжгүй, буруутай

үйлдэл байгаа эсэх, шүүхийн алдаатай дүгнэлт зэрэг, тухайн этгээдийн гэм буруугүй болохыг шүүхээс дахин хэлэлцэх болсон гол үндэслэлийг харгалзаж тогтооно.

Хэрэв цаазаар авах ялтай холбогдуулан олгох нөхөн олговор нь өмнө хоригдож байсан бол түүний хугацааг 1-т заасны дагуу олгож 30,000,000 вон хүртэл хэмжээгээр бүхий л нөхцөл байдлыг харгалзаж үзсэний үндсэн дээр олгох бөгөөд нас барсны улмаас үүссэн эд хөрөнгийн хохирлын хэмжээ нотлогдсон бол үүнийг ч мөн барагдуулна.

Торгуулийн тухайд төлсөн торгуулийн хэмжээгээр буцаан олгож нөхөн олговор олгохоор шийдвэр гаргах хүртэлх хугацааг Иргэний хуульд заасан хүүгээр тооцож олгох ба эд хөрөнгийн хураан авах арга хэмжээний нөхөн олговрын хувьд хураан авсан эд хөрөнгийг буцаан олгон, буцаан олгох боломжгүй бол нөхөн олговор олгох үеийн тухайн эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд үндэслэн нөхөн олговор олгож, эд хөрөнгийн хураан авсны дараагийн өдрөөс нөхөн олговор олгох өдөр хүртэлх хугацаанд иргэний хуульд заасан хүүгийн хэмжээний дагуу хүүг олгоно.

4.7. ЯПОН УЛС

Японы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн 190-193 дугаар зүйлд “Прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлж, яллах ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж зааснаас гадна цагдаагийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг чиглүүлэн удирдахаас гадна хойшлуулшгүй арга хэмжээ авах тохиолдолд түүнийг хянаж зөвшөөрөл олгоно.

Цагдаагийн болон өөрийн илрүүлсэн мөрдөн байцаалтын хэргийн талаар яллах нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн 41 дүгээр зүйлд “... Өмгөөлөгч нь хуулийн тусгайлан олгогдсон эрхийн дагуу бие даан өмгөөллийн үйл ажиллагаа явуулна” гэж заажээ.

Өмгөөлөгчид хуулиар олгогдсон эрхэд нотлох баримтыг цуглуулах, өөрийн биеэр хэргийн газрын үзлэгт оролцох, үзлэгийн газар дээрээс

зураг авах, яллагдагчийг байцаахад зарим үед байлцах, гэрч нараас асуулт асуух, шинжээчтэй уулзаж ярилцах зэрэг эрхээр хангагдсан байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн 298.1 дүгээр зүйлд: “Прокурор, шүүгдэгч, өмгөөлөгч нь нотлох баримтыг шүүхээр шинжлэн судлуулахаар хүсэлт гаргах эрхтэй” гэж заасан нь гэрчийг шүүх хуралд дуудан ирүүлж байцаах, бичгийн болон эд мөрийн баримтад шинжилгээ хийсэн дүгнэлт танилцуулах, нотлох баримт хангагдаагүй нөхцөл байдлыг илрүүлэх зэргээр талуудын идэвхтэй ажиллагаагаар дамжин явагдана. Японы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт, нотолгоог хангах шалгуурыг оновчтой болгох, мөрдөн шалгах ажиллагаан дахь байцаалт, таньж олуулах болон мэдүүлэг гаргуулах ажиллагааг дүрс бичлэгээр заавал бэхжүүлж, ил тод нээлттэй болгох, улмаар тухайн мэдүүлгэн нотлох баримт нь нотлох чадвартай эсэхийг шүүх дээр бодитойгоор үнэлэх зэргээр хэд хэдэн реформын шинжтэй шинэчлэл, өөрчлөлт хийгдсэн билээ. Японы эрүүгийн шүүх хуралдаан Америкийн шүүхийн чөлөөт мэтгэлцээний зарчмыг ихэнх агуулгаар тусгаж, шүүн таслах ажиллагааны бүхий л үйл явцад уг зарчим сонгогдог утгаар хэрэгждэг гэж үзэж болно. Мөрдөн байцаалтыг явуулах үед хууль зөрчих, зүй бус арга хэрэглэхээс урьдчилан сэргийлэхийн тулд Японд байцаалт явагдсаныг ил тод болгох зорилгоор дүрс бичлэгийн бүх үйл явцыг хамруулан бэхжүүлэн авч байх журмыг мөрдүүлж эхлээд байна.¹⁶⁷

¹⁶⁷ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2015 он, 145-147 дахь тал

ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Олон улсын хүний эрхийн баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөгөө Монгол Улсын иргэн баталгаатай эдлэхэд мэргэжлийн өмгөөлөгчийн оролцоо чухал шаардлагатай юм. Гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэн боловч хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхээ баталгаатай эдлэхэд хууль зүйн баталгааг хангаж чадах процессын эрх, механизм зайлшгүй шаардлагатай байна.

ЭХХША-нд оролцож иргэний эрхийг хамгаалах өмгөөлөгчийн эрх, оролцоо нь иргэний эрхийг баталгаатай, тууштай хамгаалах хэмжээнд биш байгааг ЭХХША-нд оролцож буй иргэд байнга илэрхийлсээр ирсэн. Нөгөө талаар ЭХХША-нд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн иргэний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий өмгөөлөгчийн эрх, оролцоо, яллах чиг үүрэгтэй оролцож буй прокурорын эрх, оролцоотой харьцуулбал тэнцвэргүй, ялгаатай, яллах тал илт давуу байдалтай байгаа шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, буруутгах, яллах хандлага практикт илүү давамгайл байдалтай байна. Иймд иргэний үндсэн эрх болох шударгаар шүүгдэх эрхээ иргэн нь өөрийн сонгосон өмгөөлөгчөөр дамжуулан ЭХХША-нд оролцож буй тул өмгөөлөгчийн эрх, оролцоог бодитой, үр нөлөөтэй өөрчлөх, өмгөөлөгчийн процессын эрхийг хангах, олон улсын жишигт ойртуулах, олон улсын механизмтай холбох шинэчлэх шаардлага бодитой тулгарч байна.

Гадаадын зарим улс орны Үндсэн хуулиудад хүний халдашгүй байх эрх, шударгаар шүүгдэх эрх, хууль зүйн баталгааг процессын харилцаатай, сөрөг үр дагаврыг хязгаарласан хэлбэрээр нарийвчлан зохицуулсан байгаа нь дэвшилтэй байна. Олон улс оронд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалах суурь зарчим, жишиг, хэм хэмжээ баттай тогтож, өмгөөлөл, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй ашиглагдаж байна. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож иргэний эрхийг хамгаалахад судлан хэрэгжүүлэх шаардлагатай олон

сайн жишиг байна. Олон улс орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг жишиг, практикт мэтгэлцээний хоёр тал болох өмгөөлөгч, прокурорын эрх мэдлийг өрсөлдөхүйц байлгах, харилцан хяналт, тэнцвэртэй болгох талаар ихээхэн дэвшил, өөрчлөлт гарчээ.

Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл нь сэжигтэн, яллагдагчийн Үндсэн хуулиар баталгаатай эдлэхээр заасан үндсэн эрх болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шударгаар шүүгдэх бүлэг эрхийг баталгаатай эдлүүлэх, үндсэн эрхийг үр дүнтэй хамгаалах, хүний эрхийг хамгаалагч өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг бодитой бүрдүүлэх, яллах, өмгөөлөх талын мэтгэлцээн, оролцооны эрх тэгш байдлыг хангах, нотлох процессын шинэчлэлд төвлөрөх нь практик ач холбогдолтой юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим болох нотолгооны цогц шинжийг хангах, тэнцвэртэй бөгөөд харилцан шалгах зарчим (Cross-examination), мөрдөн мөшгих ба яллах чиг үүргийг ялган зааглах зарчим, шударгаар шүүгдэх, шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх зарчим, эрүүдэн шүүхээс ангид байдлаар мэдүүлэг гаргуулах зарчим, шүүх хуралдааныг мэтгэлцээний үндсэн дээр нээлттэй хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зарчмыг манай хуулийн практикт үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хараат бус шүүх нь хүний эрхийг хүндэтгэж хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд дотоод итгэл үнэмшлийг удирдлага болгож хэргийг шийдвэрлэдэг, хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй.

Хуулиар тэгш хамгаалуулах эрх гэдэг нь хуулиар ялгаварлан гадуурхах болон эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд хуулийг хэрэгжүүлэхдээ ялгаварлан гадуурхахыг хориглодог. Ялгаварлан гадуурхалт гэдэг нь аливаа харьцааны бүх ялгаатай байдлыг биш харин объектив, үндэслэлтэй шалгуурт тулгуурлаагүй, хууль ёсны зорилгыг хангахад чиглээгүй, түүнд нийцээгүй ялгааг л ойлгоно. Энэ нь шүүгч, прокурор, хууль сахиулах ажилтнууд нь хуулийн тэгш хамгаалалтыг хангаж, ялгаварлан гадуурхалтын хориглолтыг хүндэтгэн, хамгаалах үүрэгтэй гэсэн үг юм.

НҮБ-ын Загвар хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөлийг хангахад нотолгоог хэрэгжүүлэгч субъектийн эрх хэмжээ, үйл ажиллагаа нь давхардалгүй, хүнд сурталгүй, харилцан уялдсан, шуурхай бөгөөд тэнцвэртэй байх ёстойг тайлбарлажээ.

Загвар хуулийн агуулгаас үзэхэд орчин үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоо нь аль нэг системд хамаарагдана гэхээсээ илүү, тухайн салбарт шинэчлэл хийхдээ аль алиных нь үнэт зүйлс, сонгодог өв соёлыг хослуулан зохистойгоор рецепци хийх замаар хүлээн авах нь түгээмэл хандлага болж байна. Иймд энэхүү судалгааны ажилд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл нь сэжигтэн, яллагдагчийн Үндсэн хуулиар эдлэхээр заасан үндсэн эрх болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шударгаар шүүгдэх бүлэг эрхийг эдлүүлэх, үндсэн эрхийг үр дүнтэй хамгаалах, хүний эрхийг хамгаалагч өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг бодитой бүрдүүлэх, яллах, өмгөөлөх талын мэтгэлцээн, оролцооны эрх тэгш байдлыг хангах, нотолгооны процессын шинэчлэл чухал юм.

Хүний эрхийг хамгаалах мэргэжлийн чиг үүргийг гүйцэтгэж буй өмгөөлөгчийн байр суурь, оролцоо нь ЭХХША-ны зорилгыг хэрэгжүүлэхэд “дэмжлэг үзүүлэх чиг үүрэг”-ийн хүрээнд “хүсэлт, гомдол гаргах”-аас өөр оролцооны механизм байдаггүй. Иймд өмгөөлөгчийн ЭХХША-нд оролцож буй өнөөгийн эрх зүйн байдал, оролцоо, эрхийн асуудалд бодитой дүгнэлт хийж, өөрчлөх шинэчлэх шаардлага зайлшгүй хийгдэх нь цаг үеэ олсон асуудал гэж дүгнэж байна. Өмгөөлөл бол нотолгооны процесс, ЭХХША-ны мэтгэлцээний нэг гол оролцогч тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тэнцвэрийг хангахад чухал. Өмгөөлөгчийн эрх зүйн байдал, байр суурь, эрх, оролцоог яллах чиг үүрэгтэй оролцож буй прокурорын эрх, оролцоотой уялдуулж, хүний эрхийг хангах тэнцвэрийг хангахаар өмгөөлөх чиг үүргийг ЭХХШТХ-ийн хуулийн зорилгод багтааж, эрүүгийн хэргийн мэтгэлцэх зарчмыг зөвхөн

шүүхийн шатанд биш, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлж, өмгөөлөгчийг ЭХХША-нд үр дүнтэй оролцуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.

2. Эрүүгийн хосолсон процесс буюу хосолсон систем нь орчин үед шинээр хөгжиж буй загвар, хандлага бөгөөд манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг загварын зарим хэлбэр, зарчим нэвтэрч байгаа ч дутуу судалсан, дутагдалтай тал цөөнгүй ажиглагдлаа. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа загвар систем нь хэргийн хувь заяа нь мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслах ажиллагаа явагддаг, шүүхээс өмнө мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байх ба өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал байгаагаас хүний эрхийн зөрчил, маргаан цөөнгүй дагуулж байна, уг тогтолцоо, системийн сөрөг, дутагдалтай талыг даван туулах зайлшгүй шаардлага бодитой бий болжээ гэж дүгнэж байна. Сүүлийн жилүүдэд үндэсний болон олон улсын эрх зүйн тогтолцооны харилцан хамаарал, нөлөөлөл улам гүнзгийрч, улс орон бүхэнд шинэ нөхцөлд нийцсэн эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлага бий болжээ.

3. БНСУ-д нотлох баримтыг оролцогчид зөвхөн шүүх дээр үнэлүүлэх шинэ дэг журам тогтоосон, өмгөөлөгчийн эрхийг өргөжүүлж, түүний баталгааг хангасан, нотолгооны бүх үйл явцыг стандарт, журамтай болгосон, прокурорын шийдвэрт гомдол гаргах нөхцөл, журмыг шинээр хуульчлах зэргээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл хийсэн нь үр өгөөжтэй байна.

Ялангуяа нотлох ажиллагаанд нотлох баримтын нотолгооны хүчин чадлыг чөлөөтэй шинжилж үнэлэх зарчим амжилттай хэрэгжихээс гадна шүүхийн урьдчилсан сонголт, хэлэлцүүлэг буюу шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг. Энэ нь шүүхийн үр дүнтэй ажиллагааг явуулах зорилгоор прокурор, сэжигтэн яллагдагч эсхүл өмгөөлөгчийн хүсэлтэд үндэслэн шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн гол агуулга болон нотлох баримтыг хянах ажиллагаанд төвлөрч байна. Уг шинэчлэл нь шүүхэд бүх ажиллагааг төвлөрүүлэхийн тул урьд нь бичмэл нотлох

баримтад үндэслэн шийдвэрлэдэг байсныг мэтгэлцээний зарчим болгон өөрчилсөнтэй холбоотой бөгөөд яллах дүгнэлт нь нотлох баримттай нийцэж байгаа, талуудын санааг шалгах ажиллагаа юм. Уг хугацаа нь 3 сар хүртэл байхаар зааж, урьдчилсан хэлэлцүүлэг илүү ач холбогдол өгч байна. Иймд БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл, сайн туршлагыг Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэчлэхэд ашиглах шаардлагатай.

4. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл нь сэжигтэн, яллагдагчийн Үндсэн хуулиар баталгаатай эдлэхээр заасан үндсэн эрх болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шударгаар шүүгдэх бүлэг эрхийг эдлүүлэх, үндсэн эрхийг үр дүнтэй хамгаалах, хүний эрхийг хамгаалагч өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг бодитой бүрдүүлэх, яллах, өмгөөлөх талын мэтгэлцээн, оролцооны эрх тэгш байдлыг хангах, нотлох процессын шинэчлэл чухал байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт “Яллагдагчийн эрх үүргийг тодорхой хуульчилсан боловч шүүгдэгчийн эрх зүйн байдалтай хольж хутган ойлгомжгүй байдлаар хуулийн зохицуулалт хийсэн нь өмнөх Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас ухралт хийсэн байх бөгөөд цаашид яллагдагчийн эрх үүрэг, шүүгдэгчийн эрх үүргийг хуулиар тусгаарлаж, нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

5. Өмгөөлөгчийн хуулиар олгогдсон эрх болох хэргийн материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж хувилж авах эрхийг бодитой хэрэгжүүлэх талаар дорвитой өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагатай. 21 дүгээр зуунд техник, мэдээлэл технологийн эрэн үед ухаалаг гар утас зэрэг төхөөрөмжийг ашиглан цаг хугацаа, зардлыг хэмнэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах үүднээс холбогдох байгууллагын удирдлагуудын түвшинд харилцан ойлголцох, хуулиас дээгүүр үйлчилж буй дүрэм, журам зааврыг өөрчлөн хүчингүй болгох зэрэг шинэчлэлтийг хийх нь зүйтэй. Тухайлбал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2-ын өмгөөлөгчийн эдлэх эрх гэсэн хэсгийн 2.9-д заасан “... Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах” гэсэн зохицуулалтыг “... мөрдөн шалгах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад тохиолдолд хэрэгт цугларсан нотлох баримтыг тухай бүрт нь өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, хэргийн бүх материалтай танилцаж байх” гэж өөрчлөн найруулах боломжтой.

6. Мөрдөн байцаалтын шатанд зөвхөн шинжээчийн дүгнэлттэй танилцуулж бусад хэрэгт авагдсан аливаа баримтат мэдээллийг танилцуулдаггүй нь өмгөөлөгчийг ажиллах боломжийг алдагдуулж тодорхой мэдээлэлгүй, таамгаар үйл ажиллагаа явуулахад хүргэдэг. Иймд өмгөөлөгч мөрдөн байцаалтын үйл ажиллагааны нууцыг алдагдуулахгүй гэсэн баталгаа гаргасан тохиолдолд хэргийн материалтай танилцах боломжийг хуулиар нээж өгөх нь оновчтой. Хэрэв өмгөөлөгч мөрдөн байцаалтын нууцыг задруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.9 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх учир задруулах асуудал гарахгүй байх боломжтой.

7. Хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг гэрчээр дуудаж гэрчийн хувьд мэдүүлэг авсны дараа яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг үүсгэх явдал түгээмэл байна. Гэрч нь тухайн хэрэгт холбогдолгүй этгээд байх ёстой гэсэн шаардлагыг үл харгалзан өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуульд баталгаажуулсан эрхийг нь зөрчиж мэдүүлэг авдаг, дараа нь гэрчээр өгсөн мэдүүлгийг нь үзүүлж дарамтлах, түүнийг нь шүүх хуралдаан дээр ашиглах зэрэг хүний эрхийг зөрчих явдал хавтгайрах шинжтэй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6-д “... Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй” гэж заасан ч ихэнх тохиолдолд хуульд заасан эрхээ мэддэггүйгээс

хойшлуулшгүйгээр өмгөөлөгчгүй мэдүүлэг өгөх эрх нь зөрчигдсөөр байгааг цаашид анхаарч сэжигтнээр тооцож мэдүүлэг авдаг байсан өмнөх хуулийн жишгийг сэргээх шаардлагатай гэж үзэж байна.

8. Хүний эрхийг хангахад хуульчийн ажил, мэргэжил чухал үүрэгтэй. Хуульчийн ажил мэргэжлийн хараат бус, бие даасан байдлыг хангахгүйгээр хүний эрхийг хамгаалах боломжгүй бөгөөд шударга ёсыг тогтооход хараат бус, бие даасан шүүгчээс гадна хараат бус, бие даасан байдал нь баталгаажсан өмгөөлөгч чухал үүрэгтэй. Өмгөөлөгч нь хууль дээдлэх ёс, хүний эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх чөлөөг дэмжих шаардлагатай.

9. Өмгөөлөгч нь бусад иргэдийн нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаанд оролцох эрхтэй. Ялангуяа, хууль тогтоомж, шүүн таслах ажиллагаа, хүний эрхийг хамгаалах ба дэмжих тухай асуудлуудыг олон нийтээр хэлэлцэхэд оролцох ба хууль ёсны байгууллагын гишүүн болсон, эсхүл хууль ёсны үйл ажиллагаанд нь оролцсон гэсэн үндэслэлээр мэргэжлийн хязгаарлалтгүйгээр олон улсын, үндэсний, орон нутгийн байгууллагуудад эвлэлдэн нэгдэх, тэдгээрийг үүсгэн байгуулах эрхтэй. Эдгээр эрхийг эдлэхдээ өмгөөлөгч нар хууль ёс, хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд, мэргэжлийнхээ ёс зүйг ямагт баримтлах ёстой гэсэн зарчмыг тууштай дэмжих, уг эрхээ эдэлсэн өмгөөлөгч нарт ирж шахалт, дарамтыг зогсоох шаардлагатай.

10. Өмгөөлөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харилцаанд идэвхгүй оролцогч биш харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектийн нэг бөгөөд нотлох баримтыг цуглуулах, шалгахад оролцох эрх эдлэхээс гадна шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэх хуралдаанд мэтгэлцээний нэг /цагаатгах/ талыг төлөөлж оролцох, ингэхдээ шүүхийн процесст тодорхой эрхтэйгээр /асуулт асуух, нотлох баримтыг шинжлэн судлах, баримт сэлт гаргаж өгөх/ өмгөөлөл явуулах статустай байх явдал цаашдын хөгжлийн явцад бий болж төлөвших хандлагатай байгаа тул энэ хандлагыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрүүлэх нь зүйтэй.

11. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны загвар систем нь хэргийн хувь заяа нь мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслах ажиллагаа явагддаг, шүүхээс өмнөх мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байх ба өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал шинжтэй байгаагаас хүний эрхийн зөрчил, маргаан цөөнгүй дагуулж байна, уг тогтолцоо, системийн сөрөг, дутагдалтай талыг даван туулах зайлшгүй шаардлага бодитой бий болжээ.

12. БНСУ-д нотлох баримтыг оролцогчид зөвхөн шүүх дээр үнэлүүлэх шинэ дэг журам тогтоосон, өмгөөлөгчийн эрхийг өргөжүүлж, түүний баталгааг хангасан, нотолгооны бүх үйл явцыг стандарт, журамтай болгосон, прокурорын шийдвэрт гомдол гаргах нөхцөл, журмыг шинээр хуульчлах зэргээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл хийсэн нь үр өгөөжтэй байна. Ялангуяа нотлох ажиллагаанд нотлох баримтын нотолгооны хүчин чадлыг чөлөөтэй шинжиж үнэлэх зарчим амжилттай хэрэгжиж байна.

13. БНСУ-д шүүхийн урьдчилсан сонголт, хэлэлцүүлэг буюу шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг нь шүүхийн үр дүнтэй ажиллагааг явуулах зорилгоор прокурор, сэжигтэн ба түүний өмгөөлөгчийн хүсэлтэд үндэслэн шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн гол агуулга болон нотлох баримтыг хянах ажиллагаанд төвлөрч байна. Энэхүү шинэчлэл нь шүүхэд бүх ажиллагааг төвлөрүүлэхийн тул урьд нь бичмэл нотлох баримтад үндэслэн шийдвэрлэдэг байсныг мэтгэлцээний зарчим болгон өөрчилсөнтэй холбоотой бөгөөд яллах дүгнэлт нь нотлох баримттай нийцэж байгаа, талуудын санааг шалгах ажиллагаа юм. Иймд БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэчлэл, сайн туршлагыг Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэчлэхэд ашиглах шаардлага байна.

14. Бодит байдал дээр ЭХХША гэдэгт эрүүгийн хэрэг бүртгэх, шалгах, хянан хэлэлцэх, шийдвэрлэх чиг үүргийг хамруулан ойлгож байх бөгөөд ЭХХША-нд өмгөөлөх чиг үүргийг тусгайлан авч үзээгүй

байна. Үүнтэй холбоотойгоор ЭХХША-ны үндсэн оролцогч гэдэгт шүүх, прокурор, мөрдөгчийг хамруулан авч үзэж, өмгөөлөгчийг “гэрч, шинжээч, мэргэжилтэн” зэрэгтэй адил өвөрмөц чиг үүрэгтэй субъект гэж үзэх хандлага хүчтэй оршсоор байгаа болно. Уг үзэл, байр суурийг үзэл баримтлал, хандлагын хувьд өөрчлөх, шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Хүний эрхийг хамгаалах мэргэжлийн чиг үүргийг гүйцэтгэж буй өмгөөлөгчийн байр суурь, оролцоо нь ЭХХША-ны зорилгыг хэрэгжүүлэхэд “дэмжлэг үзүүлэх чиг үүрэг”-ийн хүрээнд “хүсэлт гаргах”-аас өөр оролцооны механизм дутмаг байна.

Иймд өмгөөлөгчийн ЭХХША-нд оролцож буй өнөөгийн эрх зүйн байдал, оролцоо, эрхийн асуудалд бодитой дүгнэлт хийж, өөрчлөх шинэчлэх шаардлага үүсжээ. Өмгөөлөл бол нотолгооны процесс, ЭХХША-ны мэтгэлцээний нэг гол оролцогч тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тэнцвэрийг хангахад чухал юм. Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа, өмгөөллийн үйлчилгээ авах иргэдийн хэрэгцээ шаардлага, хүлээлт бодит амьдрал дээр өндөр байгаа бөгөөд харин өмгөөлөгчийн хуулиар эдэлж буй эрх, оролцоо энэхүү иргэдийн хүлээлт, шаардлагыг хангаж чадахгүй байна.

15. Монгол Улсын Үндсэн хуульд “... гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”¹⁶⁸ гэсэн зарчмыг ЭХХШтХ-д улам бүр тодотгон “шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй”¹⁶⁹ гэж заасан бөгөөд аливаа хэргийг эцэслэн шийдвэрлэдэг шинж чанараараа шүүх засаглалын мөн чанарыг илэрхийлдэг. Хараат бус шүүх нь хүний эрхийг хүндэтгэж хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд дотоод итгэл үнэмшлийг удирдлага болгож хэргийг шийдвэрлэдэг. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй байна.

¹⁶⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг. Төрийн мэдээлэл УБ., 1992, №1

¹⁶⁹ ЭХХШтХ-ийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл. УБ., 2017, №23

Хуулиар тэгш хамгаалуулах эрх гэдэг нь хуулиар ялгаварлан гадуурхах болон эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд хуулийг хэрэгжүүлэхдээ ялгаварлан гадуурхахыг хориглодог. Ялгаварлан гадуурхалт гэдэг нь аливаа харьцааны бүх ялгаатай байдлыг биш харин объектив, үндэслэлтэй шалгуурт тулгуурлаагүй, хууль ёсны зорилгыг хангахад чиглээгүй, түүнд нийцээгүй ялгааг л ойлгоно. Энэ нь шүүгч, прокурор, хууль сахиулах ажилтнууд нь хуулийн тэгш хамгаалалтыг хангаж, ялгаварлан гадуурхалтын хориглолтыг хүндэтгэн, хамгаалах үүрэгтэй гэсэн үг юм.

16. Манай улсын өнөөгийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа яллах мөн чанартай байгаа тул мөрдөгч болон прокурор, өмгөөлөгчөөс гаргаж өгч байгаа баримт сэлт, мэдээллийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй, нотлох баримт цуглуулах талаар гаргасан үндэслэл бүхий хүсэлтийг хүлээн авдаггүй, хүсэлтийг хангахаас татгалзах, мөн иргэн, хуулийн этгээдээс тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авахаар хандахад тэр бүр зөвшөөрдөггүй зэргээр нотлох ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо бага, саад бэрхшээл ихтэй байна.

17. Хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг гэрчээр дуудаж гэрчийн хувьд мэдүүлэг авсны дараа яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг үүсгэх явдал түгээмэл байна. Гэрч нь тухайн хэрэгт холбогдолгүй этгээд байх ёстой гэсэн шаардлагыг үл харгалзан өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуульд баталгаажуулсан эрхийг нь зөрчиж мэдүүлэг авдаг, дараа нь гэрчээр өгсөн мэдүүлгийг нь үзүүлж дарамтлах, түүнийг нь шүүх хуралдаан дээр ашиглах зэргээр хүний эрхийг зөрчих явдал хавтгайрах шинжтэй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6-д “...Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй” гэж заасан ч ихэнх тохиолдолд хуульд заасан эрхээ мэддэггүйгээс хойшлуулшгүйгээр өмгөөлөгчгүй мэдүүлэг өгч эрх нь зөрчигдсөөр байгааг цаашид анхаарч сэжигтнээр тооцож мэдүүлэг авдаг байсан өмнөх хуулийн жишгийг сэргээх шаардлагатай.

18. Хуульчийн нийгэмд гүйцэтгэх үүрэг бол өргөн хүрээтэй бөгөөд зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх аль нэг ажиллагаагаар хязгаарлагдахгүй юм. Иймд хуульч нь нийгмийн инженерийн хувьд нийтийн эрх ашиг, олон нийтийн төлөө хүний эрхийг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж байдаг. Хуульч, өмгөөлөгч бол хүний эрхийг хамгаалагчийн хувьд өмгөөлөгчийн хууль зүйн баталгаа, мэргэжлийн үйл ажиллагааны эрх, оролцоог шинэ шатанд гаргах шаардлагатай юм.

19. Өмгөөлөгчийн эрх зүйн байдал, байр суурь, эрх, оролцоог яллах чиг үүрэгтэй оролцож буй прокурорын эрх, оролцоотой уялдуулж, хүний эрхийг хангах тэнцвэрийг хангахаар өмгөөлөх чиг үүргийг ЭХХШТХ-ийн хуулийн зорилгод багтааж, ЭХХШТХ-д өмгөөлөгчийг ЭХХША-ны процесст үр дүнтэй оролцуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Прокурорын тогтолцоог хүний эрхийг хангах хүрээнд шинэчлэл хийх, прокурорын мэргэжлийн болон захиргааны удирдлагыг салгах, прокурорын бие даасан байдлыг хангах, прокурорын шийдвэрт шүүхийн хяналтыг сайжруулах, гэм буруугийн асуудлыг прокурорт бус, шүүхийн эрх мэдэлд төвлөрүүлэх асуудлыг судлах шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002.
3. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2007.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
5. Өмгөөллийн тухай хууль, 2002.
6. Өмгөөллийн тухай хууль, 2019.
7. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2020.
8. Өмгөөллийн тухай хууль, 2019.
9. БНСУ-ын Үндсэн хууль, 1948.
10. БНСУ-ын иргэний хэрэг хянан шийдвэрлэж ажиллагаанд цахим бүхий бичиг баримтыг ашиглах тухай хууль, 2010.
11. БНСУ-ын хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэргийн цахим бичиг баримтын тухай хууль, 2010.
12. БНСУ-ын цахим бичиг баримт болон цахим арилжааны ерөнхий хууль, 1999.
13. БНСУ-ын цахим гарын үсгийн тухай хууль, 1999.
14. БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим бүхий бичиг баримтыг ашиглах тухай хууль, 2021.
15. БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахад хөхүүлэн дэмжих тухай хууль, 2020.
16. БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1954.
17. БНСУ-ын эрүүгийн хэргийн нөхөн олговор болон нэр төрийг сэргээх тухай хууль, 1959.
18. БНСУ-ын ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх болон ялтны тухай хууль, 1950.
19. БНСУ-ын өмгөөллийн тухай хууль, 1949.
20. БНСУ-ын прокуророос улсын өмгөөлөгчийг томилох тухай журам, 2012.
21. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны

шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 1-ны өдрийн №2020/
ЗШ/1237 Шийтгэвэр

22. Нийслэлийн Прокурорын газрын прокурорын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 57 тоот тогтоол

НОМ, СУРАХ БИЧИГ

1. Ж.Амарсанаа, “Хүний эрх. Олон Улсын ба Үндэсний эрх зүйн асуудал” УБ., 2000.
2. Д.Баярсайхан, Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал, УБ., 2012.
3. Х.Нямбаатар, Л.Батжав, Т.Оюунчимэг, Ч.Нямсүрэн, Б.Цолмон, Р.Баярмагнай ... Ч.Отгонсүрэн, Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2020.
4. Ханнс Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжлэх ухааны тайлбар, УБ., 2003.
5. БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, УБ., 1987.
6. Шүүн таслах ажиллагааны мэтгэлцээн, гарын авлага, УБ., 2004.
7. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл (Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй), УБ., 2012.
8. Өмгөөлөл судлал 1-р боть, УБ., 2011.
9. МУИС, ХЗС, У.Хүрэлсүх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах шаардлага, арга зам, Хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, УБ., 2019.
10. Д. Баярсайхан “Өмгөөлөл ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” УБ., 2015.
11. Г.Наранбаатар “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь” УБ., 2006.
12. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсэн асуудал” УБ., 2018.
13. Г.Наранбаатар “Өмгөөлөл хууль зүйн туслалцаа” УБ., 2020.
14. Ц.Доржням, Г.Наранбаатар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй” УБ., 2022.

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР, ПАКТ, КОНВЕНЦ

- НҮБ. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт. 1966 он.
- Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах цогц зарчмуудын тухай конвенц. 1988 он.
- НҮБ-ын Эрүү шүүлтгийн эсрэг комиссын зөвлөмж, мэдэгдэл. Европын Хүний эрхийн хороо
- Хуулийг гүйцэтгэн хэрэгжүүлэх албан тушаалтан зан үйлийн тухай” конвенц. 1979 он.
- Өмгөөлөгчдийн ажил, үүргийн талаарх үндсэн зарчим” тухай конвенц. 1990 он.
- “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” конвенц. 2000 он.
- Хүүхдийн эрхийн конвенц. 1990 он.

СОЛОНГОС ХЭЛ ДЭЭР ЭХ СУРВАЛЖ

1. 정동윤 등, [민사소송법], 제5판, 2016
2. 이창현, 형사소송법, 2020
3. 강병훈, “변호인의 조력을 받을 권리”, 『형사소송 이론과 실무』, 형사소송법학회(2009)
4. 기우중. 訴訟의 새로운 틀 “電子訴訟”. 저스티스, 170-201. 2010
5. 김정연. (2019). 형사절차에서 변호인의 ‘효과적인’ 조력을 받을 권리의 보장. 헌법학연구, 25(4), 1-36.
6. 류부곤. 형사전자소송의 현황과 미래. 비교형사법연구. 2017;
7. 박혜림, “변호인의 조력을 받을 권리의 현황 및 개선과제”, NARS 현안분석 vol.53, (2019)
8. 송광섭. 약식명령절차에서의 몇 가지 논쟁, 그 이용 현황과 개선방안. 형사법의 신동향. 2013; 40 176-226.
9. 신이철 “피고인·피의자의 접견교통권에 대한 올바른 해석과 입법적 제언” 형사법의 신동향 66 pp.41-80 (2020)
10. 이형근, 조은경, 이미선. “수사관의 심증이 조서의 왜곡에 미치는 영향.” 한국심리학회지: 법 11.3 (2020):

11. 이형근, 조은경, 이미선. "수사관의 심증이 조서의 왜곡에 미치는 영향." 한국심리학회지: 법11.3(2020):267-285.
12. 장승일. "형사절차상 범죄피해자 권리보호에 관한 연구." 법학연구 37. (2010): 217-235.
13. 천진호 (Jin Ho Chun). "제4회 중,한 형사소송법 학술대회 : 형사절차에서 변호인의 역할 제고 방안." 법학논총 28.4 (2011)
14. 형사 전자소송의 바람직한 발전방향. 사법정책연구원 연구총서. 2020:2020(5):1-479.

БНСУ-ЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЖИШИГ ШИЙДВЭР

1. БНСУ-ын анхан шатны шүүхийн 1991.09.19. 91гадад24555 шийдвэр
2. БНСУ-ын дээд шүүхийн 1990.02.1389до37 тогтоол
3. БНСУ-ын дээд шүүхийн 1991.03.28 за 91до24 тогтоол
4. БНСУ-ын дээд шүүхийн 2003.01.10 선고 2002да56628 тогтоол
5. БНСУ-ын дээд шүүхийн 2013.04.26 за 2013ма4003 тогтоол
6. БНСУ-ын дээд шүүхийн 2014.12.22 за 2014да229016 тогтоол
7. БНСУ-ын үндсэн хуулийн шүүхийн 2017.11.30 선고 2016хнма 503 тогтоол
8. Хүний эрхийн хороо 2013.05.27 12жинг0456100 тогтоол

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. https://www.kics.go.kr/portal/jsp/popup/kics_brochure.jsp
2. <https://www.lawtimes.co.kr/Legal-News/Legal-News-View?serial=101700>
3. <https://legalinfo.mn/>
4. <https://nhrcm.gov.mn/>
5. <https://www.supremecourt.mn/>
6. <http://103.48.116.173/eruanhan>
7. <https://www.ama.org.mn/>
8. <https://www.mglbar.mn/>
9. <https://www.osce.org/files/f/documents/1/7/454269.pdf>
10. <https://www.medee.mn/p/169383>

